

## ХАМТДАА БЭХЭЖСЭН ЗУУН



Монгол Улсад орчин  
цагийн банкны салбар  
үүсэж, бэхэжсэний 100  
жилийн ойгоор  
“Хубилай хааны  
зарлиг”, “Хос луу”,  
“Монголбанк-100 жил”  
нэртэй дурсгалын зоос  
гаргалаа.







**Онцлох нийтлэл 04**  
Банк, санхүүгийн  
тогтолцооны "манаач"  
Монголбанк

**Түүхэн товчоон 06**  
Он цагийн хураангуй  
товчоон

**Онцлох ярилцлага 08**  
Б.Лхагвасүрэн: Банкны  
салбарын туулсан зам  
дардан байгаагүй ч одоо  
батжин бэхжээд байна

**"Банк-100" үзэсгэлэн 15**  
Монголбанк-100 жил",  
"Хубилай хааны зарлиг",  
"Хос луу" дурсгалын зоос  
мэндлэв

**Мөнгөний бодлого 18**  
Мөнгөний бодлогын  
шинэчлэл



**КОВИД-19 21**  
КОВИД-19 цар тахлын үеийн  
мөнгөний болон макро  
зохистой бодлого

**Мөнгөний шинэчлэл 24**  
Төлбөрийн хэрэгсэл, мөнгөн  
тэмдэгт шинэчлэгдэж ирсэн  
түүх

**Гадаад валют 27**  
Валютын ханшийн бодлого,  
нөөцийн удирдлага

**Үндэсний төлбөрийн  
систем 30**  
Дэвшилтэт технологид  
суурилсан үндэсний  
төлбөрийн систем

**Хяналт шалгалт 34**  
Банкны салбарт хийсэн  
"хувьсгалууд"



**Санхүүгийн мэдээлэл 34**  
Мөнгө угаах, терроризмыг  
санхүүжүүлэх тогтолцоо  
бэхэжсэн нь

**Судалгаа, шинжилгээ 40**  
Төв банкны судалгааны  
чанар сайжирсан он жилүүд

**Дурсамж 42**  
Д.Моломжамц:  
Ажилд орох үед  
гарааны нөхцөл туйлын  
хүнд байсан

**Монголбанкны ажилтнууд  
44**  
Монголбанк бидний  
бахархал

**ХААН БАНК 48**  
Эх дэлхийд ээлтэй, олон  
нийтэд нээлттэй ХААН Банк



**ГОЛОМТ БАНК 52**  
Дэлхийн жишиг  
ГОЛОМТ БАНК

**ХАСБАНК 54**  
Сайн засаглалыг  
түүчээлэгч ХасБанк

**ТӨРИЙН БАНК 56**  
Ө.Гантөр:  
Төрийн банкныг  
Дундаж давхаргыг  
дэмжигч үндэсний  
тэргүүлэгч банк гэж  
тодорхойлсон

**КАПИТРОН БАНК 60**  
Шинэ эриний үнэ цэнийг  
бүтээгч Капитрон банк

**Зураг түүх өгүүлнэ 62**



# Хамтдаа бэхэжсэн зуун байлаа



Монголбанкны Ерөнхийлөгч  
**Б.ЛХАГВАСҮРЭН**

Нэгэн зууныг ололт, амжилтаар түүчээлсэн Монгол Улсын орчин цагийн банкны салбарын 100 жилийн ой энэ онд тохиож байна. Тэртээ 1924 оны зургадугаар сарын 2-ны өдөр Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь банкны салбарын үүсэл төдийгүй, Монголбанкны суурь болсон юм.

Өнөөдөр банкны салбар нь үйлчилгээ, бүтээгдэхүүний нэр төрлөөр олон улсын жишигт хүрч хөгжин, дотооддоо үйлчилгээ, технологийн манлайлагч байж, санхүүгийн зуучлалыг тасралтгүй гүйцэтгэж, гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол тулгуур, тэргүүлэх салбар болж хөгжөөд байна. Өнгөрсөн зуун бол банкны салбар, эдийн засгийн хөгжил харилцан нэгнээ дэмжин, өргөжин тэлсээр ирсэн “ХАМТДАА БЭХЭЖСЭН ЗУУН” байлаа.

Зуун жилийн босгон дээр Монгол Улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт эерэг өөрчлөлт гарч байгааг дурдахад таатай байна. Монгол Улсын эдийн засаг 2024 оны нэгдүгээр улирлын байдлаар 7.8 хувийн өсөлттэй, инфляц Монголбанкны зорилтот түвшин рүү амжилттай буурлаа. Гадаад валютын нөөц анх удаагаа таван тэрбум ам.долларын босго давж, түүхэн

дээд түвшинд хүрлээ. Гадаад валютын нөөц нэмэгдсэнээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлж байна. Экспортын орлого нэмэгдэн урсгал тэнцэл сүүлийн 16 жилд анх удаагаа ашигтай гарч, төлбөрийн тэнцэл сайжрах нөхцөлийг бүрдүүллээ.

Банкны салбарын хувьд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, санхүүгийн зуучлалын үүргээ амжилттай хэрэгжүүллээ. Банкны реформ үргэлжилж, банкнууд хувьцаат компанийн хэлбэрт шилжсэний зэрэгцээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо дэлхийн жишигт нийцэн сайжирч, олон улсын хамтын ажиллагаанд идэвх чармайлт гаргасны үр дүнд корреспондент банкны харилцааг ахиулж, гадаад төлбөр тооцоог илүү үр ашигтай гүйцэтгэх боломж бүрдлээ.

Монголын эдийн засгийн энэхүү хөгжил дэвшлийг бүтээхэд манай банк, санхүүгийн салбарынхны оруулсан хувь нэмэр өндөр бөгөөд Монголбанк болон бусад бүх банкны удирдлага, ажилтан хамт олонд Монгол Улсад банк үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

Монгол Улсын банкны салбар зуунаас зуунд төгөлдөржин дэвших болтугай! ■



## Онцлох нийтлэл

# Банк, санхүүгийн тогтолцооны "манаач" Монголбанк

1994 онд  
банкнуудын  
үйл  
ажиллагааг  
Монголбанк  
бүрэн  
хяналтад  
авч, үнийн  
өсөлтийг  
тогтвортой  
бууруулж  
эхлэв



**М**онгол Улсад орчин үеийн банк санхүүгийн систем үүсэж, хөгжөөд 100 жилийн босгыг алхаж байна. Энэ салбарт хоёргүй сэтгэлээр зүтгэсэн банк санхүүгийн олон мянган ажилтны хувьд хийсэн бүтээснээрээ бахархах, олон түмэндээ тайлагнах, өнгөрснөө дүгнэх, одоог бүтээх, ирээдүйг төлөвлөх цаг мөч тохиож байна.

Тэртээ 1924 оны зургадугаар сарын 2-ны өдөр Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк байгуулагдсанаас 100 жилийн дараа нарлаг сайхан зуны улиралд банк санхүүгийн салбарынхан түүхэн ойгоо тэмдэглэн өнгөрүүлж байна. Банкны салбар нь Монгол Улсын санхүүгийн салбарын 95 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг бөгөөд манай эдийн засгийн үрт хугацааны тогтвортой өсөлтөд чухал нөлөө үзүүлсээр ирсэн билээ. Тэр ч утгаараа Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтынхоо хүрээнд мөнгөний бодлогыг баримталж, инфляцыг тогтворжуулах, банкны салбарын хууль эрх зүйн

орчны шинэтгэл, банкны салбарт тавигдах хяналт, шалгалтын үр нөлөөтэй байдлыг тогтмол ханган ажиллах зэрэг үүрэг хариуцлагыг хүлээн ажиллаж байна. Монголбанк энэхүү үүргээ 100 жилийн хугацаанд амжилттай гүйцэтгэсээр ирэв.

100 жилийн түүхэн дэх банк санхүүгийн салбарын зам дардан байгаагүй. Унаж, боссон олон саад бэрхшээлийг давж түүлжээ. Тодруулбал, банк үүсэн хөгжих эхэн үедээ буюу арав орчим жилийн туршид мөнгө, зээлийн бодлого эмх цэгцгүй, өөрийн гэсэн санхүүгийн бүтэц бий болгох тэмцэл дунд явж ирсэн байдаг. 1933 оноос эхлэн зээлийг тодорхой зориулалттай, эргэн төлөх хугацаатай, үнэ бүхий барьцааны зүйлээр баталгаажсан байхаар зохион байгуулж эхэлсэн бөгөөд санхүүгийн тайлан, тэнцэлд дүн шинжилгээ хийж зээлжих хэмжээг тодорхойлдог болсон байна. Өөрөөр хэлбэл, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг удирдах тогтолцооны эхлэл ийнхүү тавигдсан гэж үздэг. Харин 1940 оноос Монголбанк нь Монгол Улсын санхүүгийн бүх харилцааны төв ►



► болж, банкны зээл төлбөр тооцоо, касс зэрэг бүхий л үйлчилгээг өөр дээрээ авснаар түргэн шуурхай хүртээмжтэй байдал нь алдагдаж эхэлжээ.

Ийнхүү 1954 онд БНМАУ-ын банкныг бүрэн өмчлөх болж, мөнгө, зээлийн бодлогыг өөрийн орны зорилгод бүрэн нийцүүлэх боломж бүрдсэн юм. Үүнээс хойш 1991 хүртэлх хугацаанд Улсын төлөвлөгөөний комисст баталсан төлөвлөгөөт эдийн засгийн арга хэмжээнд санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах байдлаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байв. Гэсэн ч банкны тухай тусгайлсан хууль, тогтоомж байхгүй учраас банкны үйл ажиллагаатай холбоотой харилцааг дүрэм, журмаар зохицуулдаг байжээ.

## Банкны систем “эрүүлжив”

1991 оны дөрөвдүгээр сарын 4-ний өдөр Банкны тухай хууль батлагдаж, банкны тогтолцоо нь Төв банк, арилжааны банкнаас бүрдэхээр болж, хоёр шатлалт системд шилжив. Төв банкныг хуулиар Монголбанк гэж нэрлэн, үйл ажиллагаа нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, улсын валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, харилцагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэжээ. Харин арилжааны банк нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бизнесийн үйл ажиллагааг эрхлэх болсон байна.

Банкны тухай хууль гарахаас өмнө байгуулагдсан арилжааны банкнуудыг шинээр бүртгэн банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, шинээр арилжааны банк байгуулахыг зөвшөөрөх, банк хоорондын клирингийн тооцооны төв байгуулах, зээлийн мэдээллийн нэгдсэн сантай болох зэрэг эхний шатны алхмыг 1993 оны эхний хагас жилээс хэрэгжүүлэн эхэлжээ.

1992-1995 онд мөнгөний удирдлагын захиргааны болон эдийн засгийн аргыг хослуулсан мөнгөний бодлого боловсруулан хэрэгжүүлснээр 1994 он гэхэд банкнуудын үйл ажиллагааг Монголбанк бүрэн хяналтад авч, үнийн өсөлтийг тогтвортой бууруулж эхэлжээ. Нөгөө талаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чөлөөт тогтолцоонд шилжүүлсэн нь Монголын эдийн засаг зах зээлийн харилцаанд шилжих үйл явцын чиг хандлагыг тодорхойлов. Мөн банк хоорондын төлбөр тооцоог түргэн шуурхай болгох зорилгоор цахим сүлжээнд тулгуурласан банк хоорондын клирингийн тооцоог нэвтрүүлж эхэлсэн

**Банкны  
салбарын  
хувьцаа  
эзэмшигчдийн  
тоо 70 гаруй  
мянгад хүрэв**

байна. Гэсэн хэдий ч хэдэн жилийн дараа зарим банк дампуурлаа зарлав. Санхүү төлбөрийн чадварын хүнд байдалд орсон ХОТШ банкныг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 1999 онд албадан татан буулгахаар шийдвэрлэсэн байдаг. Харин есөн жилийн дараа Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2008 онд Анод банканд онцгой дэглэм тогтоож, Эрх хүлээн авах албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Ийнхүү 2008 онд Банкн дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль, 2009 онд Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийг тус тус боловсруулан, батлуулж, банкны салбарын хууль эрх зүйн орчин, банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцооны үндэс суурийг бэхжүүлжээ. Ингэснээр банкны салбарын үйл ажиллагаа улам өргөжин дэвшиж, дэлхийн хөгжил дэвшилтэй зэрэгцэж ирэв.

## Арилжааны банкуудын засаглал сайжирч, олон нийтэд нээлттэй болов

Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2021 онд УИХ-аар батлуулж, банкнуудыг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулахаар болсон билээ. Энэ хүрээнд арилжааны банкнууд олон нийтэд нээлттэй болж, засаглал нь сайжрах үндэс суурь нь тавигдсан юм. Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк 2023 онд анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болов. Үүний үр дүнд банкны салбарын хувьцаа эзэмшигчдийн тоо 70 гаруй мянга болж, нийт 473 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг дотоодын зах зээлээс татан төвлөрүүлж, банканд тавих олон нийтийн хяналт сайжрав. Монголын банк санхүүгийн салбарын туулж ирсэн зам, бүтээсэн ажил үйлс, хийж хэрэгжүүлсэн бодлого шийдвэр нь улс орныг өнөөгийн хөгжилд хүргэхэд томоохон хувь нэмэр оруулсныг хэлэх хэрэгтэй. Зуун жилийн өмнө банк гэдэг зүйл байгуулагдаагүй байхад гадаадын мөнгө хүүлэгч пүүсүүд монголчуудын санхүүг атгаж, мөнгөн гүйлгээний эмх замбараагүй байдлыг үүсгэсэн байдаг. Тиймээс энэ нөхцөл байдлыг засахын тулд улс орон, ард түмний санхүүгийн манаач үндэсний банкныг байгуулсан нь өнөөдөр 100 жилийн турш үүргээ ухамсарлаж, биелүүлж ирсний дүнд Монгол Улс өнөөдөр дэлхийн хөгжил, дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж байна. ■



## ТҮҮХЭН ТОВЧООН

• 1924<sup>02/VI</sup>

- Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк байгуулагдав.
- Монгол Улс анх удаа үндэсний банктай болж, үндэсний мөнгөн тэмдэгттэй болох, улс ардын төсвийн болон аж ахуйн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, төлбөр тооцоог хийх, зээлийн тогтолцоог бүрдүүлэх, ард иргэдийн хувийн мөнгөн хадгаламжийг хадгалах, арвижуулах үүргийг гүйцэтгэв.

• 1954<sup>12/IV</sup>

- ЗХУ банканд оруулсан өөрийн хөрөнгөө Монголын талд шилжүүлэн өгснөөр Монголбанк БНМАУ-ын Засгийн газрын мэдэлд бүрэн шилжив.
- Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банкныг өөрчлөн байгуулж, Улсын банкны ерөнхий хороо болгов.
- Улсын банкны Ерөнхий хороо нь улсын мөнгөн гүйлгээ, зээл олголтыг төр засгийн хатуу хяналтын дор төлөвлөгөөгөөр зохицуулж, санхүүжилтийн төв болж төсвийн кассын үүрэг гүйцэтгэж, эдийн засагт төгрөгийн урьдчилсан болон дараалсан хяналтын үүрэг гүйцэтгэж байв.

• 1991<sup>04/IV</sup>

- Банкны хууль батлагдаж, банкны тогтолцоо нь Төв банк, арилжааны банкнаас бүрдэхээр болж, хоёр шатлалт системд шилжив.
- Төв банкныг хуулиар Монголбанк гэж нэрлэн, үйл ажиллагаа нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, эмиссийн болон улсын валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, харилцагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэв.
- Арилжааны банк нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бизнесийн үйл ажиллагааг эрхлэх болов.

## ОН ЦАГИЙН ХУРААНГУЙ ТОВЧООН

**1260 он:** Юань гүрний их хаан Хубилай алт, мөнгөн баталгаатай цаасан мөнгийг анх удаа гүйлгээнд гаргав.

**1924 он:** Монгол-Зөвлөлийн Худалдаа ба Аж үйлдвэрийн банк /Монголбанк/ байгуулагдав.

**1925 он:** Үндэсний мөнгөн тэмдэгтийг төгрөгөөр тогтоож, 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртийг гүйлгээнд гаргав.

**1932 он:** Хугацаатай, эргэн төлөгдөх зээлийн зарчмыг анх нэвтрүүлснээр зээлийн барьцаа авч эхлэв.

**1933 он:** Хувийн аж ахуйн нэгжид анх удаа зээл олгож эхлэв.

**1934 он:** Худалдаачин, малчин иргэдэд анх удаа зээл олгож эхлэв.

**1940 он:** Улсын төсвийн орлого, зарлага Худалдаа аж үйлдвэрийн банкаар дамжих болов.

**1941 он:** Урт хугацааны, 2-4

жилийн хугацаатай зээл олгогдох болов.

**1942 он:** Худалдаа аж үйлдвэрийн банк аймгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулах салбар, хэлтэстэй болов.

**1954 он:** ЗХУ банканд оруулсан өөрийн хөрөнгөө Монголын талд шилжүүлэн өгснөөр Монголбанк БНМАУ-ын Засгийн газрын мэдэлд бүрэн шилжив.

**1956 он:** Зээлийг эдийн засгийн агуулга, зорилгын түвшинд харгалзан үзэж, ангилж эхлэв.

**1958 он:** Социалист орнуудтай бэлэн валютын гэрээ байгуулах эрх авчээ.

**1963 он:** Монгол Улс олон талт бүртгэл, тооцооны системд шилжив.

**1964 он:** Улсын банкны Ерөнхий хорооны бүтцэд өөрчлөлт оруулж, үйлчилгээний ажлыг тусад нь гаргаж, Улаанбаатар

хотын банкны салбарыг байгуулав.

**1973 он:** Электрон машин анх ашиглаж, банкны гүйлгээний баримтыг механикжуулав.

**1978 он:** Телетайпыг анх нэвтрүүлж, гадаадын банктай шууд холбогдох боломжтой болов.

**1986 он:** Үндэсний валют, валютын үнэт зүйлийг гаргах, оруулахад тодорхой хязгаар тогтоож, олон улсын валютыг үндэсний мөнгөн тэмдэгтээр солих бололцоог бүрдүүлэв.

**1989 он:** Олон улсын банкнуудтай хамтран ажиллах хүрээг өргөжүүлэх зорилгоор Хамтын ажиллагааны комисс байгуулав.

**1990 он:** Төгрөгийн ам.доллартой харьцах суурь ханшийг тогтоов.

**1991 он:** Хоёр шатлалт банкны тогтолцоонд

шилжив.

**1992 он:** Банк хоорондын клирингийн тооцоо нэвтэрч, банкнуудын эх үүсвэрийг өөр хооронд нь тусгаарлав.

**1993 он:** Валютын ханшийн тогтмол дэглэмээс чөлөөтэй хөвөх тогтолцоонд шилжив.

**1994 он:** Мөнгөний бодлого мөнгөний үзүүлэлтүүдийг онилсон арга хэлбэрт шилжив.


**1995 он:** Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг батлуулж, банкны харилцагчдын эрхийг хамгаалав.

**1996 он:** Олон улсын төлбөр тооцооны SWIFT сүлжээнд холбогдон, гадаад төлбөр тооцоог шуурхай дамжуулах боломжтой болж, гадаад орнуудтай хийх төлбөр тооцооны найдвартай байдлыг





# БАНКНЫ ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ 100 ЖИЛД



хангав.

**1998 он:** Мөнгөжсөн алт, үнэт металлын бүртгэлийн үнийг тогтоов.

**1999 он:** Олон улсын “Master”, “VISA” сүлжээнд нэгдсэнээр төлбөрийн картын үйлчилгээг нэвтрүүлэв.

**2001 он:** АТМ төхөөрөмж ашиглан бэлэн мөнгө авах үйлчилгээг нэвтрүүлэв.

**2002 он:** Интернэт банкны үйлчилгээг анх нэвтрүүлэв.

**2004 он:** Эрдэнэсийн сангийн хоёр танхим бүхий үзмэрийг нээснээр иргэдэд тус санд хадгалагдаж буй хосгүй үнэт үзмэрийг дэлгэн үзүүлдэг болов.

**2005 он:** Төлбөр тооцооны төв буюу Үндэсний цахим гүйлгээний төвийг байгуулав.

**2006 он:** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлагдав.

**2007 он:** Инфляцыг онилох мөнгөний бодлогын арга, хэлбэр рүү шилжиж эхлэв.

**2008 он:** Төв банкнаас валютын захад оролцох оролцоог бууруулж,

төгрөгийн ханш илүү уян хатан тогтох болов.

**2009 он:** Гадаад валютын дуудлага худалдааг нэвтрүүлж, Төв банкны интервенцийг дуудлага худалдааны зарчмаар явуулах болов.

**2010 он:** Төлбөрийн карт гаргагч банкнуудтай хамтран “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г байгуулж, тухайн банкны харилцагч аль ч банкаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэв.

**2011 он:** Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16 тэрбум төгрөг байхаар тогтоов.

**2012 он:** Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлгэдэн нэрлэсэн үндэсний брэнд “₮ карт”-ыг банкнуудтай хамтран гаргаж, нийтийн хүртээл болгов.

**2013 он:** Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдав.

**2014 он:** Бага дүнтэй төлбөр тооцооны систем 24/7 бодит цагийн горимд шилжив.

**2015 он:** Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16 тэрбум төгрөгөөс 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоов.

**2016 он:** Банк хоорондын интернэт худалдаа “eCommerce” нэвтрүүлэв.

**2017 он:** Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай болов.

**2018 он:** Төв банк / Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар шийдвэрийг хамтын удирдлагын зарчимд /Мөнгөний бодлогын хороо, Хяналт шалгалтын хороо/ тулгуурлан гаргадаг боллоо.

**2019 он:** Үндэсний мөнгөн дэвсгэртийн хамгаалалтын элементийг сайжруулж, 50-т, 100, 500, 1000, 5000, 10000, 20000-тын дэвсгэрт дээр сүүлийн үеийн дэвшилтэд технологи бүхий 3 хэмжээст хөдөлгөөнтэй, спарк бэхэн элемент болон бусад шинэлэг өөрчлөлтийг хийв.

**2020 он:** Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар

“Банкны салбарын шинэчлэлийн дүнд хугацааны хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж эхлэв.

**2021 он:** Монголбанкнаас зөвшөөрөлтэй цахим мөнгөөр дижитал бонд худалдах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, цахим мөнгөний хэрэглээ нэмэгдэхэд дэмжлэг үзүүлэв.

**2022 он:** Банкны системд нөлөө бүхий банкнууд нээлттэй ХК, харин бусад банк ХК-ийн хэлбэртэй болов.

**2023 он:** Үндэсний брэнд ₮ картыг олон улсын жишгийн дагуу EMV/Чип технологид шилжүүлэв. Мөн ₮ картаар олон улсад гүйлгээ хийх боломжийг нэмэгдүүллээ. Монгол Улсын төлбөрийн систем түргэн шуурхай, найдвартай, аюулгүй байдлын хувьд дэлхийн жишигт хүрэв.

**2024 он:** Монгол Улсад Монголбанк үүсэж, бэхэжсэний 100 жилийн ой тохиов.

## Онцлох ярилцлага

# Б.Лхагвасүрэн: Банкны салбарын туулсан зам дардан байгаагүй ч, одоо батжин бэхжээд байна



*Банкны тогтолцооны үүсэл, хөгжил, бэхжилт, Төв банкны үүрэг, оролцоо, санхүүгийн цахим үйлчилгээний талаар Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнтэй ярилцлаа.*

-Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж, бэхжсэний 100 жилийн ой тохиож байна. Монгол Улсын эдийн засгийн хөгжилд банкны салбарын гүйцэтгэсэн үүрэг, хувь нэмрийг та хэрхэн тодорхойлох вэ?

-Монгол Улсын банкны салбар өнгөрсөн 100 жилийн хугацаанд олон улсын түвшинд хүрч хөгжиж, тэр хэрээр эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, улс орны бүтээн байгуулалт, хөгжлийг эрчимжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирлээ. Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк) анх 1924 онд байгуулагдаж, 1925 онд үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг гүйлгээнд гаргасан нь түүхэн чухал үйл явдал байв. Ийнхүү Монголбанк байгуулагдсанаар Монгол Улсад мөнгөний тогтолцоо үүсэж ►



► бэхжих, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг дотоод санхүүжилтээр дэмжих суурь бүрдсэн.

Монголбанк 1924-1991 онд санхүүгийн зуучлал болон санхүүгийн системийн хөгжлийг дангаар тодорхойлж, санхүүгийн зах зээл дээрх үндсэн ганц зуучлагч байсан. Харин 1991 оноос хойш банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжиж, банк санхүүгийн тогтолцоо эрчимтэй хөгжихөд онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг. Монголбанк анх 22 ажилтантай, Нийслэл хүрээнд төвтэйгөөр байгуулагдаж, Алтанбулаг суманд салбартай байсан бол, 2023 оны эцсийн байдлаар банкны салбар 16,459 ажилтан, 303 салбар, 1019 тооцооны төв, 51 валют солих цэг, 5 төлөөлөгчийн газартайгаар санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Монголбанк 100 жилийн түүхэндээ дотоод, гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай хийх, үнийн тогтвортой байдлыг хадгалах, гадаад валютын нөөцийг удирдах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, олон улсын жишигт хүрсэн тоон мэдээлэл гаргах, судалгаа, шинжилгээ хийх чиглэлд дэлхийн сайн түршлагыг нутагшуулан улам бэхжин, хөгжиж ирлээ.

Өнөөдөр Монголбанк төрийн институт, эмиссийн банк, мөнгөний бодлого тодорхойлогч, банкны салбарын зохицуулагч байгууллага, санхүүгийн зуучлагч, гадаад валютын нөөцийн удирдлагын менежер, Эрдэнэсийн сангийн “арвижуулан хамгаалагч”, санхүүгийн боловсрол олгогч, зээл, санхүүгийн мэдээллийн санг хариуцагч зэрэг чиг үүргийг гүйцэтгэн, улс орны бүхий л салбар, нийгмийн амьдрал, хөгжилд өөрийн чиг үүргийн хүрээнд оролцож байна. Банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжин, хөгжилд тэмүүлсэн 33 жилийн хугацаанд банкны салбар үйлчилгээ, технологийн чиглэлд анхдагч байж, хөгжлийн хувьд олон улсын түвшинд хүрч, Монгол Улсын эдийн засгийн чухал салбарын нэг болтлоо тэлээд байна. Банкны салбарын түүлсан зам үргэлж дардан шулуун байгаагүй ч одоо “эрийн цээнд хүрч” эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт, ногоон хөгжлийг түүчээлэх тулгуур багана болж чадсан гэж харж байна.

**-Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн түүх арвин баялаг, мөн өнө эртнээс улбаатай. Чингис хааны үеийн мөнгөн тэмдэгт, Юань гүрэн гээд бахархам түүхтэй. Гэхдээ монголчууд бид**

**Монголбанк байгуулагдсанаар Монгол Улсад мөнгөний тогтолцоо үүсэж бэхжих, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг дотоод санхүүжилтээр дэмжих суурь бүрдсэн.**

**мөнгөн тэмдэгтийн өнөө үед шинэчлэгдэн ирсэн түүхээ сайн мэддэггүй нь үнэн. Таныг энэ талаар сонирхолтой түүх ярина гэж бодож байна?**

-Тийм ээ, бид төлбөрийн хэрэгсэл, мөнгөн тэмдэгтийн арвин баялаг түүхтэй. Тэр түүх маань өнө эртнээс улбаатай. Азийн нүүдэлчдийн байгуулсан анхны хүчирхэг эзэнт гүрэн Хүннү, түүний дараах Түрэг, Уйгарын үеэс зоосон мөнгө цутгаж, худалдаа арилжаанд хэрэглэж байсан. Чингис хаан, түүний залгамжлагчид Монголын их эзэнт гүрнийг байгуулж, алт, мөнгө, хүрэл зоос, цаасан мөнгөн тэмдэгтийг эдийн засгийн эргэлтэд оруулж байв.

Хожим Ардын хувьсгал ялж, мөн Монголбанкийг байгуулсны дараа МАХН-ын 1924 оны наймдугаар сард хуралдсан III их хурлаар банкны үйл ажиллагааны тухай авч хэлэлцээд, “Цагаан мөнгөн баталгаа бүхий мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах нь зүйтэй” гэж шийдвэрлэсэн байдаг. БНМАУ-ын анхдугаар хурлын тогтоолд гадаадын мөнгө хэрэглэх нь улс орны эдийн засагт ихээхэн хор хохиролтой болохыг тэмдэглээд, үндэсний мөнгөн тэмдэгт бий болгох нь чухлыг тодотгосон.

Улмаар Ардын Засгийн газраас 1925 оны хоёрдугаар сарын 22-ны өдөр “Мөнгөний шинэчлэл хийх тухай” түүхэн тогтоол гаргасан байдаг. Үүний дагуу Сангийн яамнаас Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банкныг түшиглэн 1925 онд Мөнгөний явдлыг шинэчлэн сайжруулах комиссыг байгуулж, үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, мөнгө, зээлийн бодлого боловсруулах ажлыг хариуцуулж байлаа. Ийнхүү 1925 оны арванхоёрдугаар сарын 9-ний өдөр анх 200, 100 төгрөгийг гүйлгээнд гаргаснаас хойш 99 жил болж байна. Үндэсний мөнгөн тэмдэгт “төгрөг” ийнхүү улс ардын аж ахуйн хөгжлийн бүхий л үе шатанд амжилттай үйлчилж, мөнгөн гүйлгээ, төлбөрийн хэрэгсэл, өртгийн хэмжүүр, хадгаламжийн үндсэн нэгж, олон улсын мөнгөний үүргийг бүрэн чадвартай гүйцэтгэсээр ирсэн түүхтэй.

“Хубилай хаан 1260 онд Шанду (Юань гүрний зүны нийслэл)-д Монголын Их Эзэнт гүрний хаан болсны дараагаар гүйлгээнд байсан төлбөрийн хэрэгслүүдийг орлуулах зорилгоор мөнгөөр ►

► баталгаажсан шинэ цаасан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргасан нь нэгдсэн мөнгө гаргах эхлэл болсон. Хубилай хаан Монголын Их Юань гүрэн (1271-1368)-ийг байгуулан өөрийн гаргасан цаасан мөнгөн тэмдэгтийг цорын ганц хууль ёсны төлбөрийн хэрэгсэл болгон зарлаж, бусад бүх металл зоосыг хүчингүй болгосон байдаг.

**-Төв банкныг энэ 100 жилд хэдэн Ерөнхийлөгч удирдаж байсан бэ? Таны хувьд ажлын гараагаа Монголбанкнаас эхлэн, банк санхүүгийн салбарт 30 орчим жил ажиллаж, өдгөө 100 дахь жилийн ойгоор Монголбанкандаа эргэн ирж Ерөнхийлөгчийн хувиар ажиллаж байна. Та ямар сэтгэгдэлтэй байна вэ?**

-Монголбанк, банкны салбарын хөгжлийн 100 жилийн хугацааг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк үүсэн байгуулагдсан үе, БНМАУ-ын 100 хувь өөрийн эзэмшлийн банкттай болж хөгжсөн үе, банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжин бэхэжсэн үе гэж ерөнхийд нь үечилж болно. Одоо миний бие Төв банкны 20 дахь удирдлага болон ажиллаж байна. Монголбанкийг үүсгэн байгуулсан эхний жилүүдэд 1924-1931 оны хооронд Оросын дөрвөн мэргэжилтэн удирдаж байсан нь манай улсад банк, санхүүгийн талаарх мэдлэг боловсролтой боловсон хүчин байхгүй байсантай холбоотой. Харин 1931 онд анхны монгол даргаар С.Довчин томилогдож, 1939 он хүртэл ажилласан. Түүнээс хойш 1991 он хүртэл Монголбанкийг Ю.Цэдэнбал, Т.Балдан, Г.Балжид, Л.Лхамсүрэн, П.Төмөр, Д.Данзан, Г.Хүдэрчулуун нарын долоон хүн удирдаж байв. 1991 онд Монголбанкны анхны Ерөнхийлөгчөөр Н.Жаргалсайхан томилогдсоноос хойш Д.Моломжамц, Ж.Үнэнбат, О.Чулуунбат, А.Батсүх, Н.Баяртсайхан, Л.Пүрэвдорж, Н.Золжаргал нарын эрхмүүд энэ албыг нэр хүндтэй хашиж ирсэн.

Таны дараагийн асуултад хариулахад миний ажил амьдрал Төв банк, банк, санхүүгийн салбартай салшгүй холбоотой. МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн жилдээ тухайн үед Улсын төлөвлөгөөний комиссын дэргэдэх Шинжлэх ухааны Эдийн засгийн хүрээлэнд эрдэмтэн шинжилгээний ажилтнаар ажлын гараагаа эхэлж, улмаар Монголбанканд шилжин ажилласнаар бодлогын шийдвэр гаргадаг бүхий

**Банкны салбарын туулсан зам дардан шулуун байгаагүй ч одоо “эрийн цээнд хүрч”, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт, ногоон хөгжлийг түүчээлэх тулгуур багана болж чадсан**

л газар, нэгжид ажилласан. Монголбанкандаа ажиллаж байх хугацаандаа АНУ-ын Вашингтон дахь Дэлхийн банкны төвд Зүүн Ази, Номхон далайн орнуудын санхүүгийн секторт зөвлөхөөр шилжин ажиллаж, туршлага хүримтлүүлсэн.

Улмаар Монголбанкандаа буцан ирж, өөрийн мэдлэг, туршлагынхаа хүрээнд төрийн мөнгөний бодлого банкны салбарыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж ирсэн. Монгол Улс анх удаа харилцагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуультай болсноор Хадгаламжийн даатгалын корпорацыг төрөөс үүсгэн байгуулж, анхных нь удирдлагаар ажиллаж, үйл ажиллагааг нь төлөвшүүлж байв. Түүний дараа Монголбанкандаа дахин томилогдож, Дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчөөр дэвшин ажиллаж байна. Энэ хугацаанд “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэх, ФАТФ-ийн “Саарал жагсаалт”-аас шуурхай гарах, цар тахал, геополитикийн хурцадмал цаг үеийн мөнгөний бодлогыг удирдах зэрэг хариуцлагатай үүрэгтэй тулгарсан. Одоо харахад, эдийн засгийн бүхий л үзүүлэлт эерэг зүгт сайжирч, сэргэсэн байна.

Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж, бэхжсэний 100 жилийн ойгоо ололт амжилт бүтээлээр угтаж байгаадаа Монголбанк, банкны салбарынхан бид баяртай байгаа. Эдийн засагт тулгарсан хүндрэл бэрхшээлийг бууруулахаас гадна банкны системийг тогтворжуулах шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан. Үр дүнд нь банк олон нийтийн өмчлөлтэй болж, засаглал сайжрах, гаднын банк дотоодын зах зээлд олон хэлбэрээр нэвтрэх эрх зүйн орчин бүрдэж, банкны салбарыг хөгжлийн дараагийн шатанд хүргэх шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж байна.

**-Таны Монголын банкны секторт ажиллаж эхэлсэн хугацаа Монгол Улс зах зээлийн системд шилжсэн хугацаатай давхцаж буй. Монголын арилжааны банкнуудын өнгөрсөн 30 гаруй жилийн хөгжлийг та хэрхэн тодорхойлох вэ?**

-Банкны салбарын өнгөрсөн 33 жилийн түүхийг товч дүгнэбэл, банкуудын хувьд ч, банкны салбарын хууль эрх зүйн зохицуулалтын хувьд ч үсрэнгүй хөгжлийн үе байлаа. 1990 ►



► оноос Монгол Улс банкны хоёр шатлал бүхий тогтолцоонд шилжиж, анхны арилжааны банкууд үүсгэн байгуулагдаж эхэлсэн. Арилжааны банкууд үүсгэн байгуулагдсанаар банкны салбарт системийн шинжтэй томоохон өөрчлөлт бий болж, Төв банкны хувьд арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгах томоохон үүрэгтэй болсон. Төв банкны зүгээс банкны салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, банкуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх ажлыг шүүрхайлж, 1991 оны дөрөвдүгээр сард Банкны тухай хуулийг баталж, Төв банкийг мөнгө, зээлийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй болгож, үйл ажиллагааг зохицуулсан Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг 1996 онд батлуулж, банкны салбарын хууль эрх зүйн орчин бүрдэх үндэс суурь тавигдсан. Шилжилтийн эдийн засгийн он жилүүдэд банкууд олноор байгуулагдаж, мэдлэг туршлага бага байснаар 1994-1996 оны хооронд банкны салбарт хүндрэл хямрал нүүрлэж байв.

Банкны салбарын зохицуулалт сайжирснаар 2000-2009 онд харьцангуй тогтворжилтын үе эхэлж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн харьцаа, зээлийн чанар сайжирч, мэргэшсэн боловсон хүчинтэй болж, үйл ажиллагаа нь төлөвшиж ирсэн. Ингэснээр 2010 оноос банкны салбар улам өргөжиж, арилжааны банкуудын үйл ажиллагааны цар хүрээ тэлж, олон улсын шинэ технологийг нэвтрүүлж эхэлснээр манай банкны салбар дэлхийн улс орнуудтай мөр зэрэгцэх хөгжил дэвшлийн гараандаа ирсэн гэж хэлж болно.

Банкны салбарын тогтвортой байдлын үндсэн тулгуурын нэг болох хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгон, банканд дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлж, банкны хадгаламжийг даатгалд хамруулж, банкны салбарын тогтвортой байдлыг улам бэхжүүлсэн. Банкны үйл ажиллагаанд тавигдах зохистой харьцааны шаардлагыг бий болгож, банкны зохистой засаглал, эрсдэлийн удирдлагад тавигдах шаардлага, банканд хийх байнгын хяналт шалгалт, төлбөрийн чадваргүй болсон банканд хийх албадлагын арга хэмжээний зохицуулалтыг олон улсын сайн туршлага, өөрийн орны туршлагад үндэслэн бий

болгож ирсэн. Мөн банкны хяналт шалгалтыг олон улсын Базелийн стандартад нийцүүлэх ажил эрчимжиж, Монголбанкнаас эрсдэлд суурилсан хяналт, шалгалт, макро зохистой бодлогын арга хэрэгслийг нэвтрүүлж, хяналт шалгалтын үр нөлөө сайжирсан билээ.

Банкны салбарын хууль эрх зүйн орчин сайжирч, банканд тавигдах хяналт, шалгалтын үйл ажиллагаа олон улсын жишиг стандартад нийцтэй байсан хэдий ч зарим банк төлбөрийн чадваргүй болж, татан буугдсан нь ихэнх тохиолдолд банканд зохистой засаглал алдагдсантай холбоотой байсан. Эдгээр үйл явдал, сургамж нь банкны салбарт дараагийн шинэчлэлийг хэрэгжүүлэх эхлэлийг тавьж, Монголбанкнаас банкуудын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах үндсэн зорилго бүхий Банкны салбарын дунд хугацааны шинэтгэлийн хөтөлбөрийг 2020 оноос хэрэгжүүлж, арилжааны банкуудыг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөгдөн байгуулагдах, хувь эзэмшлийн төвлөрлөө бууруулах хугацаатай үүрэг даалгавар өгсөн.

Энэхүү хууль, эрх зүйн өөрчлөлтийг банкны салбарт хийсэн хоёр дахь “хувьсгал” гэж нэрлэж болох бөгөөд хөтөлбөрийн үр дүнд Монголын банк, санхүүгийн системд үйл ажиллагаагаа явуулж буй арилжааны бүх банк хөрөнгийн зах зээлд хувьцаагаа олон нийтэд нээлттэй гаргаж, хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн. Системийн хэмжээнд нөлөө бүхий Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк компанийн хэлбэрээ өөрчлөн нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагааг өнгөрсөн жил амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү шинэчлэл нь Монгол Улсын банк санхүүгийн салбарын урт хугацааны тогтвортой байдалд төдийгүй хөрөнгийн зах зээлийн хөгжилд түлхэц болох эдийн засаг, нийгмийн хөгжлийг түүчээлэхэд томоохон чухал үйл явдал болсон.

-Дэлхийн улс орнуудын Төв банк тухайн улсынхаа банкны секторыг тодорхойлох нь бий. Манай Төв банкны хувьд ч нэлээд өндөр боловсролтой, гадаад, дотоодод их дээд сургууль төгссөн хүний нөөц ажилладаг. Хүний нөөцийн цаашдын чиг хандлагыг хэрхэн харж байна вэ? ►

**Манай  
эдийн засаг  
олборлох  
үйлдвэрлэлээс  
өндөр  
хамааралтай  
болох тусам  
дэлхийн  
хэмжээний  
шоокын нөлөө  
улам хүчтэй  
мэдрэгдэх  
болсон**

► -Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч, Төв банкны хувьд Монголбанкны хүний нөөцийн үйл ажиллагааг дэлхий нийтийн тэр дундаа, бусад Төв банкны хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулж ирсэн. Өнгөрсөн хугацаанд Монголбанк хүний нөөцийн төлөвлөлтийг байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн үр ашигтай байдлаар зохион байгуулж, банк санхүүгийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх тал дээр түлхүү анхаарсан. Хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийхдээ Монгол Улсын төдийгүй, олон улсын нэр хүндтэй их сургууль төгссөн ажил горилогчдоос сонгон шалгаруулалт хийж, шинээр орсон ажилтнуудыг олон улсын нэр хүндтэй сургуулиудад магистр докторын түвшний сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлдэг. Ажилтнуудыг бусад орны Төв банк болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын гадаад сургалтад хамруулах зэрэг давтан сургах, мэргэжил, мэдлэгийг нь дээшлүүлэхэд байнга анхаарч, мэдлэг үр чадварыг тасралтгүй хөгжүүлэх бодлого баримталж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж ирсэн.

Гадаад, дотоодод өндөр боловсрол эзэмшиж ирсэн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, сурсан мэдлэгийг бусдад түгээх, газар нэгжүүдэд шилжүүлэн, сэлгэн ажиллуулж мэргэжлийн практик үр чадварыг эзэмшүүлэх чиглэлээр системтэй бодлого хэрэгжүүлж ирснээр өнөөдөр Төв банканд олон улсын түвшинд бэлтгэгдсэн мэргэшсэн чадварлаг ажилтнууд ажиллаж байна. Монголбанкны нийт ажилтнуудын ажилласан дундаж хугацаа нь 25 орчим жил байгаа нь сурч боловсорч, түршлага хуримтлуулсан ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж ирсний тод илрэл юм. Өндөр үр чадвар эзэмшсэн албан хаагчид маань олон улсын нэр хүндтэй санхүүгийн байгууллагуудаас ажлын санал хүлээн авдаг бөгөөд Монголбанкны хувьд ч шилжин ажиллах боломжийг нээлттэй олгодог. Жишээ нь, ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Шинэ Зеландын Төв банк, нэр хүндтэй их, дээд сургуулиуд болон Амазон, Рио Тинто зэрэг дэлхийн томоохон компаниудад шилжин ажиллаж байна.

**Ажиллагчдын мэдлэг үр чадварыг тасралтгүй хөгжүүлэх бодлого баримталж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж ирсэн**

Цаашид байгууллагын ажилчдын ирээдүйн хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцтэй хөтөлбөрүүдийн хүрээнд Монголбанкнаас бодлогын болон Төв банкны уламжлалт арга, хэрэгслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээс гадна олон улсын сайн туршлага, нийтлэг жишгээр Монголбанкны үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийг төлөвлөн, цогц байдлаар үйл ажиллагааны хөтөлбөр батлан хэрэгжүүлж, дижитал хувиргалт болон хиймэл оюун ухааны дэвшлийг ашиглан хүний нөөцийн сүүлийн үеийн өөрчлөлтүүдийг нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

**-Монголбанкны орон нутгийн салбар, хэлтсүүд хөдөөгийн хөгжилд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ. Цаашид хэрхэн өөрчлөлт гарах вэ?**

-Монголбанкны орон нутгийн салбар, хэлтсүүд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг сурталчлан таниулж, хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх, гүйлгээнд мөнгө гаргах эмиссийн үйл ажиллагаанд ихээхэн хувь нэмрээ оруулан ажиллаж ирсэн. Арилжааны банкны эрсдэлийг илрүүлж, засах бололцоог олгож, зөвлөж ажиллаж байгаа нь орон нутгийн салбар, хэлтсүүдийн онцлог, ач холбогдол юм. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, аж ахуйг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхэд арилжааны банкуудад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлж, бууруулахад анхаарч ажиллаж байна.

Сүүлийн жишээг дурдахад, орон сууцны ипотекийн хөтөлбөрт хамрагдсан нийт зээлдэгчийн 25 орчим хувь буюу 26.0 мянга гаруй өрх орон нутагт орон сууц худалдан авч амьдарч байна. Монголбанкны зүгээс орон нутагт олгох зээлийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутаг болон Улаанбаатар хотод тэгш хүртээмжтэй зээл олгох арга хэмжээг өнгөрсөн есдүгээр сараас хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд энэ онд олгосон нийт зээлийн 50 орчим хувь буюу 3000 өрхийн 303.2 тэрбум төгрөгийн зээл орон нутагт олгосон. Үүнээс 58 орчим хувь буюу 1700 өрхийн 175.8 тэрбум төгрөгийн зээл нь 3 хувийн хүүгийн ►





► хөнгөлөлттэй зээл байна. УИХ-аас 2024 оны дөрөвдүгээр сард баталсан Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Монголбанк ХХААХҮЯ, Сангийн яам, Зээлийн батландаалтын сан болон арилжааны банкуудтай хамтран ажиллаж, хуульд заасан хоршооны гишүүн малчдын зээлийн санхүүжилтийн гэрээг байгуулсан. Гэрээ байгуулснаас хойш сар гаруйн хугацаанд зээл олгох үйл явц эрчимжиж, одоогоор 1326 хоршооны 4538 малчинд нийт 160.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгоод байна.

**-Өнгөрсөн зууныг Монголбанкны бодлого, үйл ажиллагаа, аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал баттай бэхжсэн 100 жил гэж дүгнэж болох уу?**

-Түүхэн 100 жилийн хугацаанд Монгол Улсад Монголбанкны үйл ажиллагаа, банкны тогтолцоо батжин бэхжиж чадсан. Монголбанк нь нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилтэй уялдан үйл ажиллагаагаа шинэчлэхийн зэрэгцээ хөгжлийг түүчээлэгч нэг тулгуур болдог. Энэ бол тасралтгүй үргэлжлэх процесс. Монголбанк өнөөдөр бодлого, үйл ажиллагааны хувьд орчин үеийн дэлхийн Төв банкуудын сайн туршлага, шинжлэх ухааны ололтыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулж, тэдэнтэй мөр зэрэгцэн хөгжиж буй институт болж хөгжөөд байна. Анх

**Орон сууцны ипотекийн хөтөлбөрт хамрагдсан нийт зээлдэгчийн 25 орчим хувь буюу 26.0 мянга гаруй өрх орон нутагт орон сууц худалдан авч амьдарч байна**

Монголбанк байгуулагдахдаа мөнгөн гүйлгээний эмх замбараагүй байдлыг цэгцлэх, гадаадын мөнгө хүүлэгчдээс ангижрах, үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд нэвтрүүлэхийг зорьж байсан бол өнөөдөр үнийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, түүнд шаардлагатай дэд бүтэц, хэрэгслүүдийг нэвтрүүлэх түвшинд хүрээд байна.

Төв банкны бодлого, үйл ажиллагааны эрх зүйн орчныг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шаардлагаар өөрчилж, улмаар санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, бодлогын хэрэгслүүдийг нэвтрүүлэх үйл ажиллагаа тасралтгүй хийгдсээр байна. Эдгээр нь Төв банкны бодлого, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалж, бэхжүүлэхэд чиглэж байна.

**-Монголын банк, санхүүгийн сектор технологийн хөгжлийн хувьд дэлхийд дээгүүр бичигддэг. Одоо дэлхий даяар бүхий л салбарын хөгжлийн чиг хандлагыг хиймэл оюун ухаан тодорхойлж байна. Тэгвэл хиймэл оюуны чиглэлээр Монголын банкуудын чиг хандлага ямар байгаа вэ?**

-Банк, санхүүгийн салбар нь харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн орчин үеийн цахим технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ирсэн. Өнөөдөр төлбөр тооцооны тал дээр бүрэн цахимжсан салбар болсон. Ковид-19 цар тахлын хөл хорионы үед ч төлбөр тооцоо тасралтгүй явж ирсэн нь үүний нэг нотолгоо байв. Эдгээр үндсэн зорилтыг хангахад чиглэсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлого төлөвлөлтийн шинжилгээний систем загвар, аргачлалыг эдийн засаг, санхүүгийн шинжлэх ухааны хөгжил, дэвшлийг тусгасан байдлаар боловсруулж, ашиглаж байна. Төлбөрийн системийн оролцогч банкууд, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь Монголбанкны клирингийн төвийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байсан бол одоо банк бус санхүүгийн байгууллага, финтек компаниуд үүнд нэгдэн орсон. Ингэснээр иргэд, аж, ахуй нэгжүүд цаг хугацаа, орон зайг үл харгалзан 24/7 горимоор төлбөр тооцоогоо төлбөрийн карт, ►

► интернэт, мобайл банк, QR код, аппликейшн зэрэг сүвгийг ашиглан гүйцэтгэж хэвшээд байна.

Монголбанк олон улсын жишигт нийцсэн стандарт, шийдэл бүхий Банксүлжээ, Автомат клиринг хаус систем, Төлбөрийн картын клирингийн систем, Төв банкны арилжааны нэгдсэн систем, олон улсын TIER II түвшинд магадлан итгэмжлэгдсэн дата төв, Токен баталгаажуулах систем зэргийг амжилттай нэвтрүүлсэн. Өнгөрсөн оны зургадугаар сард Монголбанк “Central Banking” институтээс шалгаруулсан “Fintech RegTech Global Awards”-ын “The Pioneer Award” буюу “ТҮҮЧЭЭЛЭГЧ” шагналын эзнээр тодорсон. Энэ шагналыг өмнө нь Их Британийн Санхүүгийн зохицуулах хороо 2022 онд, Тайландын Төв банк 2021 онд, Францын Төв банк 2019 онд, Канадын Төв банк 2018 онд тус тус хүртэж байсан. Монголбанк 2016 оноос эхлэн “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэн төлбөрийн системтэй холбоотой дэд бүтэц, хууль, эрх зүйн орчин, тоног төхөөрөмж, программ хангамж гэсэн үндсэн чиглэлээр хийж гүйцэтгээд байна. Их өгөгдлийн системийн сууриллуулалт, хөгжүүлэлтийг үндэсний компани болох “Novelsoft”-тай хамтран гүйцэтгэсэн бөгөөд банкуудаас тоон мэдээлэл, тайланг нэгдсэн хэлбэрээр өндөр давтамжтай цуглуулах системийг сууриллуулсан нь дэлхийн Төв банкуудад жишиг болохуйц ажил болсон тул уг шагналыг олгосон байдаг.

Цаашид хиймэл оюун ухаанд суурилан, санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай их хэмжээний мэдээлэлд бодит цагийн горимд дүн шинжилгээ хийж, үүсэж болох эрсдэлийг тооцож, эдийн засагт сөрөг нөлөөгүй, оновчтой шийдлээр тохирсон арга хэмжээг урьдчилан авах боломж бий болно үзэж байгаа. Хиймэл оюун ухааны тусламжтайгаар санхүүгийн бүх тайлан, мэдээ, статистикийг боловсруулж, цахимаар авах, бүрэн автоматжсан системийг хөгжүүлж, түршилыг эхлүүлсэн. Энэ системийн үр дүнд тайлан, мэдээг цаг хугацааны хувьд маш бага хоцрогдолтойгоор гаргах боломж бүрдэнэ.

**Монголбанк  
гадаадын  
банкны бие  
даасан салбар,  
нэгжийг  
дотоод зах  
зээлд нээн  
ажиллуулах  
орчныг  
бүрдүүлэх  
чиглэлд  
түлхүү  
анхаарч  
ажиллаж  
байгааг  
онцлон хэлье**

**-Монголбанк өнгөрсөн нэгэн зууныг үдэж, шинэ зууны эхлэлийг тавьж байна. Шинэ зууны эхлэл дээр ямар ажилд төвлөрч байна вэ?**

-Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлд “Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг хангана” хэмээн тусгасан байгаа. Гадаадын банк, санхүүгийн байгууллага дотоод зах зээлд нэвтэрч үйл ажиллагаа эрхлэх нь гадаад санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг өсгөх, банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулах, дотоодын санхүүгийн зах зээлийн хөгжилд түлхэц үзүүлж, санхүүгийн дэд бүтцийг сайжруулах зэрэг эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой. Тиймээс Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль, дагалдах журмуудын төслийг боловсруулж, батлаад байна. Ингэснээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид том төслүүдийг санхүүжүүлэх, банкны салбар, нэгж байгуулах боломж илүү нээлттэй болж байна. Монголбанк гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоод зах зээлд нээн ажиллуулах орчныг бүрдүүлэх чиглэлд түлхүү анхаарч ажиллаж байгааг онцлон хэлье.

Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх шинэ стратегийг 2024 оноос хэрэгжүүлж байна. Иргэдийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх анхан шатны ойлголт сайжирч буй хэдий ч инфляц, хүү, санхүүгийн эрсдэл зэрэг эдийн засаг, санхүүгийн мэдлэг сул байна. Иймд Монголбанкнаас эдийн засаг, санхүүгийн суурь ойлголтыг өгөхийн хажуугаар хувь хүн, өрхийн санхүүд үүсэж болох эрсдэл, анхаарах асуудлын талаар мэдлэг, мэдээллийг давхар олгож байна. Тухайлбал, санхүүгийн залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд анхаарч, олон нийтэд мэдлэг, мэдээлэл өгөх, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна. ■



## “Банк-100” үзэсгэлэн

# “Монголбанк-100 жил”, “Хубилай хааны зарлиг”, “Хос луу” дурсгалын зоос мэндлэв

Их Монгол Улс байгуулагдсаны дараа Чингис хааны хамгийн анхны алтан зоос 1219-1220 онд Хорезм руу хийсэн аян дайны эхэн үед гарч байсан түүхтэй. Улмаар Юань гүрний үед гүйлгээнд анх гаргасан цаасан мөнгөн дэвсгэрт болон Монголын эртний хаадын нэр овгийн тамгатай 52 ширхэг зоосны цуглуулгыг улсын санд худалдаж авсан байдаг. Энэ нь маш ховор дурсгал буюу 800 жилийн өмнө Хубилай хааны зарлигаар барлаж бүтээсэн мөнгөн дэвсгэрт юм.

Тэгвэл хэдэн зуун жилийн дараа буюу 2024 оны зургадугаар сарын 2-ны өдөр Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж бэхэжсэний 100 жилийн ойн хүрээнд “Чингис хаан” үндэсний музейд “Банк-100” гэрэл зураг, мөнгөн тэмдэгт, маркийн үзэсгэлэн нээгдсэн юм. “Банк-100” үзэсгэлэнд Монгол Улсын банкны салбарын зуун зуун жилийн түүхэн фото зургууд болон монголчуудын төлбөрийн хэрэгсэл, зоос, дурсгалын зоос, мөнгөн тэмдэгтийн хөгжлийг илтгэсэн ховор нандин цуглуулга, үзмэрүүдийг нэг дор дэлгэсэн байв. Үзэсгэлэнгийн нээлтийн үеэр Монгол Улсад банкны салбар үүсэж бэхэжсэний 100 жилийн ойд зориулан гаргасан “Монголбанк-100 жил”, “Хубилай хааны зарлиг”, “Хос луу” сэдэвт дурсгалын зооснуудыг албан ёсоор олон нийтэд танилцуулав. Мөн “Монгол шуудан” ХК-иас банкны салбарын 100 жилийн ойд зориулсан “Анхны өдөр” маркийн эх зургийг нээх ёслол, маркийг Монголын маркийн музейд хадгалуулах дугтуйнд гарын үсэг зурах зэрэг ёслолууд болсон юм.

Тус арга хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нээж хэлсэн үгэндээ “Нэгэн зууныг ололт, амжилтаар түүчээлсэн манай банкны салбар өнөөдөр, үйлчилгээ, бүтээгдэхүүний нэр төрлөөр олон улсын жишигт хүрч, санхүүгийн зуучлалын үүргийг амжилттай гүйцэтгэж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол түлгүүр, тэргүүлэх




салбар болж хөгжөөд байна. Иймд өнгөрсөн зуун бол бидний “Хамтдаа бэхэжсэн зуун” байлаа. Энэ зууны түүхэн ойн баярыг тохиолдуулан “Банк-100” үзэсгэлэнг ийнхүү зохион байгуулж байна. Хоёрдугаар мянганы дэг журам, хөгжлийг тодорхойлж, өрнө дорнын хооронд худалдаа, харилцааг хөгжүүлсэн монголчууд бидний өвөг дээдэс алт, мөнгөн зоос, цаасан дэвсгэртийг эдийн засгийн эргэлтэд оруулснаараа дэлхийн мөнгөний түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Эдгээр түүхэн баримт, нотолгоог дэлгэн үзүүлээ.

Банкны тогтолцоо үүсэж, хөгжсөний 50 жилийн ойгоос эхлэн Монголбанк ойн дурсгалын зоосоо гаргаж ирсэн. 70 жилийн ойгоор “Чингис Хаан” 1 кг-ын алтан дурсгалын зоос гаргаж байсан бол өнөөдөр “Монголбанк 100 жил”, “Хубилай хааны зарлиг”, “Хос луу” зооснуудыг гаргаж байна. Дурсгалын зоос нь тухайн үйл явдалд зориулсан зураг чимэглэл, тусгай бичвэрээрээ бусад зоосноос ялгарах бөгөөд нэрлэсэн үнэ, банкны билэгдэл тэмдгийг агуулахаас гадна улс орны түүх, соёлыг сурталчлах өвөрмөц илэрхийлэл болдог” хэмээн онцолсон юм. ■

# Тоон мэдээ

## Бодит ДНБ-ий өсөлт (2015 оны зэрэгцүүлэх үнээр)

2023: 68.8  
их наяд ₮  
(оны дүнгээр)



2023 оны эцсийн байдлаар


ОНЫ ҮНЭЭР **68.9** их наяд төгрөг

2015 ОНЫ ЦЭРЭГЦҮҮЛСЭН ҮНЭЭР **30.5** их наяд төгрөг

ӨСӨЛТ **70%**

Эх сурвалж: УЦХ, Монголбанк

## Инфляц (Төв банкны зорилтот түвшин)



2023 оны эцсийн байдлаар

УЛААНБААТАР ХОТЫН ИНФЛЯЦ **8.6%**


УЛСЫН ИНФЛЯЦ **7.9%**

ХҮНСНЭЭС БУСАД БАРАА **4.7%** нэгж

ХҮНСНИЙ БАРАА **3.2%** нэгж

Эх сурвалж: УЦХ, Монголбанк

## M2, Зээл, банкны салбарын актив (ДНБ-д эзлэх жингээр)



2023 оны  
эцсийн байдлаар

M2 мөнгөний  
нийлүүлэт

**37.6**

их наяд төгрөг

БАНКНУУДЫН  
ЗЭЭЛИЙН  
үлдэгдэл

**27.1**

их наяд төгрөг


БАНКНУУДЫН  
АКТИВ

**57.1**

их наяд төгрөг

Эх сурвалж: YCX, Монголбанк

## Гадаад валютын албан нөөц, ханш (сая ам.доллар)



2024 оны 5-р  
сарын байдлаар:

**5,183.4** сая ам.доллар  
2024.05.31

2024 оны  
5-р сарын  
дундаж ханш

USD

**3,381.2**



EUR

**3,652.4**



CNY

**467.4**



Эх сурвалж: Монголбанк



## Мөнгөний бодлого

## Мөнгөний бодлогын шинэчлэл

**М**өнгөний бодлого нь мөнгөний нийлүүлэлт, түүний үнэ, олдцод нөлөөлж санхүүгийн зах зээлийн төлөвийг өөрчлөн эдийн засгийн тогтвортой байдал, үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Төв банк /Монголбанк/-наас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа юм. Мөнгөний бодлого нь эдийн засаг тогтвортой өсөх суурь нөхцлийг бүрдүүлдэг. Эдийн засаг хэт идэвхжиж, үнийн өсөлт нэмэгдсэний улмаас иргэдийн орлого үнэгүйдэх, амьжиргаа доройтохоос сэргийлэх үүрэг хүлээдэг. Мөнгөний бодлого амжилттай хэрэгжих суурь нь зах зээлийн хөгжил, институцийн зохион байгуулалт, хүний нөөцийн үр чадвар юм.

Зуун жилийн өмнө Монголбанк байгуулагдсан тэр үед санхүүгийн зах зээл бүрэлдээгүй, гадаадын мөнгө хүүлэгч пүүсүүд монголчуудын санхүүгийн хэрэгцээг хангаж, гадаад улсуудаас банк байгуулах өрсөлдөөн нэмэгдсэн, мөнгөн гүйлгээний эмх замбараагүй байдал үүссэн байжээ. Иймээс үндэсний мөнгөн тэмдэгтийг бий болгож, мөнгөн гүйлгээг зохион байгуулах, үндэсний банкныг байгуулах шаардлага үүссэн байна. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 1924 оны зургадугаар сарын 02-нд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба Аж үйлдвэрийн банк (Монголбанк)-ийг үүсгэн байгуулжээ. Гэхдээ 10-аад жилийн туршид мөнгө, зээлийн бодлого эмх цэгцгүй, өөрийн гэсэн санхүүгийн бүтэц бий болгох тэмцэл дунд явж ирснийг түүхийн баримтууд харуулдаг.

Монголбанк нь 1933 оноос зээлийг тодорхой зориулалттай, эргэн төлөх хугацаатай, үнэ бүхий барьцааны зүйлээр баталгаажсан байхаар зохион байгуулж эхэлсэн бөгөөд санхүүгийн тайлан, тэнцэлд дүн шинжилгээ хийж зээлжих хэмжээг тодорхойлдог болжээ. Өөрөөр хэлбэл, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг удирдах тогтолцооны эхлэл ийнхүү тавигдсан гэж үздэг. Монгол Улс 1954 онд БНМАУ-ын банкныг бүрэн өмчлөх болж, мөнгө, зээлийн бодлогыг өөрийн орны зорилгод бүрэн нийцүүлэх боломж бүрдсэн юм. Үүнээс хойш



**1990-ээд оны сүүл үеийн банкны хямрал нь банкны системийн цаашдын хөгжилд томоохон өөрчлөлт авчирсан юм**

1991 хүртэлх хугацаанд Улсын төлөвлөгөөний комисст баталсан төлөвлөгөөт эдийн засгийн арга хэмжээнд санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах байдлаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байв.

Монгол Улс 1990 оны эхнээс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхэлснээр банкны хоёр шатлалт тогтолцоо үүсэж, зах зээлийн дэд бүтцийг бий болгох шаардлага тулгарч, мөнгөний бодлого хэрэгжүүлэх институционал өөрчлөлтийг хийсэн. Эхний жилүүдэд санхүүгийн зах зээлийн зохион байгуулалтыг бий болгох, хүний нөөц бүрдүүлэх, банк болон төлбөр тооцооны системийг тогтвортой ажиллуулах нь нэн тэргүүний зорилт болж байв. Иймээс шилжилтийн эхэн үед мөнгөний бодлого нь захиргааны арга хэрэгсэлд тулгуурласан санхүүгийн эх үүсвэрийн хуваарилалт цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд чиглэж байв. Монголбанк 1996 оноос Төв банкны эрх зүйг олон улсын туршлагатай нийцүүлж, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлснээр банкны системийг хянах, удирдах нөхцөл бүрдэж эхэлсэн учир мөнгөний бодлогын арга хэлбэр, хэрэгслүүдийг шинээр зохион байгуулж эхэлжээ.

Зах зээлд суурилсан бодлогын арга хэрэгс-

► лүүдийг нэвтрүүлэхийн хэрээр Монголбанкны мөнгөний бодлого нь мөнгөний үзүүлэлтүүдийг онилсон арга хэлбэр рүү шилжих суурь тавигдаж байв. Монголбанк 1994 оноос эхлэн “Санхүүгийн програмчлал” буюу сектор хоорондын мөнгөн хөрөнгийн илүүдэл, дутагдлын тооцоог Олон Улсын Валютын Сан /ОУВС/-гийн аргачлалаар хийж эхэлсэн нь мөнгөний үзүүлэлтүүдийг зорилт болгосон бодлогын арга хэлбэрийг хэрэгжүүлэх тооцоолол шинжилгээний үндэс болж байв.

Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжүүлэх хэрэгслүүд санхүүгийн захын хөгжлийг даган өөрчлөгдөж, цаг үеийн шаардлагаар шинэчлэгдэж ирлээ. Бодлогын зохион байгуулалт 1996 оноос тодорхой арга хэлбэртэй болж, шилжилтийн үеийн үнийн хэт өсөлтийг хязгаарлаж, инфляц 100 хувиас давж байсан нь бүүрсаар нэг оронтой тоонд орсон юм. Банкны салбарын 1990-ээд оны сүүл үеийн банкны хямрал нь банкны системийн цаашдын хөгжилд томоохон өөрчлөлт авчирч, санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг өөрчлөв. Түүний зэрэгцээ Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр өсөж, улмаар гадаад валютын нөөцийн хэмжээ ОХУ-ын их өр төлж, тэглэснээс хойш ерөнхийдөө өсөв. Эдгээр гол хүчин зүйлс нь эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийг ихээхэн хэмжээгээр шингээж чадаж байв. Энэ үеийг судлаачид эдийн засаг мөнгөжих үйл явц хүчтэй ажиглагдсан үе гэж үздэг. Энэ үед Монголбанк эдийн засгийн бүтцийн талаар болон загвар хөгжүүлэлтэд шаардлагатай глобал суурь судалгаануудыг хийсэн.

Глобал санхүүгийн хямралаас улбаатайгаар дотоод эдийн засагт төлбөрийн тэнцлийн хямрал нүүрлэж, системийн тогтвортой байдалд эрсдэл үүсэж байв. Мөнгөний бодлогын зорилтод тогтвортой байдал чухал ач холбогдолтой болсон учир Төв банк эцсийн зээлдүүлэгчийн хувьд системийн тогтвортой байдлыг хамгаалах ажлыг шүүрхай зохион байгуулан ажиллаж байв. Энэ хүртэл уян хатан байдлаар хэрэглэх бололцоотой мөнгөний бодлогын хэрэгслүүдийг бий болгох томоохон дэвшлүүд хийгдсэн. Банк хоорондын захын хүүг бодлогын хүүгээр удирдаж, хүүгийн нэгдсэн бодлого хэрэгжүүлж байна. Бодлогын хүүг 2007 онд анх нэвтрүүлснээс хойш банк хоорондын захын хүүг мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт болгох суурь тавигдсан бөгөөд түүнийг

удирдах коридорыг бий болгож эхэлсэн.

Мөнгөний болон макро зохистой бодлогын хэрэгслүүдийг эдийн засгийн түвэгтэй орчинд хэрэглэхэд бэлэн болгож олон төрөлтэй болгосоор байгаа нь бодлогын арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх өргөн орон зай олгож буй ач холбогдолтой. Манай эдийн засаг олборлох үйлдвэрлэлээс өндөр хамааралтай болох тусам дэлхийн хэмжээний шокын нөлөө улам хүчтэй мэдрэгдэх болсон.

Банкны салбар хөгжиж, банк хоорондын зах ажиллаж эхлэхтэй зэрэгцэн нөөц мөнгөөр дамжуулан мөнгөний нийлүүлэлтийг удирдах арга хэлбэрийг ашиглаж инфляцын зорилтыг хангах боломж бүрдсэн. Эдийн засаг тогтворжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, олон улсын санхүүгийн захын интеграцид орж эхлэхэд гадаад валютын хөрөнгийн үрсгал нэмэгдэж, цаашид мөнгөний нийлүүлэлтийг удирдахаас илүүтэйгээр хүүгийн түвшинд нөлөөлөх нь үр ашигтай болсон. Иймд бодлогын арга хэлбэрийг сольж, “бодлогын хүү” хэрэглэх болсон.

Үүний дараагийн шат болох ирээдүйд чиглэсэн шийдвэр гаргах тогтолцоо буюу эдийн засгийн төсөөлөлд суурилсан мөнгөний бодлогын шийдвэр гаргах ажил 2014 оноос эхэлсэн. Инфляцын төсөөлөлд суурилж бодлогын шийдвэр гаргахад инфляцын хүлээлтийг удирдах, тооцоолох шаардлага улам нэмэгдэв. Хүлээлт нь мөнгөний бодлогын төлөвийг тодорхойлоход ач холбогдолтой орц болсон учраас ойрын төлөвийг тайлбарлах, бодлогын шийдвэрийн үндсийг олон нийтэд ойлгуулах хэрэгцээг бий болгосон. Энэхүү хэрэгслийг нэвтрүүлэхдээ хэвлэлийн бага хурал, инфляцын тайлан, бодлогын арга хэмжээг сурталчилсан олон төрлийн мэдээллийг нийтэд гаргах боллоо.

Төв банк нь олон нийтэд илүү нээлттэй болохын хэрээр Төв банкны бодлогын шийдвэр гаргалтууд олон нийтийн шүүлтүүрт орж, бодлогын хараат бүс шийдвэр гаргалтын хариуцлагатай байдлыг улам бүр нэмэгдүүлэх юм. Эцэст нь, Төв банканд итгэх итгэлийг сайжруулж, хүлээлтийг удирдах чадавхаа нэмэгдүүлэхийг зорьж байна. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн үеийн мөнгөний бодлогын зорилт нь улс орны хөгжил, эдийн засаг, санхүүгийн системийн хөгжилтэй уялдан цаг үеийн шаардлагаар хувьсан өөрчлөгдөж иржээ. ►

**Манай  
эдийн засаг  
олборлох  
үйлдвэрлэлээс  
өндөр  
хамааралтай  
болох тусам  
дэлхийн  
хэмжээний  
шокын нөлөө  
улам хүчтэй  
мэдрэгдэх  
болсон**

► Өнгөрсөн 30 жилийн хугацаанд инфляцын зорилтыг хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх үнийн өсөлтийн түвшнээр жил бүр тодорхойлж ирсэн. Мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө нэг жилээс дээш хугацаагаар үргэлжилдэг учраас жил бүр зорилтоо өөрчлөх эсхүл тодорхойлох нь зохимжгүй тул 2017 оноос эхлэн дунд хугацаагаар буюу гурван жилээр тодорхойлж жил бүр УИХ-д өргөн мэдүүлдэг болсон.

Инфляцын гүйцэтгэл дийлэнхдээ зорилтод түвшнээс давж байсан нь мөнгөний бодлогоор нөлөөлөх боломжгүй хүчин зүйлсийн буюу зах зээлийн дэд бүтэц, улирлын нөлөөтэй холбоотойгоор нийлүүлэлтийн шинж чанартай өөрчлөлтөөр хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэж байсантай холбоотой байв. /Зураг 1-ээс үзнэ үү/. Тухайлбал, цаг агаарын таагүй байдлаас шалтгаалан өвөлжилт хүндрэх, зуншлага тааруу байснаас ургац алдах, малын ашиг шим буурах байдлын давтамж нэмэгдэж байгаа нь зах зээл дээр мах, сүү, хүнсний ногоо зэрэг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг доголдуулж, үнэ өсөх нөхцөлийг бүрдүүлж байна. Манай эдийн засгийн уул уурхайгаас хамаарах хамаарал нэмэгдэхийн хэрээр гадаад шокийн инфляцад үзүүлэх нөлөөний давтамж, хүч сүүлийн 20 гаруй жил буурахгүй байгаа нь өрхийн хэрэглээнд өндөр жин эзэлдэг импортын бараа, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийг нэмэгдүүлэх нөлөөтэй байна.

Монголбанк ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогын арга хэлбэрт шилжихийн тулд төсөөлөл, шинжилгээний бүтцийг бий болгох, хөгжүүлэх, нэвтрүүлэх шаардлагатай болсон. Монголбанк, Польшийн Төв банкны хамтын ажиллагааны хүрээнд 2006 оноос “Инфляцыг таамаглах хураангуй загвар” хөгжүүлж, 2013 он хүртэл төсөөллийн үндсэн загвар болгон ашиглаж байв. Мөн 2011 оноос эхлэн макро эдийн засгийн төсөөлөл хийх цэгцтэй уялдаатай бүтэц бий болгох, энэ чиглэлд хүний нөөцөө мэргэшүүлэх, мөнгөний бодлогын төсөөлөл, шинжилгээнд ашиглах загварууд хөгжүүлэх зорилгоор “Төсөөлөл, бодлогын шинжилгээний систем” нутагшуулах төслийг Европын сэргээн босголт хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хоёр үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлсэн.

Олон нийтэд зарласан тогтсон хуваарийн дагуу мөнгөний бодлогын шийдвэр гаргах тогтолцоонд 2015 оноос шилжсэн нь орчин цагийн Төв банкны мөнгөний бодлогын ололтыг нэвтрүүлсэн чухал алхам болов. Түүнээс гадна, мөнгөний бодлогын


асуудал хэлэлцэж, шийдвэрлэх үүрэг бүхий Мөнгөний бодлогын хороог Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 2018 оны нэмэлт, өөрчлөлтийн дагуу байгуулж, олон нийттэй харилцах шинэ дэд бүтцийг бий болгосон нь хариуцлагатай, ил тод байдлыг шинэ шатанд гаргасан алхам билээ.

Сүүлийн 10 гаруй жилийн туршид “Глобал санхүүгийн хямрал”, “Уул уурхайн супер мөчлөг”, КОВИД-19 цар тахал, олон улс, улс төр, эдийн засгийн хуваагдал тохиолдож, бодлогын ердийн хэрэгслээр шийдвэрлэж болохооргүй сорилт тулгарсан. Эдгээр хямрал, сорилтыг даван туулахад Төв банк эцсийн зээлдүүлэгчийн хувьд зээл олгох, банкнуудын зээлдэгчдийн эрсдэлийг бууруулахын тулд богино хугацаат репо хэлцлийг илүү урт хугацаат хэрэгсэл болгон өөрчлөн, банкны зээлдэгчдийн эрсдэлийг өөртөө түр авах зэргээр бодлогын хүнд сонголт хийж, заримдаа уламжлалт бус хэрэгсэл ашигласан.

Мөнгөний бодлого хэрэгжүүлэх тогтолцоо өнөө хүртэл хөгжиж ирэхдээ Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу эдийн засгийн өсөлт, хөгжил, санхүүгийн захын бүтцийг боловсронгуй болгон, сорилт хүндрэлүүдийг даван туулсаар байна. Цаашид эдийн засаг, санхүүгийн зах зээл улам бүр нарийн боловсронгуй болж, дэлхийн санхүүгийн зах зээлтэй нягт холбогдохын хэрээр мөнгөний бодлогын шийдвэр гаргах тогтолцоог боловсронгуй болгох, тооцоолол шинжилгээний аргачлалыг сайжруулах ажлыг тасралтгүй хийсээр байх юм. ■

### Инфляцын зорилт, биелэлт

Улаанбаатар хотын инфляц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанкны өгөгдөл дээр үзүүлэв



## КОВИД-19

## КОВИД-19 цар тахлын үеийн мөнгөний болон макро зохистой бодлого

**К**ОВИД-19 цар тахлын улмаас дэлхийн улс орнуудад сүүлийн 80 жилд тохиогоогүй гэнэтийн, гүн хямрал тохиов. Дэлхий нийтээр эрүүл мэндээс үүдэлтэй эдийн засгийн хямралын үед хэрхэн ажиллах, ямар бодлого хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа хэрхэн зохион байгуулахад бэлэн биш байсан. Энэ нь хөл хорионд орж, бизнесийн болон цалингийн орлого аль аль нь зогссон зээлдэгчийг хамгаалан чанаргүй зээлдэгч болохоос урьдчилан сэргийлэх, зээлийн эргэн төлөлт тасалдсан үед зээл олгогч санхүүгийн байгууллагыг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын болон төлбөрийн чадвар дутагдалд орж дампуурахаас сэргийлэх буюу санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах явдал байв.

Дэлхий нийтээр аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээ, тээвэр зэрэг салбарын үйл ажиллагаа богино хугацаанд хумигдаж, цар тахлын цохилтод хүчтэй өртсөнөөс гадна вирусийн шинэ хувилбарууд бий болсон нь улс орнууд хямралын давхар давллагаатай нүүр тулсан юм. КОВИД-19 цар тахал Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт төлбөрийн тэнцэл, орлого, зээлийн сувгаар дамжин нөлөөлөв. Цар тахлаас шалтгаалан 2020 оны эхний хагаст Монгол Улсын гол экспорт болох эрдэс түүхий эдийн үнэ 20 орчим хувиар унасны зэрэгцээ БНХАУ-тай хиллэдэг боомтуудыг хааж, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 40 гаруй хоногийн хугацаанд зогссон нь эдийн засаг, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд хүчтэй сөрөг нөлөөг үзүүлсэн. Үүнтэй зэрэгцэн, халдвараас сэргийлэх хатуу хөл хорионы улмаас эдийн засаг зогсонги байдалд орсон нь хөдөлгөөнт байдлын индекс 2020 оны төгсгөл, 2021 оны эхний улиралд нийтдээ 40 орчим хувиар буурснаас харагддаг.

Эдийн засаг 2020 оны эхний хагаст 9.7 хувиар агшиж, зах зээлийн тодорхой бус байдал огцом нэмэгдсэн тул банкнууд зээл олголтоо бууруулж, банкны нийт зээл 2020 оны эцэст өмнөх оны мөн үеэс таван хувиар тус тус буурсан.

Цар тахлын үед бодлогын дизайныг боловсруулахад эдийн засгийн сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх нь бодлогын эхний зорилт болгож байсан бол, цар тахлын дараа эдийн засаг хурдан сэргэхэд дэмжлэг болох эдийн засаг, санхүүгийн зах зээлийн бүтцийг хамгаалж авч үлдэх нь хамгийн чухал зорилт байлаа. Санхүүгийн зуучлалыг дэмжих зорилгоор Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 онд ээлжит болон ээлжит бусаар нийт долоон удаа хуралдаж, бодлогын хүүг таван нэгж хувиар бууруулан түүхэн доод түвшин болох зургаан хувьд хүргэв. Түүнчлэн, зээлийн эх үүсвэрийг

чөлөөлөх, эх үүсвэрийн алдагдсан боломжийн өртгийг бууруулах зорилгоор төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах арга хэмжээг давхар авч хэрэгжүүлсэн юм. Төв банкны уламжлалт богино хугацаат /14 хоног/ репо санхүүжилтийг 2020 оны есдүгээр сард өөрчлөн урт хугацаат репо санхүүжилт болгон нэвтрүүлэв. Уг хэрэгсэл нь банкны системд үүсээд байсан зээлийн тасалдлыг зогсоох, зээл олголтыг нэмэгдүүлж ажлын байрыг хамгаалах зорилготой байв.

2020 оны тавдугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 43.6 мянган зээлдэгчийн 3.01 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсээд байв. Энэ хүрээнд Монголбанкны зүгээс ААН, өрхүүдийг дефолтоос сэргийлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой бодлогын зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм. Үүнд:

Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зориулалтаар иргэнд олгосон зээлийн ангилал бууруулах хугацааг уртасгах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байв (2021 оны 08 сараас 2022 оны 04 сар хүртэл хэвийн горимд аажмаар шилжүүлсэн).

Бүх төрлийн зээлд бүтцийн өөрчлөлт хийхэд хязгаарлалтгүй болгох түр хугацааны зохицуулалт зэрэг арга хэмжээ авсан.

Банкны ашигт ажиллагаа, эрсдэл даах чадварыг дэмжих зорилгоор банкуудын ТТГЧ-ын зохистой харьцааг 25-аас 20 хувь болгож бууруулах (2021 оны 6 сар хүртэл), өөрийн хөрөнгийн нөөц интервал бүрдүүлэх хугацааг хойшлуулах (2022.07.01 хүртэл) шийдвэрийг гаргаснаар банкуудын санхүүгийн чадавхад эерэг нөлөө үзүүлэв. Мөн цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 онд Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын зарим зохицуулалтыг сулруулсан ба 2021 оноос эхлэн хэвийн горим руу шилжүүлэв.

Цаашлаад 2021 онд эдийн засаг сэргэж эхэлсэн хэдий ч, цар тахлын сөрөг нөлөө төдийлөн буураагүй, салбаруудын өсөлт жигд бус байсан тул бодлогын хүүг зургаан хувьд 2021 оны туршид хэвээр хадгалж, өсөлтийг дэмжих арга хэмжээг авч үргэлжлүүлсэн. Мөн урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслээр дамжуулан цар тахлын цохилтод хүчтэй өртсөн салбаруудыг дэмжих, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд мөнгөний бодлогын үйл ажиллагаа чиглэсэн. ■

## Макро зохистой бодлого

## Макро зохистой бодлогын тогтолцоо бүрдэв

2008 оны глобал санхүүгийн хямралаас хойш дэлхий нийтээр санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудлыг чухалчилж, дийлэнх улс орон “макро зохистой бодлого”-ын чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид тодорхой тусгаж, хэрэгжүүлж байна. Энэхүү чиг хандлагыг даган УИХ-аас 2018 оны нэгдүгээр сард баталсан Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх эрх үүргийг Монголбанкны Мөнгөний бодлогын хороонд даалгасан. Ингэснээр Монгол Улсад макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэлдэж, Монголбанкнаас макро эдийн засгийн болон санхүүгийн бодлогыг хослуулсан цогц бодлогын тогтолцоо (Integrated policy framework)-г хэрэгжүүлэх үндэс тавигдав. Цогц бодлогын тогтолцоо нь мөнгөний, ханшийн бодлого, хөрөнгийн үрсгалын зохицуулалт болон макро зохистой бодлогыг хооронд нь үялдуулан, оновчтой хослуулан хэрэгжүүлэх замаар макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрт байдал, санхүүгийн тогтвортой байдлыг нэгэн зэрэг хангах зорилт бүхий цогц бодлогын тогтолцоо юм.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос 2018 онд бусад орны сайн туршлага, олон улсын байгууллагуудын зөвлөмжид тулгуурлан боловсруулсан "Монгол Улсад макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлэх стратеги"-ийг баталсан. Уг стратегид Монгол Улсад хэрэгжүүлэх макро зохистой бодлогын зорилго, түүнд хүрэхэд ашиглах арга хэрэгслүүд, институцийн зохион байгуулалт, бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд баримтлах ерөнхий зарчмыг тодорхойлсон. Түүнчлэн, олон улсын байгууллагуудын техник туслалцааны үр дүн, зөвлөмжид нийцүүлэн 2019 онд Монголбанкны дотоод бүтцийн өөрчлөлтөөр системийн эрсдэлийн шинжилгээг гүйцэтгэх, макро зохистой бодлогын санал боловсруулж, шийдвэрлүүлэх үндсэн чиг үүрэг бүхий макро зохистой бодлого хариуцсан нэгж, улмаар хэлтсийг Мөнгөний бодлогын газар дотор байгуулан ажиллаж байна.



## Макро зохистой бодлогын хүрээнд гаргасан шийдвэрүүд

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос Монгол Улсын санхүүгийн системд тулгарч буй эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор макро зохистой бодлогын шийдвэрийг гарган ажиллаж байна. Өрхийн өрийн дарамтыг бууруулж, улмаар санхүүгийн салбарт эрсдэл хүримтлэгдэхээс сэргийлэх, банкны салбараас олгох зээлийн хувьд хэрэглээний зээлээс илүүтэй бизнесийн зээлийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оноос эхлэн банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд өр-орлогын харьцаа (ӨОХ)-ны болон хугацааны хязгаарлалт тогтоон мөрдүүлж байна. Тус бодлогын нөлөөгөөр хэрэглээний зээлийн өсөлт саарч, улмаар хэрэглээний импортын өсөлтийг сааруулах, ханшийн болон төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулах, бизнесийн зээл олголтыг дэмжих зэрэг эерэг нөлөө үзүүлж байна. Харин тус бодлогын арга хэмжээний нөлөөгөөр иргэдийн хэрэглээний зээлийн эрэлтийн тодорхой хэсэг банкны салбараас банк бус санхүүгийн салбарт шилжиж, бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй. Иймд цаашид банкнаас бусад санхүүгийн байгууллагаас олгох бүх төрлийн хэрэглээний зээлийг ӨОХ-ны хязгаарлалтад хамруулах арга хэмжээг авах, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын

**2018 онд  
"Монгол  
Улсад макро  
зохистой  
бодлогын  
тогтолцоог  
бүрдүүлэх  
стратеги"-  
ийг баталсан**

► бодлогын шийдвэрийг харилцан уялдуулах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж байна.

Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах хүрээнд гадаад валютын орлогогүй, валютын ханшийн эрсдэлийг удирдах бололцоо хязгаарлагдмал иргэн, ААН, байгууллагад олгох гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 120 хувиас 150 хувьд хүргэн нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, 2019 оны эхнээс мөрдүүлж байна. Үүний зэрэгцээ, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж, хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг Мөнгөний бодлогын хорооноос 2020 онд гаргасан. Эдгээр шийдвэрийн нөлөөгөөр зээл, хадгаламжийн долларжилт буурч, валютын позицгийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлсэн.

Харин КОВИД-19 цар тахлын үед Монгол-банкнаас эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулж, сэргэлтийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн макро зохистой бодлогын цогц шийдвэр гаргаж байв. Эдийн засгийн гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд Мөнгөний бодлогын хорооны 2022 оны гуравдугаар улирлын хурлаар банкнуудын гадаадын зах зээлээс бонд, зээл хэлбэрээр 360 хоног болон түүнээс дээш хугацаагаар шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөх шийдвэрийг гаргасан. Тус хорооны 2023 оны нэгдүгээр улирлын хурлаар банкнуудын гадаадын зах зээлээс бонд, зээл хэлбэрээр 360 хоног хүртэлх хугацаатай шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Энэ арга хэмжээ нь хөрөнгийн орох урсгалын төлөв хангалтгүй үед банкнуудад гадаад валютын эх үүсвэр татах хөшүүргийг бий болгож, улмаар хөрөнгийн орох урсгал, гадаад тэнцвэрт эерэг нөлөө үзүүлэв.

Банкнуудын тэтгэврийн зээлийн өндөр өсөлт, өрхийн өрийн дарамт, эрсдэлийг харгалзан үзээд 2023 оны гуравдугаар сард Монголбанкны шийдвэрээр үлдэх хугацаа нь зургаан сараас дээш,

**Дэлхийн банк болон Азийн Хөгжлийн банкны төслийн хүрээнд 2020 оноос “Системийн эрсдэлийн үнэлгээний загвар”-ыг хөгжүүлж байна**

зээлийн сарын төлбөр төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байх тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэх хувийг 2023 оныг дүүстал хугацаанд 150 хувь болгон нэмэгдүүлэв. Улмаар Мөнгөний бодлогын хорооны 2023 оны IV улирлын ээлжит хурлаар дээрх зохицуулалтын хамрах хүрээг өргөтгөж, “Зургаан сараас дээш хугацаагаар олгосон, эсхүл зээлийн сарын төлбөр төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байх тэтгэврийн зээл”-ийн хувьд 2024 оны эхнээс мөрдөх шийдвэр гаргав.

### Макро зохистой бодлогын шинжилгээний тогтолцоо

Монголбанкны зүгээс 2018 оноос хойш олон улсад системийн эрсдэлийн шинжилгээ, мониторинг гүйцэтгэхэд нийтлэг ашиглагдаж буй голлох шинжилгээний арга техникүүдийг хөгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Тодруулбал, системийн эрсдэлийн төлөв байдлыг илэрхийлэх 35 үзүүлэлт бүхий системийн эрсдэлийн зураглал болон санхүүгийн систем дэх мөчлөгийн шинжтэй эрсдэлийг хянах зорилгоор санхүүгийн мөчлөгийн индексийг боловсруулж, улирал бүр шинэчлэн тооцож системийн эрсдэлийг тогтмол хянаж байна. Бүгд Найрамдах Чех улсын OGREsearch судалгааны байгууллагатай хамтран “Макро-санхүүгийн загвар”-ыг хөгжүүлж, бодлогын шинжилгээнд ашиглахад бэлэн болгоод байна.

Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд 2020 оноос “Системийн эрсдэлийн үнэлгээний загвар”-ыг хөгжүүлж байна. Монголбанк нь макро зохистой бодлогын тогтолцоог бэхжүүлэх, шинжилгээний арга зүйг олон улсын түвшинд хүргэх зорилгоор ОУВС-гаас урт хугацааны техник туслалцаа авах хүсэлт тавьсны дагуу 2023 оны арванхоёрдугаар сараас эхлэн ОУВС-гийн суурин зөвлөх томилогдон ажиллаж байна. Энэ хүрээнд олон улсын сайн туршлагад нийцүүлэн Монгол Улс өнөөгийн макро зохистой бодлогын институцийн болон үйл ажиллагааны тогтолцоонд хөгжүүлэх чиглэлд бүх талаар зөвлөмж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. ■



## Мөнгөний шинэчлэл

# Төлбөрийн хэрэгсэл, мөнгөн тэмдэгт шинэчлэгдэж ирсэн түүх

**М**онгол Улсад орчин цагийн банкны салбар үүсэж, бэхэжсэний 100 жилийн ойгоор “Хубилай хааны зарлиг”, “Хос луу”, “Монголбанк-100 жил” нэртэй дүрсгалын зоос гаргаж, олон нийтэд танилцуулав. Орчин үед зоосыг худалдаанд төдийлөн хэрэглэхээ больсон ч олон мянган жилийн түүх, танин мэдэхүйн ач холбогдол нь асар үнэ цэнтэй байдаг билээ. Дэлхийн хүмүүс арав гаруй мянган төрлийн зүйлс цуглуулдаг хамгийн их цуглуулдаг нь зоос байдаг гэдэг. Тиймээс ч зоос үнэ цэнээ хэзээ ч алдахгүйгээр барахгүй, орчин үед хүмүүс хөрөнгө оруулалтын чиглэлээр илүүтэй сонирхон судалж байна. Эртний Хүннү гүрэн, Монголын эзэнт гүрэн, Их Юань гүрний үед зоос, таваар-мөнгөний харилцааг ашиглаж, дэлхий дахинд анхны цаасан дэвсгэртийг 1260 онд гүйлгээнд хэрэглэж байсан баримт одоо Түүхийн музейд байдаг.

Монгол туургатны зоос хэрэглэж ирсэн түүх эртнээс бөгөөд Хүннү, Түрэг, Уйгар гүрний үеэс зоосон мөнгө цутгаж арилжаа наймаанд хэрэглэж байсан баримтууд олон бий. Их Монгол Улс байгуулагдсаны дараа Чингис хааны хамгийн анхны алтан зоос 1219-1220 онд Хорезм руу хийсэн аян дайны эхэн үед гарч байжээ. Улмаар Чингис хаан Монголын нэгдсэн тулгар төрийг үүсгэн байгуулж Сүхэс нэртэй алт, мөнгөн зоос цутгуулж, 1227 онд дэлхийд анх удаа цаасан тэмдэгт хэвлүүлж гүйлгээнд хэрэглэж байсан түүх бий. Тэр үеийн зоосон мөнгө нь эхэн үедээ тодорхой тоо хэмжээ заагаагүй байснаа 1241 онд “Их Монгол Улсын мөнгө” нэртэй зоосыг “Нэг” гэсэн тоотой гаргасан байна. Энэ нь Чингис хаан Монголын нэгдсэн эзэнт гүрнийг улс төр, эдийн засаг, соёлыг зангидан барьж нэгэн



Чингис хааны  
алтан зоос

Хубилай  
хааны зоос



Монголын Их  
Юань улсын  
цаасан мөнгөн  
тэмдэгт

үдирдлагад захирахдаа таваар мөнгөний харилцааг ухаалгаар ашиглаж байсныг харуулна. Цаасан тэмдэгт, зоосон мөнгө их хэмжээгээр гүйлгээнд гарган 1253 онд “Мөнгөний хэрэг эрхлэх хэлтэс” нэртэй мөнгөн гүйлгээ эрхэлсэн байгууллага буюу одоогийнхоор банк байгуулан ажиллуулж байжээ.

Харин Юань гүрний үед гүйлгээнд анх гаргасан цаасан мөнгөн дэвсгэрт болон Монголын эртний хаадын нэр овгийн тамгатай 52 ширхэг зоосны цуглуулгыг улсын санд худалдаж авсан билээ. Энэ нь маш ховор дүрсгал буюу 800 жилийн өмнө Хубилай хааны зарлигаар барлаж бүтээсэн мөнгөн дэвсгэрт юм. Монголчуудыг дэлхийн түүхэнд мөнгөн дэвсгэртийг анх гаргасан гэж үздэг. Үүний баталгаа болох мөнгөн тэмдэгт дэлхийд маш ховор бөгөөд олон улсын шинжээч, судлаачдын сонирхлыг ихэд татдаг билээ. Монгол дөрвөлжин бичиг, хятад ханзаар бичиж, хааны тамгаар баталгаажуулсан мөнгөн тэмдэгт олон зуун жилийн дараа ийнхүү эргэн ирсэн билээ.

Мөн л Хубилай хааны үе 1260 онд Хархоринд “Мөнгө тушаах банк” байгуулж, улмаар аравт, хорьт, зуут, мянгатын дэвсгэрт бүхий мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулан 1282 онд худалдааны төв газруудад салбаруудыг байгуулан ажиллуулж байжээ. Мөнгөний гүйлгээ эрчимтэй хөгжиж 1280-аад онд цаасан мөнгөний шинэтгэл хийж, 1327 онд хуучирсан цаасан мөнгийг шатааж устгах газартай болгон устгалын ажилд мужийн түшмэл гэрчээр оролцдог журам тогтоож байж. Монголын эзэнт гүрний үед 100 гаруй удаа алт мөнгөн болон металл зоос, цаасан тэмдэгтүүдийг гүйлгээнд гарган хэрэглэж байв. ▶


## ► 1925 онд цаасан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд нэвтрүүлэв

Манжийн ноёрхлын үед үндэсний эдийн засаг, соёл, шинжлэх ухааны ололт үгүй болсон гэхэд болно. Монгол орон Манжийн эзэмшилд орж хэдэн зуун жил нүхлагдахдаа үндэсний эдийн засаг, соёл, шинжлэх ухааны ололт бүтээлээ мэдрэхгүй болтлоо доройтсон юм. Тэр үеийн Монгол нь үндэсний банк, санхүү, мөнгө зээлийн системгүй, зах зээлд нь Хаант орос, Хятадын цаасан тэмдэгт, англи, америк, мексик алт мөнгөн зооснууд, цутгасан гүлдмай мөнгө, хятад манжийн юмбүү нэртэй мөнгөн цутгамал болон амбан шар, атан тэмээ, агт морь, хонь мал, хадаг, цай, ангийн үс зэрэг таваар зэрэгцэн арилжаалагдаж, энэ нь эдийн засагт сөргөөр нөлөөлөх болжээ.

1911 онд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, Богд хаант Монгол Улсыг тунхаглав. 1921 онд Ардын хувьсгал ялж тусгаар тогтносон БНМАУ байгуулагдсанаар орчин үеийн мөнгөн тэмдэгтэй болох эхлэл тавигдсан гэхэд болно. Энэ үед Монгол Улс нь үндэсний банк, санхүү, мөнгөний системгүй, зах зээлд Хаант Орос, Хятадын цаасан тэмдэгт ноёрхож байсан үе.

Ардын хувьсгал ялсан эхний өдрөөс эхлэн үндэсний мөнгөн тэмдэгтэй болох зорилгыг төр, засгийн зүгээс тавьж байлаа. 1921 оны гуравдугаар сард үндэсний санхүүгийн системийн эх суурийг тавьж, 1924 оны зургадугаар сарын 2-ны өдөр Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк нээгдсэнээр эдийн засгийн шинэчлэл хийх мөнгөний бодлогыг цаашид хэрэгжүүлэх боломж бүрджээ. Үүний тулд улс орны мөнгөн гүйлгээг цэгцэлж, нэгэн хэмжүүрт шилжүүлэх шаардлага бий болж мөнгөний нэгжээр "лан"-г түр хэрэглэж бүх төрлийн тооцоог лангаар үйлдэхээр тогтоожээ. Нэг лан цэвэр мөнгөтэй Хятадын мөнгөн янчаан тэнцэнэ. Харин Оросын мөнгийг хоёр лантай тэнцэхээр тогтоосон байна.

Ингээд Ардын Засгийн газраас 1925 оны



1925 оны цаасан тэмдэгт

**Эдүгээ зоосон мөнгийг гүйлгээнээс хассан бөгөөд тусгай нөхцөл байдалд дурсгалын зоосыг цөөн тоогоор бүтээлгэдэг аж**

хоёрдугаар сарын 22-ны өдөр мөнгөний шинэчлэл хийх тухай түүхэн тогтоол гаргажээ. Уг тогтоолд, Мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онц эрхийг Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банканд олгох, Банкны тэмдэгт цаас нь мөнгөний нэгж болох төгрөгөөр 1, 2, 5, 10, 25, 50, 100-тийн дэвсгэртээр гаргах. Мөнгөн тэмдэгт бүрэн баталгаатай байвал зохино. 25-аас доошгүй хувь нь үнэт металлаар, 75 хувь нь түргэн борлогдох бараа материалаар батлагдана" гэж заасан байдаг.

Анх 1925 оны арванхоёрдугаар сарын 9-ний өдөр төгрөгийг гүйлгээнд гаргасан. Монголын үндэсний шинэ мөнгөн тэмдэгтээр 900 сорьцын 18 граммын жин бүхий цагаан мөнгөн зоосыг батлан гаргаж "төгрөг" гэж нэрлэн цагаан мөнгөн зоосны зэрэгцээгээр цаасан тэмдэгтийг гүйлгээнд нэвтрүүлсэн байна. Төгрөгийг

эхлээд гүйлгээнд гаргахдаа цалингаар дамжуулан гаргаж дараа нь улсын хэмжээний бүх албан газрын төсөвт зардлуудыг төгрөгөөр тооцдог болгожээ.

Төгрөгийг гүйлгээнд гаргасан үеэс үндэсний валют төгрөг, Хятадын янчаан хоёрын хооронд ширүүн тэмцэл өрнөж байлаа. Мөнгөний шинэчлэлт явуулах нь ард түмний ашиг сонирхолд нийцсэн хувьсгалт арга хэмжээ байсан учраас ард түмний дэмжлэгийг хүлээсэн байна. Засгийн газар болон Төв банкнаас үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах бэлтгэл ажлыг далайцтай зохиож, мөнгөн тэмдэгтийн ач холбогдлыг өргөн сурталчилж, мөнгөний шинэчлэлт хийхэд онцгой анхаарал тавьж байлаа.

Мөнгөний шинэчлэлт хийх хугацаанд 1926-1927 оны хооронд Монголбанкны үнэт эрдэнэ, металлын нөөц 4.2 дахин нэмэгджээ. 1925-1927 оны хооронд олон улсын байдалд зарим өөрчлөлт гарч дэлхийн зах зээлд цагаан мөнгөний үнэ буурч, алтны эрэлт хэрэгцээ өсөж ирсэнтэй уялдуулан төгрөгийн бат тогтвортой байдлыг хангах зорилгыг тавьсан юм. Ийнхүү 1927 онд хуралдсан Улсын бага хурлын шийдвэрийн дагуу тэр үед Монголбанканд хуримтлагдсан Улсын алт болон



▶ валютын фондод түшиглэн 1928 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдрөөс төгрөгийг алтан баталгаанд оруулжээ. Ингэснээр БНМАУ-ын үндэсний валют "Төгрөг" бат найдвартай валют болох үндэс суурь тавигдаж, 1928 оны наймдугаар сарын 1 гэхэд төгрөг нь албан ёсны алтан баталгаанд орж 51.8 америк центтэй тэнцэх болжээ.

## Монголбанк тусгай нөхцөлд дурсгалын зоосыг цөөн тоогоор бүтээлгэдэг

Улсын банкны мөнгөний фондыг өргөтгөж сэлбэх зорилгоор 1939, 1941, 1955, 1996 онуудад төгрөгийг шинээр хэвлүүлэн гүйлгээнд гаргажээ. Анх 1925 онд гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт дээрх бүх бичиг тоог монгол үсгээр бичиж, 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртэйгээр бүтээсэн байна.

1939 онд төгрөгийн дэвсгэртүүдийн хэмжээг өөрчлөхгүйгээр бүх дэвсгэртэд Д.Сүхбаатарын хөрөгтэйгөөр үйгаржин монгол бичгээр бичин хэвлүүлж, 2-тын дэвсгэртийг 3-тын дэвсгэртээр сольж гаргасан бөгөөд 1941 онд төгрөгийн хэмжээ, өнгө, хээг өөрчлөхгүйгээр зөвхөн бичиг тооны зарим хэсгийг кирилл үсгээр хэвлэжээ. Харин 1955 онд дэвсгэртүүдийн хэмжээг томсгож, зураг хээг өөрчлөн бүх бичиг тоог кирилл үсгээр хэвлэсэн байна. 1966 онд төгрөгийн ханшийг өөрчлөхгүйгээр дэвсгэрт бүрийн хэмжээг гүйлгээнд хэрэглэхэд тохиромжтой болгон жижгэрүүлж, өнгө, зураг урлалыг цоо шинээр өөрчлөн бүтээж, хэвлэн гаргасныг одоо гүйлгээнд хэрэглэж байна.

1966 оны мөнгөн тэмдэгтийн нөөцийг хуучин зураг загвараар нь 1981, 1983 онд сэлбэн хэвлүүлж, 1981 онд 20-тын дэвсгэртийг шинээр бүтээн гүйлгээнд нэмж хэрэглэсэн байна. 1925, 1939, 1941, 1955 онуудын мөнгөн тэмдэгтэд хуурамчаар үйлдэхээс хамгаалсан тусгай хийц байгаагүй, зөвхөн цаас, зураг хээ нь мөнгөн тэмдэгтэд зориулагдсан онцлог хийцээр бүтсэн байжээ. 1993 оны шинэ мөнгөн тэмдэгтийн дэвсгэрт дүрс нь өөр өөр өнгө, хэмжээтэй,

**2002 онд дахин хэвлүүлсэн 10000-ын дэвсгэртэд хамгийн сүүлийн үеийн нууц хийц болох өнгөө сольж гялалздаг "килограмм" хийцийг оруулсан**

500, 1000, 5000, 10000-тын дэвсгэртэд Их эзэн Чингис хааны хөрөг, 5, 10, 50, 100-тын дэвсгэртэд Д.Сүхбаатарын хөрөгтэй, түүхэн болон байгалийн зураг, төрийн туг, соёмбо, үндэсний хээ угалзаар чимэглэн бүтээжээ.

2002 онд дахин хэвлүүлсэн 10000-ын дэвсгэртэд хамгийн сүүлийн үеийн нууц хийц болох өнгөө сольж гялалздаг "килограмм" хийцийг оруулсан.

БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойгоор нэг төгрөгийн цагаан өнгөтэй зоосон мөнгө, Улсын банк байгуулагдсаны 50 жилийн ойгоор 10 төгрөгийн зоосон мөнгө цөөн тоогоор үйлдвэрлэсэн. Монголбанк дэлхийн улс орнуудын жишгийг харгалзан зоосон мөнгөнөөс гадна 20, 50, 100, 200 төгрөгийн зоосон төгрөг үйлдвэрлүүлэн 1996 онд гүйлгээнд гаргасан. 20, 50 төгрөгийн зоос нь дэвсгэртийн үнийн дүнгээр чимэглэсэн зурагтай, 100 төгрөгийн зоос

нь Жанрайсэг сүмийн, 200 төгрөгийн зоос нь Засгийн газрын ордны зурагтай. 2001 онд Ардын хувьсгалын 81 жилийн ойгоор Д.Сүхбаатарын хөрөгтэй 500 төгрөгийн зоосон мөнгийг тус тус гаргаж байжээ.

Орчин үед "Coin invest trust" компани "Бүргэд" мөнгөн зоос, "Чингис хаан" алтан зоос, "John F Kennedy" алтан ба мөнгөн зоос, "Морь" алт ба алтадсан мөнгөн зоос, "Чингис хаан" мөнгөн ба өнгөт мөнгөн зооснуудыг хэвлүүлж олон улсын зоос цуглуулагчдын зах зээлд гаргаад байна. Мөн олон улсын үзэсгэлэнгээс Монголын зооснууд шагнал хүртсэний дотор "Нохой зээх" цэвэр мөнгөн зоос нь Германы Берлинд болсон Дэлхийн мөнгөний үзэсгэлэнгээс олон улсын шагнал "Оны шилдэг зоос (coin of the year)",

мөн "Шилдэг мөнгөн зоос (Best silver coin of the year)" шагналуудыг хүртжээ. Харин "Хув ууль" цэвэр мөнгөн зоос нь "Хамгийн алдартай зоос" (Most popular coin), Москва хотод болсон олон улсын дурсгалын зоосны YI уралдаанаас "Оны шилдэг мөнгөн зоос" төрөлд гуравдугаар байрын шагналыг тус тус хүртжээ. ■



**"Nimravidae" франчайз дурсгалын зоос 2023 оны "Шилдэг эртний зоос" төрөлд шилдгээр шалгарав**



## Гадаад валют

# Валютын ханшийн бодлого, нөөцийн удирдлага

Монгол Улс нь нээлттэй, жижиг эдийн засагтай. Дээр нь гадаад худалдааны бүтэц нь цөөн тооны томоохон экспортлогчидтой, харин тоо хэмжээгээрээ илүү олон тооны жижиг импортлогчидтой. Энэ нь дотоодын валютын захад богино хугацааны хэлбэлзэл үүсэхэд нөлөөлж байдаг. Иймээс Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед оролцдог.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан байдлаар өөрчлөгдөх нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Эдийн засгийн суурь нөхцөл нь олон хүчин зүйлсээс хамаарсан, өргөн үтгатай ойлголт юм. Тухайлбал, эдийн засгийн суурь хүчин зүйлсэд худалдааны түнш орнуудын эдийн засгийн төлөв болон гадаадын хөрөнгө оруулалт зэргээс дотоод эдийн засгийн хамаарал, экспортын болон импортыг орлуулах салбарын өрсөлдөх чадвар, худалдааны нөхцөл, төлбөрийн тэнцэл болон гадаад өрийн төлөв, Засгийн газар, өрх болон хувийн секторын өрийн байдал, зээл, хадгаламжийн долларжилт, гадаад валютын нөөцийн хүрэлцээтэй байдал, валютын ханшийн инфляцад үзүүлэх нөлөө зэрэг нь хамаарна.

Монголбанк валютын ханшийн бодлогодоо гадаад худалдааны өрсөлдөх чадвар санхүүгийн тогтвортой байдал зэргийг харгалздаг. Тухайлбал, “Ковид-19” цар тахлын үед хил хаагдаж, валютын орлого тасарсан нөхцөлд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларснаар өргөн хэрэглээний зардал өсөж, иргэд, аж ахуйн нэгжид нэмэлт дарамт учрахаар байв. Иймд Төв банк ханшийн бодлогодоо тухайн нөхцөл байдлыг давхар харгалзан үзэж байв.

**Монголбанк сүүлийн таван жилийн хугацаанд 100 гаруй тонн үнэт металл худалдан авч, ГВУН-г нийт 4.0 тэрбум ам.доллаароор нэмэгдүүлэв**

## Гадаад валютын улсын нөөц

Монголбанк нь Гадаад валютын улсын нөөц/ГВУН/-ийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасны дагуу нэн тэргүүнд гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон нөөцийн найдвартай байдлыг чухалчлан эрэмбэлж, эдгээр нөхцөл бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг удиртгал болгон ажилладаг.

ГВУН-ийг хуульд заасан шаардлагын дагуу дэлхийн тэргүүлэгч эдийн засагтай орнуудын төв банк, олон улсын банк, санхүүгийн байгууллага болон зээлжих зэрэглэл өндөртэй гадаадын арилжааны банкуудад харилцах, хадгаламж, богино хугацаат үнэт цаас хэлбэрээр байршуулан удирддаг. Нийт нөөцийн тодорхой хэсгийг урт хугацаат багц болгон хөгжингүй орнуудын Засгийн газар, олон улсын банк, санхүүгийн байгууллагын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх замаар батлагдсан жишиг өгөөжийг давуулан биелүүлэх зорилтын хүрээнд ажилладаг.


ГВУН 2024 оны гуравдугаар сарын байдлаар 5,249.8 сая ам.долларт буюу түүхэн дээд хэмжээнд ▶

## Төлбөрийн тэнцэл болон төгрөгийн ам.долларт харьцах ханшийн өөрчлөлт

сая ам.доллар



- хүрсэн. Банкны системээр дамжин орж ирэх гадаад валютын орох цэвэр урсгал сайжирч, экспортын орлого нэмэгдэн гадаад худалдааны тэнцэл ашигтай хэвээр байгаа нь ГВУН-ийн хэмжээ өсөхөд голлон нөлөөлсөн. Ингэснээр ГВУН-ийн хүрэлцээт байдал валютын төлбөртэй импортын барааны 7.5 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрч нэмэгдэв.



Монгол Улсын Засгийн газраас 2024 онд төлөх хуваарьтай гадаад бондыг дахин санхүүжүүлэх замаар өрийн менежментийг амжилттай гүйцэтгэсэн нь ГВУН-д үзүүлэх гадаад зээлийн эргэн төлөлтийн дарамтыг бууруулсан.

Монголбанк дотоодын зах зээлээс худалдаж авсан алтыг цэвэршүүлж, мөнгөжүүлсэн орлогоос Хятадын Ардын Банк (ХАБ) -тай байгуулсан своп хэлцлийн хүрээнд 2011–2016 оны хооронд ашигласан хэлцлийн нийт дүнгээс 2.5 тэрбум юань буюу 350 орчим сая ам.долларын эргэн төлөлтийг хугацаанаас нь өмнө урьдчилан гүйцэтгэсэн. Свop хэлцлийн нийт ашиглалтаас урьдчилан хааж эхэлсэн нь төв банкны хүүний зардлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж, Олон Улсын Валютын сан (ОУВС) болон бусад олон улсын санхүүгийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чухал үйл явдал болсон.

Монголбанк нь ГВУН-ийн удирдлагын хүрээнд харилцагч гадаадын банк, санхүүгийн байгууллагуудыг төрөлжүүлж, олон улсын томоохон банкуудтай харилцаа холбоогоо

өргөжүүлэх, сайжруулах чиглэлд тогтмол анхаарч, арилжааны банкуудын гадаад төлбөр тооцооны сүвгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ингэснээр Монгол Улс ФАТФ байгууллагын “Саарал жагсаалт”-аас гарсан цагаас хойш анх удаа дотоодын арилжааны банкууд ам.долларын шууд клирингийн данс нээх боломж бүрдэж, эхний ээлжид Худалдаа Хөгжлийн банк нь АНУ-ын “The Bank of New York Mellon” (BNY Mellon) банканд клирингийн данс нээж, төлбөр тооцоонд ашиглаж эхэлсэн. Энэ нь Монгол Улсын гадаад төлбөр тооцооны тасалдалгүй байдлыг хангах, арилжааны банкны харилцагчдад ам.долларын гадаад төлбөр тооцооны үйлчилгээг өртөг багатай түргэн шуурхай үзүүлэхэд чухал ач холбогдолтой.

## Алтны үнэ ханш, дэлхийн чиг хандлага



Алт нь аюулгүй байдал, хөрвөх чадвар, өгөөжтэй байдлаараа төв банкуудын нөөцийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Иймээс төв банкууд алтны томоохон эзэмшигчид байдаг. Үүний нэгэн адил Монголбанк нь “Эрдэнэсийн сангийн тухай хууль”-д заасны дагуу ГВУН-ийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс алт худалдан авч гадаадад цэвэршүүлэн мөнгөжүүлдэг. Сүүлийн таван жилийн хугацаанд 100 гаруй тонн үнэт металл худалдан авч, ГВУН-г нийт 4.0 тэрбум ам.доллараар нэмэгдүүлж ажиллалаа.

Мөнгөжсөн алт нь олон зууны турш дэлхийн төв банкуудын ГВУН-ийн чухал бүрдэл хэсэг байсаар ирсэн. Сүүлийн жилүүдэд тэргүүлэх эдийн засагтай орнуудын төв банкууд алтны худалдан авалтаа эрчимтэй нэмэгдүүлж, 2023 оны эцсийн байдлаар нийт 36.7 мянган тонн алтны нөөцийг бүрдүүлээд байна. Геополитикийн асуудал болон эдийн засаг, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан алтны ханш тогтвортой өсөлттэй байгаа нь Төв банкуудын худалдан авалтад гол нөлөө үзүүлж байна.

Монголбанкны хувьд ГВУН-ийг нэмэгдүүлэх зорилгоор жилд 20-24 тонн үнэт металл худалдан авдаг. Хариуцлагатай алт олборлолтыг дэмжих замаар, дотоодын арилжааны банкууд, төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. ►

**Нэг унц алтны ханш 2024 оны эхний улиралд 2,229.87 ам.доллар унц хүрч хаагдсан бол, өнгөрсөн дөрөвдүгээр сарын дундуур 2,400.00 ам.долларыг давж түүхэн дээд түвшнийг эвдлээ**

### Олон улсын зах зээл дээрх алтны ханш болон ам.долларын бондын өгөөж



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк дотоодын зах зээлд олборлосон алтыг худалдан авч мөнгөжүүлэхдээ, олон улсын зах зээл дээрх эдийн засгийн тоон үзүүлэлтүүд, хөрөнгө оруулагчдын хандлага болон хүлээлт, геополитикийн нөхцөл байдал, хөгжингүй орнуудын төв банкны бодлогын хүүний төсөөлөл зэрэг мэдээллийг шинжлэн судалж, шийдвэр гаргахад ашигладаг.

Нэг унц алтны ханш 2024 оны эхний улиралд 2,229.87 ам.доллар унц хүрч хаагдсан бол, өнгөрсөн дөрөвдүгээр сарын дундуур 2,400.00 ам.долларыг давж түүхэн дээд түвшнийг эвдсэн. ОХУ ба Украйны зөрчилдөөн болон Ойрх Дорнодод өрнөж буй цэргийн ажиллагаа, хариу халдлагууд нь геополитикийн нөхцөл байдлыг хүрцэтгэж, алтны ханшийг түүхэн дээд хэмжээндээ хүрч өсөхөд голлон нөлөөллөө. Цаашид гадаад зах зээлд өрнөж буй зэвсгийн мөргөлдөөн, төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын өөрчлөлт, улс хоорондын харилцаа зэрэг улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны нөлөөгөөр алтны ханшийн хөдөлгөөн тодорхойлогдох хүлээлттэй байна. Олон улсын банк санхүүгийн байгууллагын шинжээчдийн зүгээс 2024 онд нэг унц алтны дундаж ханшийг 2,175.0 ам.доллар байх таамаглалыг дэвшүүлээд байна.

### Үнэт металлын үйл ажиллагаа

Монголбанк 2020 онд 20.8 тн, 2021 онд 20.8 тн, 2022 онд 22.9 тн, 2023 онд 17.86 тн, 2024 оны дөрөвдүгээр сарын эцсийн байдлаар 4.3 тн

үнэт металл худалдан авсан. Худалдан авсан үнэт металлаас мөнгөжүүлэн гадаад валютын дансанд 160 ширхэг гүлдмай буюу хоёр тонн жин бүхий 999.9 сорьцтой алтан гүлдмайг биетээр хадгалж байна.

Монголбанк нь үнэт металл худалдан авах ханшийг өдөр бүр дэлхийн зах зээлийн үнээр шинэчлэн тогтоодог буюу “LBMA” Лондонгийн үнэт металлын зах зээлийн ханшийг ашигладаг. Түүнчлэн, алт олборлогч аж ахуй нэгж болон иргэдээс үнэт металл худалдан авахдаа олон улсад итгэмжлэгдсэн лабораторийн сорьцын шинжилгээний үр дүнд үндэслэн худалдаж авдаг бөгөөд худалдан авах үйл ажиллагааг түргэн шуурхай, хялбар байдлаар зохион байгуулахад онцгой анхаарч байна.

Үнэт металл олборлогч аж ахуй нэгж, иргэдийн төвлөрөл бүхий Дархан-Уул, Баянхонгор аймгуудад үнэт металлын сорьцын шинжилгээний лаборатори байгуулж, алт олборлогч аж ахуй нэгж, иргэдэд олон улсын зах зээлийн ханшаар үнэт металлаа худалдах боломжийг бүрдүүлэн, сорьцын шинжилгээний үр дүнг цахимаар хүлээн авч, төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх зэрэг ажлыг үе шаттайгаар зохион байгуулав. Үнэт металлын арилжааг албажуулах зорилгоор цагаан мөнгийг импортолж, гүлдмай, үрлэн хэлбэртэйгээр уран дархчууд болон бусад иргэд аж ахуй нэгжүүдэд худалдаалах ажлыг эхлүүлсэн болно. ■

**Цаашид улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны нөлөөгөөр алтны ханшийн хөдөлгөөн тодорхойлогдох хүлээлттэй байна**

### Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ



Эх сурвалж: Монголбанк



## Үндэсний төлбөрийн систем

Дэвшилтэт технологид суурилсан  
үндэсний төлбөрийн систем

Төв банкны  
цахим мөнгө  
гаргахад эрх  
зүйн орчин,  
дэд бүтэц,  
хүний нөөцийг  
хөгжүүлэх,  
технологийн  
шийдлийг  
тодорхойлох  
шаардлага  
үүссэн.  
Монголбанк  
энэ асуудлыг  
олон талаас  
нь судалж  
байна



## Төлбөрийн системийн бодлого, стратеги

Монголбанк нь төлбөрийн системийн үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэж, үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн бодлогыг тодорхойлж, нийт хэрэглэгчийн хэрэгцээг бүрэн хангасан, түргэн шуурхай, найдвартай, тасралтгүй ажиллагаатай төлбөрийн системийг хөгжүүлж ажилладаг.

Монгол Улсын ҮТС-ийн шинэчлэл “Үндэсний төлбөрийн системийг 2009-2014 онд хөгжүүлэх стратеги”-ийг хэрэгжүүлснээр эхэлсэн. ҮТС-ийн хөгжлийг хангах зорилгоор 2015-2020 онд дараагийн стратегийг хэрэгжүүлсэн. Эдгээрийн үр дүнд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг боловсруулан 2017 оны тавдугаар сарын 31-ний өдөр УИХ-аар батлуулж, 2018 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэхууль нь Үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах үүрэг, хариуцлагыг Монголбанканд олгож, эрх зүйн хувьд баталгаажуулсан. Мөн цахим

мөнгө, төлбөрийн карт, зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбоотой журмуудыг боловсруулж, эрх зүйн орчныг бэхжүүлэх чухал алхам болсон. Дебит, кредит шилжүүлэг, бодит цагийн гүйлгээ дэмждэг Автомат клиринг хаус систем, картын гүйлгээний аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний брэнд ₮ карт, Картын нэгдсэн сүлжээний шинэчлэлийг тус тус хийж ирлээ.

Их дүнтэй гүйлгээний Банксүлжээ (RTGS) систем нь Монгол Улсын төлбөрийн системийн үндсэн дэд бүтэц бөгөөд 2009 онд нэвтрүүлж, хоёрдугаар үеийн шинэчлэлийг 2018 онд хийж гүйцэтгэсэн. Банксүлжээ систем нь хөрөнгийн удирдлагын олон хэрэгслийг багтаасан олон улсын стандарт бүхий систем ба одоогоор таван сая төгрөгөөс дээш дүнтэй бүх гүйлгээ энэхүү системээр дамжиж байна.

Монголбанк нь “Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги 2022-2026” баримт бичгийн төслийг боловсруулж баталсан. Энэхүү стратеги нь аюулгүй, найдвартай, ►

- үр ашигтай, хэрэглэгч төвтэй төлбөрийн системийг цогцлоох, төлбөрийн үйлчилгээг цахимжуулахад чиглэж байна.

Тус стратегийн хүрээнд 2023 онд “Токен баталгаажуулах систем”-ийг нэвтрүүлсэн. Тухайн систем нь төлбөрийн картын мэдээллийг токенжуулан бүртгэлжүүлж, төлбөр тооцоонд ашиглах зориулалт бүхий систем бөгөөд мобайл болон бусад төхөөрөмж дээр тухайн токеныг ашиглан төлбөр тооцоо хийх боломж олгосон дэд бүтэц юм. Төлбөрийн картын өгөгдлийг токенжуулснаар хэрэглэгчийн картын мэдээлэл бусдад алдагдах, хуурамч, луйврын болон залилангийн гүйлгээ гарах эрсдэлийг эрс бууруулж, интернэт, мобайл буюу гар утас, цахим хэтэвч зэрэг биет бусаар карт ашиглан төлбөр тооцоо хийх нөхцөлд санхүүгийн мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан.

- “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд 2023 оны зургадугаар сарын 16-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон Төв банкны арилжааны нэгдсэн систем (ҮЦТХНС)-ийг нэвтрүүллээ. Энэхүү систем нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, Мөнгөний захын арилжааны систем, Валютын арилжааны систем гэсэн гурван үндсэн хэсэгтэй. Тус системийг нэвтрүүлснээр шинэ боломжууд нээгдсэн.
- Монголбанк болон ҮЦТХТ нь арилжаалагдаж буй бүх төрлийн хаалттай болон нээлттэй санхүүгийн хэрэгслүүд болох Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас, хувьцаа, компанийн бондын хадгаламж, бүртгэл болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг нэгдсэн байдлаар бүртгэх боломжтой болсон.
- Дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчдыг татах, тэдний эрх ашгийг хамгаалах боломж сайжирсан.
- ҮЦТХНС нь Банк сүлжээ болон Автомат клиринг хаус системтэй интеграци хийж ажилласнаар хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцоо найдвартай, үр ашигтай, хялбар болж хөрөнгө оруулагчдын эрх ашиг хангагдах боломж нэмэгдсэн.
- Мөнгөний зах зээл, хөрөнгийн зах зээл, валютын зах зээлийг банкны системтэй холбож, харилцан уялдаа холбоотой болсноор зах зээл дэх хөрвөх чадварыг дээшлүүлэн

**Банксүлжээ систем нь хөрөнгийн удирдлагын олон хэрэгслийг багтаасан олон улсын стандарт бүхий систем юм**

санхүүжилтийн өртгийг багасгах болсон.

- Дотоодын зах зээлийг олон улсын санхүүгийн зах зээлтэй дэд бүтцийн хувьд шүүд холбоход нэгдсэн стандарттай болсон.

Үнэт цаасны эрсдэлийн удирдлага, барьцааны удирдлага болон барьцааны үнэлгээний удирдлагыг олон улсын зарчмын дагуу хэрэгжүүлэх болсон.

Дэлхий дахинд финтек компаниуд шинэлэг шийдэл бүхий төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлж, төлбөр төлөх зан төлөв өөрчлөгдөж, шинэ эрсдэлүүд үүсэж байна. Зөвхөн технологид суурилсан, баялгаар баталгаажуагүй крипто-валют бий болж, зарим оронд түүгээр төлбөр тооцоо хийх нь олон улсын эдийн засаг, санхүүгийн салбарт тодорхой бус байдал үүсгэх болсон. Энэ асуудлыг шийдэх зорилгоор Төв банкнууд Төв банкны цахим мөнгө (ТБЦМ) гаргах талаар судалж байна.

Манай орны хувьд ТБЦМ гаргахад эрх зүйн орчин, дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлэх, энэ талаар хийж буй судалгаа, шинжилгээний үр дүнг харьцуулах, хөгжүүлэх үлмаар өөрийн орны онцлогт тохирох загвар, технологийн шийдлийг тодорхойлох шаардлага үүссэн. Монголбанк энэ асуудлыг олон талаас нь судалж байна.

## Үндэсний цахим гүйлгээний төв

Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) нь Монгол Улсын хэмжээнд клирингийн үйлчилгээ буюу оролцогч хоорондын бага дүнтэй болон төлбөрийн картын гүйлгээг түргэн, шуурхай, найдвартай гүйцэтгэх, бэлэн бус төлбөрийн шинэ хэрэгслийг төлбөр тооцоонд харилцан ашиглах зорилгоор 2005 онд “Төлбөр тооцооны төв” нэртэйгээр байгуулсан. 2006 оны хоёрдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн улс даяар оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээг ►

## 2023 оны байдлаар улсын хэмжээнд

**4.3 САЯ** ИДЭВХТЭЙ  
КАРТ ЗЭЭМШИГЧ **2.2 САЯ**

► өөрийн нэгдсэн сүлжээгээр дамжуулж эхэлсэн.


ҮЦГТ байгуулагдсан цагаас хойш томоохон ажил, төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа нь Монгол Улсын төлбөр тооцооны системийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, 2010 оны тавдугаар сарын 16-ны өдөр банкнуудтай хамтран оролцогч хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээг байгуулж, төлбөрийн картын төлбөр тооцоог 24/7 цагаар тасралтгүй үзүүлэх болсон. Энэ нь бэлэн бус төлбөр тооцоог дэмжиж, картын хэрэглээ өсөн нэмэгдэх хөшүүрэг болсон. Үндэсний мөнгөн тэмдэгтийг нэрийдэн, олон улсын төлбөрийн карттай дүйцэхүйц өндөр нууцлал бүхий төлбөрийн “F- карт”-ыг 2012 онд нэвтрүүлсэн нь бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэхэд чухал алхам болсон.

БНХАУ-ын “Юнион Пэй Интернэшнл” олон улсын картыг 2012 онд, Япон улсын “JCB” олон улсын картыг 2013 онд улсдаа хүлээн авах нэгдсэн гарцыг бий болгосон. 2014 онд бага дүнтэй төлбөр тооцоог бодит цагийн буюу онлайн 24/7 цагийн горимоор тасралтгүй дамжуулж эхэлж, банкнууд интернэт банк, цахим банк, дижитал банкны үйлчилгээг өргөнөөр дэлгэрүүлэх болсон.

Монголбанк нь төлбөрийн системийг хөгжүүлэх, төлбөр тооцооны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг 2016 онд эхлүүлсэн. Төслийн үр дүнд бэлэн бус төлбөрийн шинэ хэлбэрүүд нэвтэрч, төлбөрийн системийн дэд бүтэц, програм хангамжийг улам боловсронгуй болгож, өрсөлдөх чадвар бүхий өндөр нууцлалтай, уян хатан цахим төлбөр тооцооны системийг бий болгосон. Төслийн хүрээнд 2019 онд нэвтрүүлсэн томоохон систем бол мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бэхжүүлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллагуудад зориулсан тоон гарын үсгийн систем юм. Тус систем нь цахим орчинд дамжигдаж буй баримт бичгийн бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг баталгаажуулдаг, хуулиар баталгаажсан дижитал технологи бөгөөд тоон гарын үсгийн системийг ашигласнаар мэдээллийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах юм.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ҮЦГТ-ийн ажиллуулж байсан бага дүнтэй гүйлгээний системийг шинэчилж, олон улсын стандартыг хангасан

Бодит цагийн гүйлгээ (RTP)



Эх сурвалж: Монголбанк

**Тоон гарын үсгийн системийг ашигласнаар мэдээллийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах юм**

“Автомат Клиринг Хаус” буюу АСН+ системийг 2019 онд нэвтрүүлсэн. АСН+ систем нь кредит болон дебит багцын гүйлгээ, бодит цагийн горимын гүйлгээг дамжуулах, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийг дэмжих чадавхтайгаараа онцлог юм. Тус системийг нэвтрүүлснээр төлбөр тооцоог 24/7 бодит цагийн горимоор гүйцэтгэх, ижил төрөл, зориулалт бүхий олон тооны масс гүйлгээг багцлан илгээх, төлбөрийн нэхэмжлэлд үндэслэн дебит гүйлгээ үүсгэх, харилцагчийн нэр, данс зөрөх алдааг арилгах, дансны нэгдсэн санг ашиглах, хөрөнгийн дутагдлын эрсдэлийг хязгаарлах нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх болон шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн гүйлгээг дамжуулах боломжууд бүрдсэн. Тухайлбал, Засгийн газраас хэрэгжүүлж буй хүүхдийн мөнгө, тэтгэвэр тэтгэмж, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашиг, Ковид-19 цар тахлын хүрээнд олгосон мөнгөн тэтгэмжүүд, НДШ-ийн 50 хувийн буцаан олголт зэрэг гүйлгээг банкнуудад багцлан түргэн шуурхай илгээж байна.

Үндэсний төлбөрийн системийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийн шинэ боломжийг бүрдүүлэх зорилгоор 2020 онд ҮЦГТ-ийн барилгыг шинээр барьж, ашиглалтад оруулах бүтээн байгуулалтын ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Монголбанк нь олон улсын TIER II түвшинд магадлан итгэмжлэгдсэн дата төвтэй ►



► болсон бөгөөд орчин үеийн дата төвийн дэд бүтэц, технологийн шийдлээр бүрэн тоноглогдсон уг дата төвийг ашиглалтад оруулснаар үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, үүсэж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн.

ҮЦГТ-ийн төлбөрийн картын системийг бүрэн шинэчилж, шинэ төрлийн гүйлгээг дэмжих, системийн нууцлал аюулгүй байдал, системийн ачаалал, гүйлгээ боловсруулах хүчин чадлыг бүрэн хангасан, олон улсын стандартад нийцсэн цогц системийг 2021 онд нэвтрүүлсэн. Системийн оролцогчид нөөцийн удирдлага, хөрөнгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, маргаантай болон алдаатай гүйлгээг харилцан тохиролцож шийдвэрлэх боломжтой болсон төдийгүй, системийн тохиргоо, хүчин чадлаас хамаарч алдаатай, амжилтгүй гүйлгээний тоо, дүн буурах нөхцөл бүрдсэн.

Ийнхүү төлбөрийн системийн оролцогчид хүрээгээ тэлж, зөвхөн банкнууд, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь нэгдсэн сүлжээнд холбогдсон байсан бол одоо банк бус банхүүгийн байгууллага, финтек компаниуд Монголбанкны клирингийн төвийн нэгдсэн сүлжээнд холбогдож, гүйлгээгээ дамжуулах боломжтой болсон.

### 2023 онд “Токен баталгаажуулах систем”-ийг нэвтрүүлэв

Сүүлийн таван жилийн хугацаанд бодит цагийн гүйлгээний тоо жилд дунджаар 45, төлбөрийн картын гүйлгээний тоо 24 хувиар тус тус өссөн ба 2023 оны байдлаар улсын хэмжээнд нийт 4.3 сая карт эзэмшигч байгаагаас 2.2 сая нь идэвхтэй ашиглагдаж байна.


### Төлбөрийн системийн хяналт

Монголбанкнаас төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн хэрэгсэл гаргагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий этгээд болон операторын зохистой засаглал, удирдлага, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбогдох харилцаа, систем хоорондын хамаарлыг зохицуулсан журам, дүрэм, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Ийнхүү хяналт тавих нь системийн эрсдэлийг хязгаарлан, хэрэглэгчийн болон эдийн засгийн хэрэгцээг хангаж, найдвартай, үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулах зорилготой.

Олон улсын төлбөр тооцооны банк болон Үнэт цаасны хорооноос гаргасан олон улсад нийтлэг мөрдөж буй зарчмуудад Төв банк нь хяналтын зорилгод нийцсэн эрх, үүрэгтэй байх, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрх, хүчин чадалтай байхыг шаарддаг тул Төв банк / Монголбанк/-ны тухай хуульд Монголбанк нь Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих заалт оруулсан.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд Монголбанк төлбөрийн системийг бүхэлд нь болон бүрэлдэхүүн хэсгийг зохицуулах, хянах талаар тусгаж, төлбөрийн системд хяналт тавих үүргийг Монголбанканд хүлээлгэжээ. Монголбанкнаас “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д хяналт шалгалтад баримтлах зарчмыг тодорхойлсон бөгөөд төлбөрийн системийн хянан шалгагч нар холбогдох хууль тогтоомж болон “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээр мөрдүүлэхэд анхаарч, төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлж байна. ■

### Картын гүйлгээ



Эх сурвалж: Монголбанк

## Хяналт шалгалт

# Банкны салбарт хийсэн “хувьсгалууд”

**М**онголбанк байгуулагдсанаас хойших 100 жилийн хугацаанд банкны салбарын хөгжлийн замналыг гурван үе шатад хуваан үзэж болох юм. Үүнд:


**1921-1990:** Үндэсний банк байгуулагдаж, бэхэжсэн үе

**1991-2020:** Банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжиж, бэхэжсэн үе

**2020:** Банкны салбарын зохистой засаглалын реформ хэрэгжсэн үе

Банкны салбарын зохицуулалт нь банкны салбарын хөгжлөө дагаад тасралтгүй сайжрах, өөрчлөн шинэчлэгдэх шаардлагатай тул банкны үйл ажиллагаанд тавигдах хяналт шалгалт зохицуулалтууд олон улсын зарчим стандартыг шингээн, улам боловсронгуй болж, сайжирсаар байна.

1921-1990 оны хооронд банкны тухай тусгайлсан хууль, тогтоомж байгаагүй ч банкны үйл ажиллагаатай холбоотой харилцааг дүрэм, журам болон Иргэний хуулиар зохицуулж байв. 1940 оноос банкны салбараар хийх төлбөр тооцоо нэмэгдэж, нарийвчилсан журам заавартай болж, Монголбанк нь төлбөр тооцоо, санхүүжилтийн төв болсон юм. Ингэснээр Монголбанк нь Монгол Улсын санхүүгийн бүх харилцааны төв болж, ►



▶ банкны зээл, төлбөр тооцоо, касс зэрэг бүхий л үйлчилгээ хэт төвлөрсөн байдал нь нэмэгдэж, түргэн шуурхай хүртээмжтэй байдал нь алдагдаж эхэлсэн нь хоёр шатлалт банкны тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагыг бий болгосон юм.

1990 оноос Монгол Улс зах зээлийн зарчмын дагуу банкны хоёр шатлал бүхий тогтолцоонд шилжиж, анхны арилжааны банкнууд үүсгэн байгуулагдаж эхэлсэн. Монголбанкны зөвшөөрлөөр Монгол хоршоо, үйлдвэрийн хувь нийлүүлсэн банк, Монгол даатгал банк, Худалдаа хөгжлийн банк, Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банкнууд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Энэ үед арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулах хууль, дүрэм журмыг хараахан гаргаагүй байлаа. Эдгээр арилжааны банк үүсгэн байгуулагдсанаар банкны салбарт системийн шинжтэй томоохон өөрчлөлт бий болж, Төв банкны хувьд арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгах томоохон үүрэгтэй болсон юм. Мөн банкнуудын үйл ажиллагаа жигдрээгүй, хууль эрх зүйн зохицуулалт хангалттай бий болоогүй, банкны салбарын боловсон хүчний мэргэжлийн мэдлэг чадвар дутмаг, банкны салбарын үйл ажиллагааны талаарх ард иргэдийн ойлголт муу зэргээс үүдэн банкуудын үйл ажиллагаа тогтворгүй, банкууд олноороо төлбөрийн чадваргүй болж, дампуурч байсан юм.

Банкны салбарт учирсан хүндрэл бэрхшээл, хэд хэдэн банкны дампуурал нь Төв банкны зүгээс банкны салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, банкнуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нь банкны салбарын тогтвортой байдал, банкнуудын хэвийн үйл ажиллагааг хангахад амин чухал болохыг ойлгуулсан. Ийнхүү банкны салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг шуурхайлж, 1991 оны дөрөвдүгээр сард Банкны хуулийг баталж, Төв банкныг Монгол Улсын мөнгө, зээлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий банкаар тогтоож, Төв банкны үйл ажиллагааг зохицуулсан Төв банкны тухай хуулийг 1996 онд баталсан. Мөн түүнчлэн банкны салбарын үйл ажиллагааны голлох хуулиуд болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Векселийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн

**Хувьцаа  
эзэмшигчдийн  
тоо 150 орчим  
байснаас  
70 гаруй  
мянга болж  
нэмэгдэн,  
нийт 473  
тэрбум  
төгрөгийн  
эх үүсвэрийг  
дотоодын зах  
зээлээс татан  
төвлөрүүлжээ**

этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Аудитын тухай хууль зэргийг баталж, банкны салбарын хууль эрх зүйн орчин бий болох үндсэн суурь тавигдсан юм.

2000-2009 оны хооронд банкны салбарт харьцангуй тогтворжилтийн үе эхэлж банкнуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн харьцаа, зээлийн чанар сайжирч, банкны салбар мэргэшсэн боловсон хүчинтэй болж, банкнуудын үйл ажиллагаа төлөвшиж ирсний зэрэгцээ банкны үйл ажиллагаанд тавигдах, шаардлага, хууль эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж байлаа. Тухайлбал, Монголбанкнаас 2002 онд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2005 онд Мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2008 онд Банк дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль, 2009 онд Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийг тус тус боловсруулан, батлуулж, банкны салбарын хууль эрх зүйн орчин, банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцооны үндэс суурийг улам бэхжүүлсэн билээ.

Ингэснээр 2010 оноос банкны салбарын үйл ажиллагаа улам өргөжин дэвшиж, арилжааны банкнуудын үйл ажиллагааны цар хүрээ тэлж, банкнууд үйл ажиллагаандаа олон улсын шинэ технологийг нэвтрүүлж эхэлснээр Монгол Улсын банкны салбар дэлхийн улс орнуудтай мөр зэрэгцэх, хөгжил дэвшлийн үе эхэлсэн юм. Банкнуудын үйл ажиллагаа өргөжиж, банкууд олон төрлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхийн хэрээр банкны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжууд шинэчлэгдэн, сайжирч, банкны хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, банканд хяналт, шалгалт хийх эрх бүхий хянан шалгагчдад бүрэн эрх олгох зэрэг шаардлага үүсч, Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2010 онд батлуулснаар банкны хяналт, шалгалтын үйл ажиллагаа олон улсын хяналт шалгалтын Базелийн зарчим стандартад ойртсон, дэвшилтэт үйл явдал болсон юм.

Мөн энэ үеэр банкны салбарын тогтвортой байдлын үндсэн тулгуурын нэг болох ▶



► хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгон, банкн дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлж, 2012 онд Банкн дахь Мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг батлуулсан нь банкны салбарын тогтвортой байдлыг улам бэхжүүлэв.

Үүний зэрэгцээ банкны үйл ажиллагаанд тавигдах зохистой харьцааны шаардлагыг бий болгож, банкны зохистой засаглал, эрсдэлийн удирдлагад тавигдах шаардлага, банканд хийх байнгын хяналт шалгалт, төлбөрийн чадваргүй болсон банканд хийх албадлагын арга хэмжээний зохицуулалтыг олон улсын сайн туршлага, өөрийн орны туршлагад үндэслэн бий болгож, банкны хяналт шалгалт дараагийн түвшинд хүрсэн юм. Энэ үеэс эхлэн банкны хяналт, шалгалтыг олон улсын Базелийн стандартад нийцүүлэх ажил эрчимжиж, Монголбанкнаас 2014 онд Банкны хяналт, шалгалтын дүнд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг баталж, банкуудад хийх хяналт шалгалтыг хөгжүүлэх нэгдсэн бодлогын баримт бичгийг бий болгосон юм. Энэхүү баримт бичгийн үндсэн зорилго нь үр нөлөөтэй, оновчтой хяналт, шалгалтын үйл ажиллагааг хөгжүүлэх, олон улсад түгээмэл нэвтрүүлэх болсон мөчлөг сөрсөн, эрсдэлд суурилсан зохицуулалтыг банкны хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, системийн шинжтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх макро зохистой бодлогын арга хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг байсан бөгөөд уг стратегийн дагуу банкны хяналт, шалгалт зохицуулалт улам боловсронгуй болж, хяналт шалгалтын үр нөлөө сайжирсан билээ.

Банкны салбарын хууль эрх зүйн орчин сайжирч, банканд тавих хяналт, шалгалтын үйл ажиллагаа олон улсын жишиг стандартад нийцтэй байсан хэдий ч зарим банк төлбөрийн чадваргүй болж, татан буугдаж байсан нь ихэнх тохиолдолд банканд зохистой засаглал алдагдаж байсантай холбоотой байсан. Энэ үйл явдал, сургамж нь банкны салбарт дараагийн реформыг эхлүүлэх, банкуудын зохистой засаглалыг сайжруулах шийдвэртэй алхмыг хийх шаардлагыг Төв банканд бий болгосон юм.

**1990 онд Төв банкны хувьд арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгах томоохон үүрэгтэй болов**

Ийнхүү банкны зохистой засаглалыг сайжруулах зорилгоор Монголбанкнаас банкуудын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах үндсэн зорилго бүхий Банкны салбарын дүнд хугацааны шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2021 онд УИХ-аар батлуулж, банкуудыг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөгдөн байгуулах, хувь эзэмшлийн төвлөрлөө бууруулах хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн. Энэхүү хууль, эрх зүйн өөрчлөлтийг банкны салбарт хийсэн хоёр дахь “хувьсгал” гэж нэрлэж болох бөгөөд банкны салбар дахь засаглалын асуудлыг шийдвэрлэх томоохон системийн шинжтэй өөрчлөлт юм.

Энэхүү хөтөлбөрийн үр дүнд банкны салбарт үйл ажиллагаагаа явуулж буй бүх арилжааны банк хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн бөгөөд системд нөлөө бүхий банкууд Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк нь 2023 онд анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгож, компанийн хэлбэрээ өөрчлөн нээлттэй хувьцаат компани болж үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ. Системийн нөлөө бүхий банкуудын хөрөнгийн зах зээл дээрх анхдагч зах зээлийн арилжааны үр дүнд банкны салбарын хувьцаа эзэмшигчдийн тоо 150 орчим байснаас 70 гаруй мянга болж нэмэгдэн, нийт 473 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг дотоодын зах зээлээс татан төвлөрүүлж, банканд тавигдах олон нийтийн хяналт сайжирсан юм. Энэхүү реформ нь Монгол Улсын банк санхүүгийн салбарын үрт хугацааны тогтвортой байдалд төдийгүй хөрөнгийн зах зээлийн хөгжилд түлхэц болох томоохон үйл явдал боллоо.

Банкны салбар нь Монгол Улсын санхүүгийн салбарын 95 орчим хувийг дангаараа бүрдүүлж, санхүүгийн салбарын үндсэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг манай улсын хувьд банкны салбарын тогтвортой байдал нь манай эдийн засгийн үрт хугацааны тогтвортой өсөлтөд амин чухал юм. Энэ утгаараа Төв банкны зүгээс банкны салбарын хууль эрх зүйн орчны шинэтгэл, банкны салбарт тавигдах хяналт, шалгалтын үр нөлөөтэй байдлыг тогтмол ханган ажиллаж, тасралтгүй хөгжиж буй банкны салбартай мөр зэрэгцэн хяналт, шалгалт, зохицуулалтаа сайжруулсаар байна. ■

# Банкны салбарын мөнгө угаах, терроризмтой тэмцэх хяналт шалгалтын хөгжил

Ази, Номхон далайн бүс (APG)-ийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас 2016 онд Монгол Улсад харилцан үнэлгээ хийж, манай улсыг өргөтгөсөн эрчимтэй хяналтад оруулснаар ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орох эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн. Монголбанкны тухай үеийн удирдлагын зүгээс банкны салбарын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, шаардлагатай арга хэмжээг яаралтай авах нь зүйтэй гэж үзэж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ банкууд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хяналт шалгалт хийх, бодлого, зохицуулалтыг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлсэн ба энэ чиг үүргийг хэрэгжүүлэх Тусгай хяналтын албыг Хяналт шалгалтын газрын бүтцэд байгуулсан.

Хяналт шалгалтын газрын Тусгай хяналтын алба нь тухайн үед дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж банкнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх болон зайны хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж эхэлсэн. Энэ чиглэлийн хяналт шалгалтыг тогтмол хийх болсноор Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой эрсдэлд суурилсан тогтолцоог банканд бий болгох, Монголбанкнаас хэрэгжүүлэх хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх нөхцөл бүрдсэн.

Улмаар 2020 онд Тусгай хяналтын албыг өргөжүүлэн, орон тоог нь нэмж, Мөнгө угаахтай тэмцэх хэлтэс болгон өөрчилж зохион байгуулсан. Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийг зохион байгуулснаар санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлэх чухал үүрэг хариуцлагыг бий болгосон ба банкны системийн 100 жилийн түүхэнд тэмдэглэхүйц алхам болсон билээ. Мөнгө угаахтай тэмцэх хэлтэс нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, банкнуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийх, эрсдэлийг үнэлэх, холбогдох

бодлого, зохицуулалтыг ФАТФ-ын 40 зөвлөмж болон олон улсын стандартад нийцүүлэх, банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах ажилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийхдээ олон

улсын шаардлагад нийцүүлж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам, Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх журмыг

шинэчлэн батлуулсны зэрэгцээ олон улсын стандарт, зохицуулалтын арга хэлбэрийг судалж нэвтрүүлэх, олон нийт болон банкнуудын ажилтнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх, сургах чиглэлд анхаарч ажиллалаа.

Түүнчлэн банкны бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан банкны мөнгө угаах терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд өртөх бизнесийн эрсдэлийг тооцох, дотоод хяналтын тогтолцоо, бүтэц, үр дүнтэй байдлын үнэлэх, банкны мөнгө угаах терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, санхүүгийн хоригийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил, дутагдалд хариуцлага тооцох, зөрчил дутагдлыг арилгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, Хамтын ажиллагааны зөвлөл, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажилласны үр дүнд Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны орон, дэлхийн улсуудаас тав дахь орон болоход Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтэс хувь нэмрээ оруулан ажиллаж байна. ■



## Санхүүгийн мэдээлэл

# Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тогтолцоо бэхэжсэн нь

**М**өнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх нь улс орны санхүүгийн системийн тогтвортой байдал, нийгэм, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг дэлхий нийтийг хамарсан асуудал болсон юм. Аливаа улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо хангалтгүй байх нь банк санхүүгийн байгууллагуудад сөргөөр нөлөөлж, иргэдийн гадаад төлбөр тооцоо, олон улсын шилжүүлэг удаашрах, зардал нэмэгдэхээс гадна үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн уналтыг бий болгох эрсдэлтэй. Мөн татвараас зайлсхийх, авлигийг нэмэгдүүлэх, төсвийн орлогыг бууруулах зогсохгүй, гадаадын хөрөнгө оруулалтыг сааруулах эрсдэлтэйг олон судалгаа харуулдаг.

Иймд улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) Олон улсын стандартыг тогтоогч байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан Техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж



болон Үр дүнтэй байдлын 11, Шууд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн системийн аюулгүй байдлыг хамгаалах, МУТСТ тогтолцоог өөрийн улс орны хэмжээнд төдийгүй олон улсын хэмжээнд бэхжүүлэн ажилладаг. ►

## Монгол Улсыг “саарал жагсаалт”-аас гаргах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ

**2017.07.21** Монгол Улсын Харилцан Үнэлгээний тайланг үнэлсэн.

**2017.09.20** ФАТФ-аас Монгол Улсыг “Өргөтгөсөн эрчимтэй хяналт”-д оруулсан.

**2019.10.18** Монгол улсыг саарал жагсаалтад оруулахаар шийдвэрлэсэн

**2019.12.11** Монгол Улсын Ерөнхий Сайдын 2019 оны 172 дугаар захирамжаар ФАТФ-тай тохирсон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Сангийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан.

**2019.12.25** Засгийн газрын 463 дугаар тогтоолоор “саарал жагсаалт”- гаргах чиглэлээр 4 шүүд хэрэгжилтийн

хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

**2020.01.20** Нийт 6 үүрэг даалгаврын хэрэгжилтийг тусгасан Монгол Улсын Явцын тайланг ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлэг болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хамтран зохион байгуулсан хурлаар хэлэлцүүлж, амжилттай хамгаалсан.

**2020.05.11** Монгол Улс ФАТФ-аас өгсөн үлдсэн 3 үүрэг даалгаврын хэрэгжилтийг агуулсан Ахицын тайланг Ази, номхон далайн хамтарсан бүлэгтэй цахим уулзалтаар амжилттай танилцуулж, хамгаалав.

**2020.08.12** Санхүүгийн мэдээллийн

албанаас холбогдох байгууллагын төлөөллийн хамт Ази, номхон далайн хамтарсан бүлгийн дэд дарга болон Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй цахим хурал хийсэн.

**2020.08.14** Сангийн Сайдын 151 дүгээр тушаалаар Монгол Улсад хийх ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.

**2020.08.26** Монголбанкны Ерөнхийлөгчөөс Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Дэд дарга нар болон Ажлын албанд хандан Монгол Улсад хийх хяналт шалгалтыг цахимаар хийх хүсэлтийг хүргүүлсэн.

**2020.09.17** Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран нэгтгэн боловсруулж, ФАТФ-т хүргүүлсэн.

**2020.10.01** ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын уулзалтыг Улсын онцгой комиссын хяналтан дор Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх шаардлагын дагуу амжилттай зохион байгуулав.

**2020.10.23** ФАТФ-ын Ерөнхийлөгч Монгол Улсыг ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-аас гарсныг албан ёсоор зарласан.



► Монгол Улс нь анх 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”-д нэгдэн орж, 2004 онд ФАТФ-ын бүс нутгийн байгууллага болох Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т элсэн орсноор МУТСТ олон улсын стандартыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Улмаар 2006 оны долдугаар сарын 06-ны өдөр “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль батлагдаж МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс, суурийг тавьсан.

МУТСТ тогтолцоо нь банк, санхүүгийн системтэй салшгүй холбоотой бөгөөд санхүүгийн салбарын гадаад хамтын ажиллагаа, нэр хүндэд шууд нөлөөлдөг. Иймд Монголбанк жил бүрийн Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд мөнгө угаах, терроризмыг

**“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын тогтоолоор батлав**

санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах асуудалд өндөр ач холбогдол өгч, заалт болгон тусгадаг. Монгол Улс ФАТФ-ын зөвлөмж, шаардлагыг бүрэн биелүүлснээр гаднын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагууд манай улсын МУТСТ тогтолцоонд итгэх итгэл нэмэгдэж, банкуудын гадаад харилцаа өргөжих боломжтой. Энэ нь дотоодын банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, нэр хүнд, хууль эрх зүйн эрсдэлийг бууруулж, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эергээр нөлөөлдөг. Түүнчлэн, МУТСТ үйл ажиллагаа үр дүнтэй явсанаар гэмт хэргийн улмаас олсон аливаа орлогыг санхүүгийн салбараар дамжуулан угаах боломжгүй болж, авлига хээл хахууль, татвараас зайлсхийх зэрэг бүх төрлийн суурь гэмт хэргийн тоо буурч гадна далд эдийн засгийг хүмийх боломж бүрдэх ач холбогдолтой. ■

## Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийг “бүрэн биелүүлсэн” үнэлгээтэй улс боллоо

Монгол Улс ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орны жагсаалт буюу “Саарал жагсаалт”-д 2019 онд хоёр дахь удаагаа орсон. Улмаар ФАТФ-аас өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэх ажлын хэсгийг байгуулан эрчимтэй ажиллаж, бусад төрийн байгууллага, хувийн сектор, мэргэжлийн холбоодтой хамтран ажилласны үр дүнд маш богино хугацаанд буюу 2020 онд энэхүү жагсаалтаас гарч чадсан.

Тус үр дүнгээ бататгахын тулд Монгол Улс 2020 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-г хийсэн бөгөөд үнэлгээний үр дүнгээс харахад банкны салбарын МУТСТ чиглэлийн мэдлэг, ойлголт, боловсон хүчин бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр боловч, цаашид хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, банкны удирдлагуудын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар комплаенсын нэгжийн засаглалын тогтолцоог сайжруулж, хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах шаардлагатай гэж дүгнэсэн.

Үндэсний эрсдэлийн үнэлгээнд суурилсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2022 оны долдугаар сарын 5-ны



өдрийн 265 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. Уг хөтөлбөр 2022-2030 оны хооронд найман зорилго болон 48 зорилтын хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжих юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээнд бэлтгэх, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх ач холбогдолтой. ■

## Судалгаа, шинжилгээ

# Төв банкны судалгааны чанар сайжирсан он жилүүд

Төв банкны бодлогын шийдвэр гаргалт нь өргөн цар хүрээ бүхий судалгаа, шинжилгээний ажилд тулгуурладаг. Энэ үүднээс Төв банк нь эдийн засаг, санхүүгийн чиглэлийн шинжилгээ, судалгаа голлон хийж, судалгааны нэгж нь үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай суурь судалгаа, мэдээллийн баазыг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг.

Монголбанкны хувьд 1991 онд дотооддоо анхны судалгааны нэгжийг албан ёсоор байгуулж, судалгаа, шинжилгээг чухалчлан авч үзэх болсон. Ингэснээр Төв банк гэлтгүй Монгол Улсын эдийн засгийн бодлогын судалгааны хөгжилд хувь нэмэр оруулжирлээ. Судалгааны нэгж нь эхэн үедээ тайлан мэдээ боловсруулах, статистик шинжилгээний бюллетень гаргах зэрэг ажил хийж байсан бол явцын дунд мөнгөний үржүүлэгч, долларжилт, суурь инфляц, банкны ашигт ажиллагаа зэрэг эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдлыг тодорхойлсон шинжилгээг хийх болсон. Монголбанк судалгааны ажлынхаа хүрээг тэлж, чанарыг сайжруулахад онцгой ач холбогдол өгч, судлаач, боловсон хүчнээ гадаадын нэр хүндтэй их сургууль, олон улсын байгууллага, Төв банкнуудын сургалтуудад эдийн засаг, эконометрик, статистик, санхүүгийн удирдлага, төрийн удирдлага зэрэг олон чиглэлээр суралцан мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэн, судалгааны багаа бэхжүүлж ирсэн. Энэ хүчин чармайлтын үр дүнд судлаачдын үр чадвар, ашиглаж буй загвар, арга зүй эрс сайжирч, үүнтэй зэрэгцэн тоон мэдээллийн нэр төрөл нэмэгдэж, цуваа уртассан нь Монголбанкны судалгааны чанар сайжрахад томоохон түлхэц болсон.

Монголбанк 2007-2008 онд мөнгөний бодлогын арга хэлбэрээ өөрчилсөнтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн төлөвт суурилсан бодлогын шийдвэр гаргах шаардлага үүссэн. Улмаар Монголбанк нь бодлогын шинжилгээ хийх загваруудыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж, SIMOM, SVAR, SARIMA зэрэг эконометрик



**Монголбанкны судлаачдын 30 гаруй судалгааны өгүүлэл олон улсын өндөр зэрэглэлтэй, хянан магадлагаа хийдэг сэтгүүлүүдэд хэвлэгджээ**

загваруудыг анхлан нутагшуулж, хөгжүүлсэн. Үүний зэрэгцээ тухайн үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор өрхийн болон банкны салбарын стресс тест, гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөө, орон сууцны хөтөлбөрийн үр нөлөө болон мөнгөний эрэлт, нийлүүлэлт, зээл зэрэг сэдвийн хүрээнд суурь судалгааг олноор хийж байв.

Цаашлаад Монголбанкны мөнгөний бодлогын шинжилгээний дүнд хугацааны гол загвар болох GAP болон DSGE-д суурилсан загвар, BVAR, FAVAR, MIDAS зэрэг богино хугацааны төсөөлөл хийх загваруудыг бодлогын шинжилгээнд нутагшуулан ашиглах болов. Монголбанкны зүгээс бодлогын шийдвэр гаргахдаа эконометрик загварын үр дүнгээс гадна салбаруудад гарч буй өөрчлөлт, экспертүүдийн санаа, дүгнэлт болон иргэд, аж ахуйн нэгж, судлаачдын хүлээлтийг хамтатган авч үздэг. Энэ хүрээнд “Инфляцын түүвэр судалгаа”, “Аж ахуйн нэгжийн түүвэр судалгаа” зэрэг түүвэр судалгааг 2009 оноос хойш улирлын давтамжтай хийж, бодлогын шийдвэртээ ашиглаж байна.

Сүүлийн жилүүдэд Монголбанк макро түвшний судалгаа хийхийн зэрэгцээ микро тоон шинжилгээ, судалгааны ажилд онцгой анхаарал хандуулж, цаг

► үетэйгээ уялдуулан машин сургалт, их өгөгдөл, уур амьсгал зэрэг өнөө үед чухлаар тавигдаж буй сэдвүүдийг мөн судалж байна. Энэ хүрээнд микро өгөгдлийг ашигласан шинжилгээ хийх суурь баазыг хөгжүүлэх, өгөгдөл боловсруулалтыг сайжруулах, эмпирик судалгаанд ахисан түвшний эконометрик болон бүтцийн загваруудыг ашиглах, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх чиглэлд олон улсын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллаж байна.

Монголбанкны судалгааны чанар өнгөрсөн 20 гаруй жилд эрчтэй сайжирсан бөгөөд илтгэх нэг үзүүлэлт нь Монголбанкны судлаачид нийт 30 гаруй судалгааны өгүүллийг олон улсын өндөр зэрэглэлтэй, хянан магадлагаа хийдэг сэтгүүлүүдэд хэвлүүлсэн явдал юм. Түүнчлэн эдгээр сэтгүүлд хянан магадлагаа өгч ажиллаж байна. Энэ нь судалгааны чанар сайжрах, үр дүнд итгэхүйц байдал нэмэгдэх, ингэснээр бодлогын шийдвэр ашиглагдахаас гадна олон нийт, цаашлаад олон улс дахь Монголбанкны нэр хүндийг өсгөхөд ач холбогдолтой. Эдийн засгийн чиглэлийн судалгааны байгууллагуудын зэрэглэл тогтоодог “Ideas” өгөгдлийн сангийн зэрэглэлээр Монголбанк нь сүүлийн 10 жилийн судалгааны үзүүлэлтээр Монгол Улсдаа хамгийн нөлөө бүхий судалгааны институтээр шалгарсан (Ideas, 2024). Түүнчлэн, олон орны Төв банк, Сангийн яам, санхүүгийн байгууллагуудын судалгаа шинжилгээнд өргөнөөр ашигладаг, тооцоолол хийх зориулалттай “Eviews” программын нийт 140 гаруй нэмэлт тооцооллын функцийн 30 гаруйг (20 орчим хувийг) зөвхөн Монголбанкны судлаачид хөгжүүлснийг дэлхий даяар давхардсан тоогоор зургаан сая гаруй судлаачид ашигласан байна (Eviews, 2024).

Монголбанк судалгаа, шинжилгээний чиглэлээр олон улсын байгууллагууд, Төв банкнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж ирлээ. Тухайлбал, Монголбанк Зүүн Өмнөд Азийн Төв банкнуудын холбоонд 1999 онд нэгдсэн цагаас хойш тус байгууллагын тодорхой сэдвийн дор зүүн Азийн улс орнуудын харьцуулан шинжилдэг цуврал судалгааны товхимолд Монгол Улсын эмпирик судалгааны ажлуудыг гүйцэтгэж, хэвлүүлж ирлээ. БНСУ-ын Төв банктэй “Мэдлэг Түншлэлийн Хөтөлбөр”-ийг 2015 оноос хойш хамтран хэрэгжүүлж, жил бүр Төв банкны бодлогын шинжилгээг бэхжүүлэх, дэд бүтцийг

**“Ideas” өгөгдлийн сангийн зэрэглэлээр Монголбанк хамгийн нөлөө бүхий судалгааны институтээр шалгарав**

сайжруулах чиглэлд судалгааны ажлыг хамтран боловсруулж, бүтээлүүдийг нийтлээд байна. Мөн Швейцарийн Градуэт Институтийн “Төв банкуудад зориулсан хоёр талын тусламж, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2021 оноос эдийн засгийн судалгааны ажлуудыг хамтран боловсруулж, судлаачдын чадавхийг бэхжүүлж байна.


Монголбанкны зүгээс Монгол Улсын хөгжлийн эдийн засгийн болон санхүүгийн бодлогын шийдвэрт дэмжлэг болохуйц суурь судалгааны ажлуудыг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнг байгуулсан нь судалгаа, шинжилгээний ажлуудыг эрчимжүүлэх ач холбогдолтой үйл явдал болсон. Мөн судалгааны өгүүлэл бичиж, хэвлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, хүртээмжийг сайжруулах зорилгоор Монголбанкнаас “Мөнгө, Санхүү, Баялаг” нэртэй сэтгүүлийг эрхлэн гаргасан нь эдийн засгийн чиглэлээр сургалт, судалгаа эрхэлдэг их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, судалгааны сэтгүүл нэгээр нэмэгдсэн үйл явдал болсон. Төв банкны судлаачдын судалгааны чанар, олон улсын сэтгүүлд хэвлүүлэх судалгааны тоог нэмэгдүүлэхэд анхаарсан бас нэгэн дэмжлэг нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны тушаалаар Монголбанкны судлаач өндөр зэрэглэлтэй буюу “А” болон “А” ангиллын сэтгүүлд судалгаагаа хэвлүүлсэн тохиолдолд тодорхой урамшуулал олгож байхаар шийдвэрлэсэн явдал юм.

Монголбанкны эдийн засагчид, судлаачдын судалгааны ажлуудыг эмхэтгэсэн “Судалгааны Товхимол”-ыг 2002 оноос хойш өнөөг хүртэл 18 цуврал гаргаж, нийтдээ 370 гаруй судалгааны ажлыг олны хүртээл болгоод байна. Түүнчлэн Монголбанкны тэгш ойн жилүүдэд эрдэм шинжилгээний бүтээлүүдийг эмхэтгэн тусгай дугаар болгон гаргадаг одоог хүртэл академик талбар дахь гол эх сурвалжуудын нэг хэвээр байна. Монголбанкны аливаа бодлогын шийдвэр судалгаа, шинжилгээнд тулгуурладаг хэдий ч, судалгаа, шинжилгээний ажил нь Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэх албагүй юм. Судлаачид өөрсдийн арга барил, өнцгөөр тухайн судалгааг хийх орон зайг олгодог тул хөндлөнгийн нөлөөгүй, судлаачдын байр суурийг хараат бусаар илтгэх талбар болдог. Үүнд л Монголбанкны судалгааны ажлын үндсэн мөн чанар оршдог билээ. ■



## Дурсамж

# Д.Моломжамц: Намайг ажил хүлээж авахад гарааны нөхцөл туйлын хүнд байсан



Монгол Улсад нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, зах зээлийн харилцаанд шилжих эхний жилүүдэд Улсын банкны монополь систем задарч байв. Ийнхүү Төв банк, арилжааны банк гэсэн хоёр шатлал бүхий тогтолцоо үүсэх тэр түүхэн мөч буюу 1992 оны тавдугаар сард би Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдсон юм. Миний хувьд Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдоод дөрвөн жил, зургаан сар ажилласан. Өмнө нь Засгийн газрын гишүүнээр найман жил хагас ажиллаад байсан бөгөөд Монгол Улсын банкны хөгжлийн түүхэнд тулгараад буй асуудлуудын талаар тодорхой ойлголттой байлаа.

Ажилдаа орох үед гарааны нөхцөл туйлын хүнд байсан. Монгол Улсын Банкны тухай хуулийг Улсын Бага Хурал 1991 оны дөрөвдүгээр сард баталж, банкны хоёр шатлал бүхий орчин үеийн тогтолцооны эрх зүйн үндэс тавигдаж эхэлж байв. Гэвч Төв банкны тухай хууль байхгүй байсан. Монгол Улс өр, төлбөрийн эргүүлэгт орсон, валютын нөөцгүй болсон, гадаад валютын гүйлгээ хийх чадваргүй болж, олон улсын санхүүгийн хэллэгээр дефолтод орсон байв. Зах зээлийн эдийн засагт шилжих эхний жилүүдэд төвлөрсөн хангамжийн систем үгүй болж, олон үйлдвэр бүрэн хүч чадлаараа ажиллахгүй болж, 1990-1993 оны хооронд ДНБ-ий хэмжээ жил бүр буурсаар байсан юм. 1992 он гэхэд ДНБ-ий бодит хэмжээ

**Монголбанкны  
үйл ажил-  
лагааг таван  
чиглэлээр  
өрнүүлж,  
тодорхой  
арга хэмжээ  
авахаар  
зорьсон**

1990 оны 80 орчим хувийн түвшинд хүртэл унаад байлаа. Өргөн хэрэглээний барааны болон түлш шатахууны хомсдол нүүрлэж, гаднаас бараа таваар худалдаж авах валютын эх үүсвэргүй болов. Бараа, үйлчилгээний үнэ тарифыг улсаас тогтоож байсан журмыг өөрчилж, үнэ, тариф тогтоох чөлөөт тогтолцоонд шилжих болсноор бараа бүтээгдэхүүний үнэ огцом өсч, инфляцын түвшин 325 хувьд хүрсэн байв. Монголбанкны бэлэн мөнгөний нөөц шавхагдаж, ердөө 300 гаруй сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, хомсдолд орох эрсдэл нүүрлэсэн юм.

Би ажлаа аваад Монголбанкны үйл ажиллагааг дараах таван чиглэлээр өрнүүлж, тодорхой арга хэмжээ авахаар зорьсон. Тухайлбал, банкны хоёр шатлал бүхий тогтолцооны эрх зүйн үндсийг бүрэн бүрдүүлэх, арилжааны банкнуудын үйл ажиллагааг хяналтад авах, Монгол Улсын шинэ үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу төрийн мөнгөний бодлогыг боловсруулж зохих журмын дагуу батлуулан хэрэгжүүлж эхлэх, “алт-дилерийн хэрэг”-ээс үүдэлтэй арбитражийн гүйлгээний алдагдлыг хааж, Монгол Улсын гадаад валютын төлбөрийн чадварыг сэргээж, улсын валютын нөөцтэй болох, үндэсний шинэ мөнгөн дэвсгэртийн загварыг яаралтай бүтээж, зохих журмын дагуу батлуулж, шинэ мөнгөн дэвсгэртийг хэвлүүлэн гүйлгээнд гаргаж, бэлэн мөнгөний хомсдолоос сэргийлэх арга хэмжээ

► авах, дотоод өр авлагын сүлжээг тайлах явдал тулгамдсан зорилт байв.

Бидний анхаарлын төвд байсан нэг чухал асуудал нь Төв банкнаас үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндсийг бүрэн бүрдүүлж, Монголбанк (Төвбанк)-ны тухай хууль болон банкны үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулсан бусад хэд, хэдэн хуультай болох нь чухал байлаа. Улсын Бага Хурлын даргын захирамжаар 1991 онд баталсан ердөө 16 зүйлтэй Монголбанкны дүрэм гэж л байсан юм. Энэ нь Төв банкны үйл ажиллагааг нарийн зохицуулсан эрх зүйн акт болж чадахгүй байлаа. 1992-1996 онд Төв банк, арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулсан Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Мөнгөн хадгаламж төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Векселийн тухай хууль батлагдсан юм. Ийнхүү банкны системийн хууль тогтоомжийн нэгдсэн сүлжээ бий болсон нь зах зээлийн эдийн засгийн нэг чухал дэд бүтэц болох банкны шинэ систем бие дааж хөгжих эрх зүйн үндсийг тавьсан юм. Эдгээр хуулийн төслийг боловсруулж, батлуулахад УИХ-ын гишүүн Д.Данзан бидэнтэй гар нийлэн ажиллаж, энэ үйлсэд чухал хувь нэмэр оруулсныг зориуд тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр хууль гарснаар банкны салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн юм. Мөн арилжааны банкны Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын болон хувь нийлүүлэгчдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагын эрх зүйн үндэслэлийг тодорхой болгож, түүний биелэлтэд Засгийн газар, Монголбанкнаас тавих хяналтыг хүчтэй болгох, банк байгуулах шаардлагыг чангатгах зэрэг олон асуудлыг эрх зүйн зохицуулалтад оруулж өгсөн юм.

Монголбанк анх 1992 оны сүүлчээр Төрөөс мөнгөний бодлогын талаар 1993 онд баримтлах бодлогын чиглэлийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд оруулан хэлэлцүүлж, батлуулан түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах болов. Мөнгөний бодлогод тусгагдсан арга хэмжээнүүд нь заавал биелүүлэх, эсвэл дагаж мөрдөхийг шаардсан, эрх зүйн хувьд хуульчлагдсан онцлогтойгоос гадна уг үндсэн чиглэл нь зах зээлийн харилцааны үед төрөөс санхүү-мөнгөн

**Монголыг  
дэмжигч  
хандивлагч  
орнуудын клуб  
1991 онд бий  
болсон**

гүйлгээ, зээлийн бодлогын талаар баримтлах үндсэн баримт бичиг болсон түүхтэй. Төрийн мөнгөний бодлогыг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх эхний жилүүдэд Төв банкны мөнгөний бодлогын арга хэрэгслүүд төлөвшиж бий болсон юм. Эхний үед ялангуяа 1992-1995 онд мөнгөний удирдлагын захиргааны болон эдийн засгийн аргыг хослуулсан мөнгөний бодлого боловсруулан хэрэгжүүлж байв. Арилжааны банкнаа дахь иргэдийн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Төв банкнаас тогтоох, мөн банкнаас олгох зээлийн хэмжээг хязгаарлах, зээлийн хүүг инфляцын түвшинтэй уялдуулан өндөр тогтоох, заавал байлгах нөөцийн шаардлагыг өндөржүүлэх зэрэг захиргааны болон эдийн засгийн аргыг хослуулсан харьцангуй хатуу мөнгөний бодлого явуулж байсан. Энэ бүхний үр дүнд 1994 он гэхэд банкнуудын үйл ажиллагааг Монголбанк бүрэн хяналтад авч, үнийн өсөлтийг тогтвортой бууруулж эхэлсэн юм.

Улсын валютын нөөцийг сэргээж бий болгох явдал тэр үеийн тулгамдсан зорилтын нэг байсан. 90-ээд оны эхээр банкны хоёр шатлал бүхий тогтолцооны эхлэл дөнгөж тавигдаж байсан болон “алт дилерийн хэрэг”-ийн улмаас банкны нэр хүнд эрс унасан байсан тул манай зарим томоохон үйлдвэр валютын орлогоо гадаад банканд данс нээн хадгалж, тэндээсээ гүйлгээ хийж байсан. Би “Эрдэнэт” үйлдвэрийн захирал Ш.Отгонбилэг, “Говь” компанийн захирал Д.Дамдинжав нартай биечлэн уулзаж, экспортын борлуулалтын валютын орлогоо Монголд оруулж ирэх санал тавихад “Бидний итгэлийг даах, найдвартай үйлчлэх арилжааны банк манайд байхгүй төлбөр тооцоо саатна” гээд татгалзсан. Гэвч удаан ярилцасны эцэст энэ хоёр үйлдвэрийн валютын харилцах дансыг түр хугацаагаар Монголбанканд нээж, төлбөр тооцоог нь анхны шаардлагаар нь биелүүлэхийн хамт хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг нь Монголбанк ашиглаж зарим яаралтай төлбөрийг гүйцэтгэж байж билээ. Энэ үйлдэл нь Төв банкны ажил биш гэдэг нь хэнд ч тодорхой байсан хэдий ч шилжилтийн үеийн хүндрэлээс урган гарсан түр зуурын алхам байв.

Монголыг дэмжигч хандивлагч орнуудын ►

► клуб 1991 онд бий болж, хоёр дахь удаагийн зөвлөлгөөн 1992 оны зургадугаар сарын эхээр Токиод болж, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн Монголын эдийн засгийг зах зах зээлийн харилцаанд шилжүүлэх эхний алхмын талаар илтгэл тавьж, би Монголын банкны хоёр шатлал бүхий тогтолцоог үүсгэн хөгжүүлэх талаар авсан арга хэмжээний талаар мэдээлэл хийж байлаа. Энэ зөвлөлгөөн дээр Монголд анх удаа байгуулагдсан эвслийн Засгийн газрын үйл ажиллагааг дэмжихээ хандавлагч орнууд болон ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк (АХБ) албан ёсоор илэрхийлсэн түүхтэй. 1992 оны зургадугаар сараас ОУВС, Дэлхийн банк, АХБ-тай Монголын эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр, түүний дотор банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрүүдийг тохирч, хэрэгжүүлэх асуудлаар албан ёсны хэлэлцээр хийж эхэлсэн бөгөөд 1992 оны сүүлээс буцалтгүй тусламжийн эхний хэсэг зарим орноос орж ирэх болсон. Энэ үед Дэлхийн банкны 105.7 сая ам.долларын таван төсөл, АХБ-ны 269.5 сая ам.долларын арван төсөл, ОУВС-гийн 98,1 сая ам.долларын хоёр хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байдаг юм.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чөлөөт тогтолцоонд шилжүүлэх, валютын зохицуулалтын тухай хуулийг боловсруулан батлуулж, мөрдүүлэх алт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг олон арга хэмжээ нь улсын валютын нөөцийг сэргээн бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. 1993-1996 онд алт олборлодог компаниудаас Монголбанк 8370 кг алт худалдан авсан байдаг юм. Ер нь алт олборлолт нь 1994 оноос валютын нөөцийг бүрдүүлэгч нэг гол эх үүсвэр болсон. 1993 оны эцэс гэхэд Монгол Улс 27 сая ам.долларын валютын цэвэр нөөцтэй болж, намайг ажлаа хүлээлгэж өгөх үед буюу 1996 оны арваннэгдүгээр сард Монголбанкны валютын цэвэр нөөц бараг 60 сая ам.доллар болсон байлаа. ■

*Монголбанкны Ерөнхийлөгч асан  
Дэмчигжавын Моломжамц*

## Монголбанк бидний бахархал

*Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк анх байгуулагдах үед 260 мянган янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой, үүний дотор зөвлөлтийн мэргэжилтэн 18, монгол ажилчин дөрөв байжээ. Тэгвэл өнөөдөр Монголбанк олон мянган ажилтантай, Монгол орны мөнгө, санхүүг тодорхойлдог их айл болсон билээ. Бид Монголбанкны төлөөлөл болсон зарим ажилтны сэтгэгдлийг хүргэж байна.*

### С.Энхбат: Монголбанкны Хяналт шалгалтын газрын хамт олноороо бахархдаг



*Хяналт шалгалтын газрын Газар дээрх шалгалтын хэлтсийн ахлах хянан шалгагч*

-Миний бие Монголын сор болсон эдийн засагч, санхүүч банкируудын удирдлага дор хамт олныхоо хамтаар сүүлийн 28 жилийн түүхийг бүтээлцэж байгаадаа баяртай байдаг.

Санхүү төлбөрийн чадварын хүнд байдалд орсон ХОТШ банкныг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 1999 онд албадан татан буулгахаар шийдвэрлэсэн. Тухайн үед ХОТШ банк нь 40 мянга орчим хадгаламж эзэмшигчтэй, 8 мянга гаруй харилцагчтай, 41 салбар нэгжтэй томоохон банк байсан юм. Монголбанкны удирдлагаас залуухан хянан шалгагч намайг тэр том банкны удирдлагын багт томилон ажиллуулсан нь одоо бодоход ихээхэн итгэл хүлээлгэж, том хариуцлага үүрүүлсэн байсан. Тэр он жилүүдэд л би арилжааны банк гэж юу байдаг, хүнтэй харьцах үр ухаан, аж ахуйн ажил гэж юу байдгыг суралцаж ёстой амьдралын их сургуулийг төгссөн санагддаг.

Мөн 2008 онд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Анод банканд онцгой дэглэм тогтоож, Эрх хүлээн авах албадлагын арга хэмжээг (Эрх хүлээн авагчаар С.Энхбат миний бие, гишүүдээр Д.Батмөнх, Ч.Зоригтбаатар) авч хэрэгжүүлсэн юм. Анод банкны үр ашиггүй зардлыг бууруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсний үр



дүнд долоо мянга гаруй зээлдэгчид хамаарах 186.3 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн өрийн үлдэгдлийг 130 гаруй тэрбум төгрөгөөр бууруулан 72.2 хувьтай барагдуулж, нийт иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламж, харилцах дансны үлдэгдлийг бүрэн барагдуулж дууссан юм.

Монголбанкны Хяналт шалгалтын газрын хамт олноос Монгол Улсын гавьяат эдийн засагч М.Батжаргал, Монгол Улсын гавьяат эдийн засагч, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, УИХ-ын гишүүн, Сангийн сайд

/Монголбанкны Тэргүүн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан/ Б.Жавхлан зэрэг төр, нийгмийн нэрт зүтгэлтнүүд, мөн арилжааны банкны олон захирал төрөн гарсанд миний бие бахархаж явдаг юм. Ингээд Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж бэхжэсэний түүхт 100 жилийн ойн мэндийг хамтран ажиллаж байсан нийт ахмадууд, одоо ажиллаж байгаа хамт олон, бүх банкирууддаа хүргэж эрүүл энх, энэ хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

## Т.Түвшингэрэл: Төв банканд ажилласнаар асуудлыг том зургаар харах чадварт суралцдаг



Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Нөөцийн удирдлагын хэлтсийн нөөцийн ахлах мэргэжилтэн

-Анх Монголбанкны Валют, эдийн засгийн газарт 2012 онд ажилд ороход хүндэлж явдаг шууд удирдлага маань “Энхийн цагт хөлс их урсгавал, дайны цагт цус бага урсана” гэж хэлж байсан нь санаанаас гардаггүй. Аливаа бодлогын шийдвэр судалгаанд үндэслэж гардаг бол судалгааны чанарт тоон өгөгдлийн чанар (decision usefulness) чухал үүрэг гүйцэтгэдэг. Бодлого боловсруулагч байгууллагын ажилтны хувьд аль ч нөхцөл байдалд тоон мэдээлэл, тооцоолол, судалгаа нь чанартай бөгөөд бэлэн байх хэрэгтэй. Ингэхийн тулд багаа шинэ

мэдээллээр хангах, гадаад болон дотоод зах зээлийн нөхцөл байдлыг тогтмол үнэлж, түүнд суурилсан хамгийн оновчтой шийдлийг гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр тухай бүрт хангах шаардлага үүсдэг. Иймд Төв банканд ажилласнаар асуудлыг том зургаар харах, макро тоон үзүүлэлтүүдийн уялдаа холбоог ойлгох чадварт суралцдаг. Мөн хийж байгаа ажил маань дотоодын эдийн засагт шууд нөлөө үзүүлдэг тул өмнөх ажлаа чанартай, хариуцлагатай, чин сэтгэлээсээ хийж, нэг алхам урагшлуулахад бид анхаарч ажиллацгаадаг.

## Д.Болдбаатар: Монголбанканд 28 жил ажиллахдаа сонирхолтой сорилттой байнга тулгарч иржээ



Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Эдийн засгийн судалгаа, шинжилгээний хэлтсийн ахлах эдийн засагч

-Миний бие МУИС-д багшилж, 1996 оны сүүлчээр Монголбанкны Мөнгөний бодлогын газарт ажилласнаар одоог хүрчээ. Энэ хүртэлх 14 жилд Мөнгөний бодлогын газрын захирлаар ажилласан юм. Цаг үеийн шаардлагаар Мөнгөний бодлогын газрын бүтэц, бүрэлдэхүүн зохион байгуулалт, чиг үүрэг нь өөрчлөгдөн хувьсаж байсан боловч хамт олондоо зорилго чиг үүргээ ойлгуулан, ажлыг чигч тууштай зохион байгуулах, гүйцэтгэлийн үр ашгийг сайжруулахад анхаарч ажилласан. Харин хэлтсийн захирал, ахлах эдийн засагчаар ажиллахдаа бодлогын шийдвэр бэлтгэх цогц

системд багаа оролцуулж, тооцооллын чанар, нарийвчлалыг сайжруулахад анхаарч ажиллаж байна.

Анх Монголбанканд ажиллаж эхлэхэд эрх зүйн орчин эрс өөрчлөгдөж, банкны бүтцэд бүтэн шинэчлэл хийгдэж байсан учир журам боловсруулах, шинэчлэх, санхүүгийн захын дэд бүтцийг нээж өгөх зэрэг ихээхэн сонирхолтой ажил гүйцэтгэсэн жилүүд байжээ. Манай хамт олон энэ ажлыг гүйцэтгэх явцад маш их сурч боловсорсон бөгөөд Монголбанк биднийг нарийн мэргэших өргөн боломж олгодгийн ачаар бид хөгжлөөс хоцрохгүйг хичээж

ажилладаг байлаа. Ер нь банкны удирдлагууд манай газрыг шилдэг, авьяаслаг боловсон хүчнээр өргөтгөх боломж олгож байсан учир Мөнгөний бодлогын газрын хамт олон дэлхийн шилдэг мэдлэгээс суралцсан, хичээнгүй, хүчирхэг нэгдэл болж чадсан билээ.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шаардлагаар манай ажлын цар хүрээ тэлж, гүнзгий судалгаа шаардах болсноор цагтай уралдсан өндөр гүйцэтгэл шаардагдах болсон. Манай газрын анхлан гүйцэтгэж байсан чиг үүрэг одоо бол хоёр газар дамнасан, дөрвөн хэлтсийн хүчирхэг баг гүйцэтгэх хэмжээнд хүртэл өргөжжээ. Зарим жилд статистик, судалгаа, мөнгөн тэмдэгтийн асуудлууд ч миний хариуцсан чиг үүрэгт хамарч байсан билээ. Аль ч үед, аль ч албан тушаалд ажиллаж байсан ч мөнгөний бодлогын үр дүнд зорьж ажилладаг тэр зарчим энэ газрын шинж чанар

учраас “манай ажил боллоо, үлдсэнг бусад нь хийнэ” гэх сэдлээр ажилладаггүй нь нэг чухал онцлог юм даа. Монголбанканд би 28 жил ажиллаж байна. Энэ хугацаанд байнга шинэчилж, өөрийгөө хөгжүүлж, санаачлагатай, угтаж ажилладаг хүмүүсийн дунд ажиллаж, амьдарч ирсэн учраас байнгын сонирхолтой, сорилттой тулгарч ажиллаж иржээ.

Цаашид бид цахим ертөнцийн ололтуудыг түлхүү ашиглаж, хөдөлмөр хэмнэсэн, хугацаа хожсон, орчин цагтай хөл нийлүүлсэн арга барилд түлхүү суралцаж, нийгмийн амьжиргааг дээшлүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэсэн итгэлтэй байна. Бидний ажлын орчныг хамгаалж, өндөр ёс зүйтэй ажиллах, давшингүй хөгжих боломж бүрдүүлэхэд байгууллага маань улам сайн анхаарч, хойч үе минь улсын хөгжлийн төлөө энэ ажлыг гүйцэтгэж байгаа гэх эрмэлзлэлээ бат хадгалж байгаасай гэж хүснэм.

## Д.Энхцэцэг: Би аавынхаа үргэлжлэл...



Монголбанкны  
Дорноговь аймаг дахь  
хэлтсийн нягтлан  
бодогч

-Миний бие банкны хоёр шатлалт тогтолцоо бий болсон үе буюу 1993 оны аравдугаар сард Дорноговь аймаг дахь Монголбанкны салбарт оператороор ажилд орж, түүнээс хойш одоог хүртэл 31 жилийн туршид, гурван захирлын удирдлага дор ажиллаж иржээ.

1993 оноос өнөөг хүртэл оператор, нягтлан бодогчоор ажиллах хугацаандаа банк хоорондын гүйлгээг гараар шивж оруулж, ан модемоор холбогдон дамжуулдаг байх түвшингээс гүйлгээг банк хоорондын бодит цагийн горимоор дамжуулах түвшинд хүртэл хөгжсөн хөгжлийн гэрч бөгөөд үүнийг даган нэвтрүүлсэн шинэ техник технологи, програм хангамжид суралцсаар байна.

Монголбанк хэмээх нэр хүндтэй эрхэм салбарт аавтайгаа гуравхан жил хамт ажиллах тавилан, ерөөл байж дээ. Аав маань 1965 онд Хэнтий аймаг дахь Банкны конторт

ерөнхий нягтлан бодогчоос ажлын гараагаа эхэлсэн бөгөөд Дорноговь аймагт 1975 онд шилжин ирсэн байдаг. Монголбанк хэмээх их айлын хаалгаар орж, нэгэн эд эс болон аавынхаа ажлыг үргэлжлүүлэн тасралтгүй нэг байгууллагадаа ажиллаж байгаадаа бахархахгүй байхын аргагүй ээ.

Орон нутгийн салбарт ажиллахын нэг онцлог бол бүхий л ажлыг гардан хийж суралцдаг бөгөөд өөрийн эзэмшсэн мэргэжлээс гадна архив, албан хэрэг хөтлөх, мөнгө тоолох зэрэг их л зүйлийг сурсан даа. Гар бие, сэтгэл зүрхээрээ хамтран ажиллаж байгаа хэлтсийнхээ хамт олон болон үеийн ахмадууд, нийт банкир нартаа Монгол Улсад Банк үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, гэгээн сайхан бүхнийг хүсье.

## Э.Хосбаяр: Монголбанк ажилтнуудаа мэдлэг ур чадвараа сайжруулахад ихээхэн анхаардаг



Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн ахлах эдийн засагч

-Юуны түрүүнд та бүхэнд Монгол Улсад банк санхүүгийн салбар үүсэж, бэхэжсэний түүхт 100 жилийн ойн мэндийг дэвшүүлье.

Аливаа Төв банкны үйл ажиллагаа, бодлогын шийдвэр гаргалт тухайн улсын эдийн засаг хийгээд ард иргэдийн аж амьдралд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлж байдаг. Тэр ч утгаараа Төв банканд ажиллана гэдэг нэр хүндийн болон хариуцлагын асуудал гэж би ойлгодог. Миний хувьд 100 жилийн түүхтэй цөөн Төв банкуудын нэг Монголбанкны нэгэн цаг үеийн төлөөлөл болж, улс орныхоо эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжил дэвшилд гар бие оролцож байгаагаараа үргэлж бахархаж явдаг.

Төв банкны бодлогын шийдвэр судалгаа, шинжилгээнд тулгуурлан хийгддэг тул Төв банкныг нэг талаас судалгааны институт гэж хэлж болно. Энэ үүднээс шаардлагатай судалгааны ажлуудыг чанартай хийж гүйцэтгэхэд мэргэжилтэн, судлаачид өндөр түвшний мэдлэг

ур чадвартай байх зайлшгүй шаардлагатай. Иймд Монголбанкны зүгээс хүний нөөцөө бүрдүүлэхдээ босгыг өндөр тавьж, шилдгүүдийг сонгож авахыг зорьдог. Би оюутан байх цагаасаа хүсэж, зорьж байсан Монголбанканд эдийн засагчаар ажилд орж, салбарынхаа шилдэг хүмүүсээс суралцан, үг сонсож, хамтран ажиллаж, хамт олон болсноор мэргэжлээ илүү таньж мэдэн, аливаа зүйлийг том зургаар харах, түүнд дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах ур чадваруудаа хөгжүүлсэн. Монголбанк нь ажилтнуудаа туршлага хуримтлуулах, мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч олон улсын байгууллагуудын сургалт семинар, хурал зөвлөгөөнд оролцох, цаашлаад гадаадын томоохон их сургуулиудад мэргэжлээ дээшлүүлэх нөхцөлөөр хангагдгаас гадна хамт олны зүгээс хувийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг нь залуу хүний хувьд алдаж болохгүй боломж гэж хардаг.

## Н.Пэлжид: Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд хоёргүй сэтгэлээр ажиллаж байна



Увс аймаг дахь Монголбанкны салбарын хянан шалгагч

Банк гэж том байгууллагатай хувь тавилангаар холбогдсондоо бэлэгшээж бахархаж явдаг. Банканд ажиллана гэдэг маш том хариуцлага байдаг. Монгол Улсын сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан банкуудын санхүү, төлбөрийн чадварын байдалд хяналт тавьж, банкны салбарын үйл ажиллагаа алдаа зөрчилгүй, ард иргэдийн амьдралд өгөөжтэй байхын төлөө банкир миний бие ажиллаж байна.

Төв банкаас өгсөн чиг үүргийн дагуу 2017 оноос хойш арилжааны банкууд болон Насан түршийн боловсрол төвтэй хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд орон нутаг

ур нөлөөтэй олон ажлыг зохион байгуулсан. Нийт 38 мянган иргэнд онол практик хосолсон сургалт сурталчилгаа хийж, Төрийн мөнгөний бодлогыг олон нийтэд түгээхэд хоёргүй сэтгэл зүтгэлээр ажиллаж байна.

Увс аймгийн иргэд хуримтлал хадгаламжаа нэмэгдүүлснээр нийт хадгаламж 189.3 тэрбум төгрөгт хүрсэн амжилттай байна. Энэ үзүүлэлтээрээ манай аймаг улсад дээгүүр байранд жагсдаг нь банкны салбар бэхжиж санхүүгийн тогтвортой байдлыг хангаж байгаагийн нэг илрэл болов уу. Аймгийн банкны салбарын үйл ажиллагаа тогтвортой байж ард иргэдийн амьдрал дээшилж байвал банканд ажилласны минь хөдөлмөрийн үр шим тэр юм даа.



## ХААН БАНК

# Эх дэлхийд ээлтэй, олон нийтэд нээлттэй ХААН Банк



**М**онгол Улсад банкны систем үүсэн хөгжсөн 100 жилийн түүхийн тодорхой хэсэг болж, хөгжлийн замнал өөд тасралтгүй тэмүүлэн өнөөгийн өндөрлөгт хүрсэн банк бол ХААН Банк. Улс орны эдийн засгийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн он жилүүдийг туулан 33 жилийн түүхийг бүтээгээд байна. Хэдийгээр өдгөө 30 гаруй жилийн настай ч ажил мэргэжлийн баялаг туршлага нь зуунаар тооцогдох замналаас эхтэй.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлөөс 422-р тогтоол гарган 1990 онд “Арилжааны банкны нийтлэг дүрэм”-ийг баталсны дараа 1991 оны дөрөвдүгээр сард Монгол Улсын бага хурлаар Банкны хуулийг баталж, Улсын банкныг мөнгө зээлийн бодлого хэрэгжүүлэх эрх бүхий Төв банк буюу Монголбанк болгон зохион байгуулалтын

өөрчлөлт хийснээр банкны хоёр шатлалтай тогтолцооны эрх зүйн үндэслэл бий болсон юм. Энэ хүрээнд 1990-ээд оны эхээр арилжааны 15 банк үүсэн байгуулагдсаны тавдугаарт одоогийн ХААН Банк бичигдэж байлаа.

Тус банк 1990-ээд оны эхээр хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан хөдөө аж ахуйн нэгдэл, хоршооллын байгууллага, сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуй, орон нутгийн төсөвт байгууллагууд бүхий 255 сум, эдгээр сумын хүн ам, иргэдэд банкны үйлчилгээ үзүүлж байсан Улсын банкны 326 салбар, тооцооны кассыг тэнд ажиллагсдынх нь хамт шилжүүлэн авсан түүхтэй. Хуучин тогтолцооны Улсын банкны сууриас өнөө үеийн хүчирхэг ХААН Банкны хөгжлийн гараа эхэлсэн өвөрмөц онцлогтой. Энэ нь давуу бөгөөд ►

► сул тал аль алийг нь үзүүлсэн гэж хэлж болно. Давуу талын хувьд бүх аймаг, сум дахь Улсын банкны салбарыг эгнээндээ авсан томоохон суурь бааз гэж харагдана. Нөгөө талдаа бүх л өр ширийг нь өвлөн авсан байдаг. Тухайлбал, Улсын банкнаас 2.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр шилжүүлэн авахын хамт түүнээс 100 сая төгрөгөөр 2.3 тэрбум төгрөгийн зээл өвлөсөн байна.

Хөдөө аж ахуйн банкны 301 суманд ажиллаж байсан тооцооны төвүүд зөвхөн сумын төсвийн байгууллагуудын орлого, зарлагын гүйлгээнүүдийг хийх, цалин тэтгэвэр тэтгэмж тавьж олгох төдий үйлчилгээг хийдэг байв. Хөдөөгийн иргэд, малчдын мөнгийг сар бүрийн өндөр хүүтэй хадгалж, зээлийн үйлчилгээ хязгаарлагдмал байсан зэргээс шалтгаалж 1994 оноос жил дараалан ихээхэн алдагдалтай ажиллаж эхэлжээ.

Хөдөө аж ахуйн банкны үйл ажиллагаанд 1990-ээд оны эдийн засгийн хямрал, үнийн өсөлт, мөнгөний ханш уналт, байгууллага иргэдийн төлбөрийн чадварын доройтол, баталгаагүй зээлийн өсөлт зэрэг гадаад дотоод хүчин зүйлс ихээхэн сөрөг нөлөө үзүүлжээ. Энэ бүхнээс үүдэлтэйгээр банкны өөрийн хөрөнгө 4.9 тэрбум төгрөгийн дутагдалд орж, пассив нь активаасаа хэтрэн төлбөрийн чадваргүй болж, дампуурах бодит аюул нүүрлэж эхэлсэн байна.

1995 оны эцсээр нийт зээлийн багц таван тэрбум төгрөгөөс бүрдэж байв. Үүнээс хуучин тогтолцооноос шилжиж ирсэн зээл 980.1 сая төгрөг, Засгийн газрын шахалтаар олгосон захиргаадалтын зээл 1575 сая төгрөг байсан нь нийт зээлийн багцын 51 хувийг эзэлж байжээ. Тухайн үед Хөдөө аж ахуйн банк Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 90 хувь, нийт харилцагчдын 51.9 хувийг хамран банкны үйлчилгээ явуулж байжээ.

Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 17 дугаар тогтоолын 11 дүгээр заалтыг үндэслэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктэй хамтран санхүүгийн салбарт бүтцийн өөрчлөлт хийхээр Монголбанк, Сангийн яамнаас гаргасан журам, заавар зарчмыг баримтлан “Монголын Хөдөө аж ахуйн банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө”-г батлан гаргасан боловч байдал сайжралгүй, үргэлжилсээр байв.

1999 онд Хөдөө аж ахуйн банканд Монголбанкнаас онцгой дэглэм тогтоож, хуулийн

дагуу дараагийн шатны арга хэмжээ болгож эрх хүлээн авах ажиллагааг хэрэгжүүлжээ. Төлбөрийн чадваргүй болоход нөлөөлсөн шалтгаанууд нь захиргаадалтын зээл, муу удирдлага, өөрийн орлого олох боломжоос давсан өндөр зардал байв. Онцгой дэглэм, Эрх хүлээн авах үйл ажиллагааны үед тус банкны зээлийн үйл ажиллагааг зогсоож, хуучин зээлийн өрийг төлүүлэх, захиргааны зардлыг бууруулах, хяналт тогтоох арга хэмжээ авсан байна. Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк, АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн дэмжлэгээр Монголын Засгийн газар 2000 оны долдугаар сард ХААН Банкныг дахин хөрөнгөжүүлсэн юм. Банкныг эрүүлжүүлэх хөтөлбөр амжилттай болж, салбарын сүлжээний давуу чанар, хөдөө орон нутаг дахь санхүүгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, шинэ зээлийн хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж, сайн үр дүн үзүүлсэн юм.

Улмаар олон улсын банк, санхүүгийн түршлагатай менежерүүд ХААН Банкныг удирдаж эхэлснээр банкны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд оновчтой менежмент явуулж, санхүүгийн хувьд найдвартай, тогтвортой, үр ашигтай банк болгох, мөн хувьчлалд бэлтгэх ажлыг амжилттай удирдаж зохион байгуулсан юм. Үүний үр дүнд 2003 онд олон улсын тендер зарлаж, ХААН Банкныг хувьчилсан түүхтэй. Тухайн үед банкны 100 хувийн хувьцааг Япон улс дахь “Савада Холдингс” (Sawada Holdings) компани эзэмшиж байсан бөгөөд хожим нь “Таван Богд Трейд” (Tavan Bogd Trade) ХХК-д нийт хувьцааныхаа 40 хувийг худалдсан байдаг. Ингэснээр 2006 онд банк нэрээ өөрчлөн “ХААН Банк” ХХК болсон юм.

### Шинэ хөгжлийн үе эхэллээ

ХААН Банк хөгжлийн явцдаа ийн унаж босож, урагш тэмүүлсээр бидний өнөөгийн мэддэг Монгол Улсын хамгийн том банк гэдэг нэршлийг бий болгоод байгаа юм. Тус банк одоо дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, дэвшилтэт технологийн үр шимийг хүртэх бодлогыг стратеги төлөвлөлтдөө суулгаж, улмаар улс орны хөгжлийг хурдасгах санхүүгийн нөлөөг өргөжин хөгжүүлэхийн төлөө ажилласаар байна.

Банкны салбарын реформын хүрээнд тус банк 2023 онд олон нийтэд нээлттэй болсон. Энэ бол

**ХААН Банк  
271 тэрбум  
төгрөгийн  
ногдол ашиг  
тарааж,  
иргэдэд өндөр  
ашиг хүртэх  
боломжийг  
олгов**

**ХААН Банкны  
нийт актив  
17.3 их наяд  
төгрөгт хүрээ**

▶ ХААН Банкны дараагийн хөгжлийн шинэ үе эхэлж буйг харуулна. ХААН Банк иргэдийн найдвартай түнш байсан бол одоо олон нийтэд нээлттэй, ашиг орлогоо хуваалцдаг хувьцаат компани болоод байна. Нээлттэй хувьцаат компани болсноор өөрийн хөрөнгийн хэмжээ хоёр их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ 400 тэрбум төгрөг болжээ. Тодруулбал, эдийн засгийн хувьд үр ашигтай, тогтвортой хөгжлийг дэмжсэн, улс орон, нийгэмд хэрэгтэй бизнесийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх чадвартай болсон гэсэн үг.

ХААН Банк 271 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан бөгөөд ногдол ашгийн өгөөж нь 11.8 хувьтай байсан нь компаниудын дундаж өгөөжөөс 6.6 нэгж хувиар илүү байна. Энгийнээр бол иргэдэд өндөр ногдол ашиг хүртэх боломжийг ХААН Банк олгов. Өөрийн харилцдаг банкныхаа ашгаас өгөөж хүртэнэ гэдэг мэдээж иргэдийн хувьд тааламжтай үйл явдал билээ.

Өдгөө ХААН Банк Монгол орны хэмжээнд 545 салбар нэгж, 6500 гаруй ажилтантай, хамгийн өргөн цахим сүлжээ бүхий системийг байгуулаад байна. Монгол Улсын нийт айл өрхийн 82 хувьд буюу 2.9 сая харилцагчид санхүүгийн ухаалаг, цогц үйлчилгээг хамгийн шуурхай хүргэж байна. ХААН Банкны нийт актив 17.3 их наяд, зээлийн багц 9.7 их наяд, татан төвлөрүүлсэн хөрөнгө 15.0 их наяд төгрөгт хүрсэн нь нийт банкны системийн хэмжээнд тэргүүлсэн хамгийн дээд үзүүлэлт юм.

Мобайл банк үйлчилгээг 2007 онд зах зээлд анхлан нэвтрүүлснээс хойш Монголын банк санхүүгийн салбарт тасралтгүй хувьсал хийж, банкны бүх цахим сүлжээг нэгтгэсэн Омни-суваг платформыг нэвтрүүлээ.

## **Тогтвортой хөгжлийн бодлогоо баталлаа**

ХААН Банк сүүлийн жилүүдэд ногоон хөгжлийн төлөөх бодлогоо маш хурдтай хэрэгжүүлж байна. Дэлхийн хүн төрөлхтний тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, Даян дэлхийн гэрээнд нэгдсэн. 2020 онд банкныхаа Тогтвортой хөгжлийн бодлогыг батлан мөрдөж эхэлсэн төдийгүй бизнесийн үйл ажиллагаа, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлтийг тогтвортой хөгжлийн

зорилгуудтай нийцүүлэн ажиллаж байна. Энэ ч үүднээсээ ХААН Банк 2022 онд санхүүгийн аяллын алхам бүрд нь харилцагчидтайгаа эгнэгт хамт өсөж хөгждөг, итгэл төгөлдөр банк байхаа илэрхийлж брэндийн шинэчлэл хийн, цоо шинэ Алсын хараа, Эрхэм зорилго, Уриа үг, Үнэт зүйлсээ танилцуулсан юм.

Өнгөрсөн онд ХААН Банк олон улсын хөрөнгө оруулагчдаас нийт 270 сая гаруй ам.долларын санхүүжилт босгосноостогтвортой санхүүжилтийн хүрээнд нийт 95 сая ам.долларын санхүүжилтийг тусгайлан сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй болон байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг дэмжихэд зарцуулжээ. Үүний томоохон хэсгийг олон улсын хөрөнгийн зах зээлд Монгол Улсаас анх удаагаа гаргасан 60 сая ам долларын ногоон бонд болон дотоодын хөрөнгийн зах зээлээс босгосон 17 тэрбумын ногоон бондын эх үүсвэрүүд бүрдүүлж байгаа юм.


ХААН Банк улс орны нийгэм соёлын хөгжилд эерэг нөлөө үзүүлэгч байхыг эрхэмлэсээр ирсэн. 14 жилийн өмнө байгуулсан ХААН Банк сангаараа дамжуулж боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, орон нутгийн хөгжил, байгаль орчны хамгаалал, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлээр 510 гаруй төсөл хэрэгжүүлж, 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

ХААН Банкны тогтвортой өсөлт, санхүүгийн үзүүлэлт, бизнесийн салбарт шинээр түршиж буй төсөл хөтөлбөрүүд, банкны салбарт цахимаар түүчээлж буй амжилтыг дотоодын төдийгүй олон улсын байгууллагууд өндрөөр үнэлдэг. Тухайлбал, олон улсын “The Banker” сэтгүүлээс “Монгол Улсын шилдэг банк”-аар 9 удаа, “Euro-money” сэтгүүлээс “Монгол Улсын шилдэг банк”-аар 13 удаа, “Asiamoney” сэтгүүлээс “Монгол Улсын шилдэг банк” шагналыг зургаан жил дараалан хүртсэн цорын ганц банк болсон бол дотоодод Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас тодруулдаг “ТОП-100 аж ахуйн нэгж”-д тогтмол эхний дөрөвт жагсаж ирсэн бол 2023 онд хоёрдугаар байранд эрэмбэлэгдсэн юм.

ХААН Банк энэ байр сууриа хадгалж, хамтын өсөлтийг ямагт дэмжсэн, банк санхүүгийн үйлчилгээг хамгийн найдвартай, түргэн шуурхай хүргэхээр урагш хурдалсаар байна. ■



## ХААН Банкны хөгжлийн он цагийн хэлхээ



## Голомт банк

Дэлхийн жишиг  
ГОЛОМТ БАНК

Голомт банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 59 тоот тушаалаар 1995 оны гуравдугаар сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа дөрвөн хүний бүрэлдэхүүнтэйгээр 436 сая төгрөгийн дүрмийн сантайгаар эхлүүлж байсан билээ. Өдгөө банкны системийн 20 хувийг дангаараа бүрдүүлэн харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн иж бүрэн үйлчилгээг эх орныхоо хөгжлийн голомт байх эрхэм зорилготой 2500 гаруй ажилтнаас бүрдсэн мэргэжлийн баг, хамт олон орон даяарх 100 гаруй салбар, нэгжээрээ дамжуулан өндөр түвшинд үзүүлж байна.

“Сайн сайхныг санхүүжүүлнэ” уриатай Голомт банк нь төр засгаас үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсээр ирснийг онцлон тэмдэглэе. Голомт банкны хамт олон Монгол Улсын хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн бүтээн байгуулалтуудыг сүндэрлүүлэхэд гар бие оролцож ирсэн бүтээгч хамт олон билээ. Байгуулагдсан цагаасаа эхлэн улсынхаа эдийн засгийн хөгжлийн түүхийн салшгүй нэг хэсэг нь байж, улсын хэмжээнд хөгжил дэвшил авчрах, эдийн засгийг солонгоруулахад хувь нэмэр оруулж буй хүсэл тэмүүлэлтэй, ёс зүйтэй, шилдэг бизнесүүдийг санхүүжүүлж, байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг тасралтгүй дэмжин ажилласаар байна. Энэхүү үзэл баримтлалынхаа хүрээнд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилгад нэгдэж, Монгол Улсаа төлөөлөн “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч анхны банк болсноор өөрийн үйл ажиллагааг “Тогтвортой хөгжлийн зорилтууд” болон “Парисын гэрээний үүр амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтууд”-тай үялдуулахаа тунхагласан юм. Ингэхдээ банк Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд зээлийн үйл ажиллагаандаа тогтвортой санхүүжилтийн зарчмыг баримтлахаас гадна банкны бусад бүхий л үйл ажиллагаанд НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ыг тусган байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлыг хэрэгжүүлэн



**Голомт банк  
олон улсын  
зах зээл  
дээрээс 300 сая  
ам.долларын  
бондыг  
амжилттай  
босгож чадав**

ажиллаж байна.

Түүнчлэн байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бэлтгэн нийлүүлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан Тогтвортой хөгжлийн тухай сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

Дэлхийн жишиг Монголын банк болох Голомт банкны алсын хараа нь зөвхөн бизнесийн үйл ажиллагаагаар хязгаарлагдалгүй засаглалын тогтолцоогоороо ч салбартаа тэргүүлэн зөв жишгийг нийгэмдээ үлгэрлэж, дэлхийн улс орнуудын шилдэг туршлагыг хэрэгжүүлэн үлгэр дуурайл үзүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсад анх удаа “Дотоод аудитын мэргэжлийн практик олон улсын стандарт, ёс зүйн кодтой бүрэн нийцсэн” үнэлгээг авсан нь Монголын банк, санхүү болон Дотоод аудитын салбарын хөгжлийн түүхэнд нэгэн шинэ хуудас эргүүлснийг онцлох нь зүйтэй. Эдгээр нь банкны сайн засаглал, тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого үр дүнгээ өгч буйн илрэл юм.

## Анхдагч банк

Голомт банк нь Монголын банкны салбарт технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмын шинэчлэл, хөгжүүлэлтийг тогтмол хийж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгон инновац шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлж, цаашдын хөгжлийг тодорхойлсоор ирсэн нь бусдаас ялгарах хамгийн том давуу тал юм. Монгол Улсад банкны салбар үүсэж, хөгжсөн нэгэн зууны түүхэнд “Олон улсын төлбөрийн картын систем”-ийг 1999 онд, “Интернэт банк” үйлчилгээг 2002 онд, “Смарт банк” үйлчилгээг 2012 онд, “СошиалПэй” дижитал хэтэвчийг 2017 онд тус тус Монгол Улсад анхлан нэвтрүүлсэн нь салбартаа төдийгүй дотоодын зах зээлд шинээр олон дэвшлийг авчирч, “Анхдагч” гэх алдрын титмийг олонтоо хүртсэн юм. ►

## НЭЭЛТТЭЙ БАНК

Орчин цагийн банк, санхүүгийн салбарын шинэ өнгө төрхийг тодорхойлон технологи суурьтай Нээлттэй банкны бизнес загварыг үйл ажиллагаандаа цогцоор нь нэвтрүүлж, бизнесийн байгууллага, төрийн байгууллага, технологийн болон финтек компаниудтай дижитал шилжилт, инновацад тулгуурлан нээлттэй хамтран ажиллаж, хуримтлуулсан туршлага, олж авсан мэдлэг, бүтээсэн дэд бүтцээ харилцагчидтайгаа хуваалцах замаар шинэ үнэ цэн бүтээж, иргэдийн амьдрал, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулдаг нээлттэй банк байхаар зорин ажиллаж байна.

2022 онд Голомт банкны хувьд хөгжлийнхөө дараагийн шатанд гарч, түүхийн шинэ хуудсыг эргүүлэн олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд тухайн жилдээ Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн том дүнтэй IPO болон хамгийн богино хугацаанд 114.4 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн гэх хоёр том амжилтыг бичин үлдээсэн юм.

2024 онд анх удаа Голомт банк олон улсын зах зээл дээрээс 300 сая ам.долларын бондыг амжилттай босгож, арав гаруй жил тасраад байсан Монголын арилжааны банкуудын олон улсын зах зээл дэх санхүүжилтийн үйл ажиллагааг дахин сэргээснээр салбартаа тодоор бичигдэх томоохон амжилтыг бүтээгээд байна. Энэхүү үйл явдал нь 2012 оноос хойш Монголын арилжааны банкуудаас олон улсын зах зээл дээр бие даан бонд босгож буй анхны тохиолдол болсон юм.

## Монгол Улсын шилдэг банк

**The Banker**  
GLOBAL FINANCIAL INTELLIGENCE SINCE 1926

**GLOBAL FINANCE**

**EUROMONEY**



Өдгөө Голомт банк нь олон улсад танигдсан нэр хүндтэй, салбартаа тэргүүлэгч байр суурьтай, арвин туршлагатай, итгэлтэй найдвартай банк болон төлөвшиж, харилцагчдаа үзүүлж буй үйлчилгээ, хэрэгжүүлж буй бүхий л санаачилга, шийдлүүд нь Монгол Улсын төр болон бизнесийн салбарт шилдэг туршлага болж жишиг тогтоон үнэ цэнийг бүтээж, олон улсын нэр хүндтэй, томоохон банкуудтай эн зэрэгцэхүйц эрэмблэгддэг. Дэлхийн жишиг Монголын банк байх алсын хараагаа эрхэмлэн банк, санхүүгийн салбартаа тэргүүлэгч байж, эрхэм харилцагч, түнш, хувьцаа эзэмшигчид хамтрагчдынхаа хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд бүрэн нийцсэн банк, санхүүгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэн сайжруулж, хамгийн сайн засаглалын тогтолцоо, нээлттэй, ил тод байдлаа бэхжүүлэн ажиллаж байна. ■

## Зах зээлд эзлэх байр суурь \2023 он\

Нийт хөрөнгийн зах зээлд эзлэх хувь:  
19.4%-с 20.1%-д хүрч өсөв



Нийт зээлийн зах зээлд эзлэх хувь: 17.3%-с 17.5%-д хүрч өсөв



Харилцагчийн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь: 18.4%-с 20.0%-д хүрч өсөв

Арилжааны хэмжээ  
**29%**

Онлайн худалдааны гүйлгээний тоо, дүн  
**69%, 45%**  
Q3 2023 байдлаар

Кастодиан банк  
**45%**

Орон сууцны зээл  
**24%**

Кредит карт  
**48%**

Аккредитивын хэмжээгээр  
**69%**

Эх сурвалж: Монголбанкны статистик ашиглав



## ХАСБАНК

# Сайн засаглалыг түүчээлэгч ХасБанк

1998 онд бичил бизнесийг дэмжих зорилгоор НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “МикроСтарт” төсөл Монголд хэрэгжиж, Монгол Улсад анхны банк бүс санхүүгийн байгууллага Хөгжлийн Алтан Сан нэртэйгээр 1999 онд байгуулагдаж байсан нь одоогийн ХасБанкны эхлэл болсон билээ.

Улмаар 2001 онд “Говийн эхлэл” ББСБ-тай нэгдэн, мөн оныхоо арванхоёрдугаар сарын 27-нд арилжааны банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө Монголбанкнаас авчээ.

Банк бүс санхүүгийн байгууллагаас банкны хэмжээнд ажиллаж эхэлсэн ХасБанкны түүхийн жим Монгол Улсын банкны салбарын хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан юм. ХасБанк Монголын банкны салбарын зах зээлд шинэ өнгө төрх, шинэ алсын хараатайгаар орж ирж байлаа. Тавьсан зорилго, хүрэхийг хүссэн алсын хараа нь тухайн үедээ яг л шинэ дэвшилтэт технологи бүхий компанитай агаар нэг сонсогдож, олон нийтийн сонирхлыг ихээхэн татаж байсан юм.

“Эх дэлхий, эрдэнэт хүмүүн, эрүүл ашиг”. Энэ гурван тулгуур үг нь алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлдог. Эх дэлхийдээ ээлтэй үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдийг онцгойлон дэмжиж, эрдэнэт хүмүүн болсон харилцагч нартаа ил тод, нээлттэй, амар хялбар, хэрэгцээт үйлчилгээг үзүүлж, үнэт зүйл, зарчимдаа нийцсэн эрүүл ашгийг эрхэмлэдэг гэсэн агуулгыг илэрхийлдэг.

Тус банк энэхүү алсын хараа, эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагаа явуулж, банкны салбарыг шинэ өнцгөөс харахад томоохон хувь нэмэр оруулсан гэж хэлж болно. Учир нь эх дэлхийдээ ээлтэй үйл ажиллагаа явуулна гэдэг ойлголт 20 гаруй жилийн өмнө тааруухан байсан цаг үе. Монгол Улсын хувьд ногоон, тогтвортой хөгжлийн тухай ярихад хэтэрхий эртдэх байсан тийм л он жилүүдэд ХасБанк энэ хаалгыг нээж, эхлүүлж, өөрсдөө түүчээлэн орж ирсэн билээ.

Харин өнөөдөр тогтвортой, ногоон, эх дэлхийдээ ээлтэй ажиллаж амьдрах, бизнес

**ХасБанк ногоон санхүүгийн ойлголт, механизмыг салбартаа анхлан нэвтрүүлж, түүчээлэн хөгжүүлсээр байна**



эрхлэх нь бидний үүрэг болчихоод байна. Тиймээс ирээдүйг урьдчилан харж, стратеги төлөвлөлтөө энэ чиглэлд хандуулж, тулгарах саад бэрхшээл хүндхэн байсан ч анхны зарчимдаа тууштай явсаар ирсэн ХасБанкны түүх бол Монголын банкны салбарын 100 жилийн хөгжлийн нэгэн том өнгө байсан гэж хэлэх бүрэн үндэстэй.

Анх төслөөс долоон ажилтан, нэг сая ам.долларын хөрөнгөтэй эхэлж байсан ХасБанк өдгөө таван их наяд төгрөгийн активтай, Монголын системийн дөрвөн том банкны нэг болж, 70 гаруй салбар нэгж, 1300 мэргэшсэн ажилтан, 9000 гаруй мерчант, цахим сувгуудаараа дамжуулан нэг сая гаруй харилцагчдаа банкны үйлчилгээг тасралтгүй, найдвартай үзүүлж байна.

Тэдний энэ тогтвортой өсөлтийг товчхондоо сайн засаглал, санхүүгийн хүртээмж хэмээн томьёолжболно. Анхбайгуулагдахдаа санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдмал иргэд, бичил бизнесүүдэд хүрч үйлчлэх зорилго тавьж байсан ХасБанк өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд энэ философио орхиогүй төдийгүй улам бататган, бичлээс жижиг, жижгээ дунд, дундаас том болгон өргөжүүлж, харилцагчтайгаа хамт өсөн дэвшиж иржээ. Тэд бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээл олгоод зогсохгүй төрөл бүрийн сургалт, өдөрлөг, хөтөлбөрүүдээр улам чадавхжуулж, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлж, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулсаар ирсэн. Тус банкны нэг онцлог бол хямд өртөгтэй санхүүжилтийн гүүр болж ажилласан туршлага нь юм. Тэд өнгөрсөн 20 жилийн хугацаанд нийт 1.5 тэрбум орчим ам.доллар буюу одоогийн ханшаар 4.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг Монголд оруулж ирсэн ▶



► байна. Эдгээр хямд өртөгтэй санхүүжилт нь бичил, болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бага хүүтэй, барьцааны хөнгөлөлттэй зээл болон ажлын байр нэмэгдүүлэх, худалдан авалтыг сайжруулах зэргээр нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмрээ оруулсаар байна.

ХасБанк анхнаасаа бодлого зорилт, сэгмэнтээ зөв харж тодорхойлон сайн засаглалыг эрхэмлэн банкны салбарт үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь өнөөгийн тогтвортой, хүртээмжтэй, өсөлтийг авчирсан. Байгуулагдсан цагаасаа хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд нэг хүн эсвэл байгууллага давамгайлаагүй хамгийн зөв бүтэц, хамгийн сайн засаглалтай банк байж ирсэн. Монголын алт корпораци (МАК), Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Канадын үндэсний банк, Орикс корпораци тэргүүтэй дотоод, гадаадын нэр хүндтэй олон хөрөнгө оруулагчидтай. Эндээс ХасБанк ганц, хоёр хүний эзэмшлийн бүс олон хүн, байгууллага, хөрөнгө оруулагчдын хамтын эзэмшлийн учраас үйл ажиллагаа нь тогтвортой өсч, харилцагч үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг сайтар олсоор ирсэн нь харагдана.

Банкны тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу ХасБанк 2023 онд амжилттай IPO хийж, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор өмнө нь зөвхөн харилцагч байсан 10 мянга гаруй иргэн мөн ажилтнууд нь ч банкныхаа хувьцаа эзэмшигч болсон шинэ түүхийг тэд бичээд явж байна.

Түүнчлэн Монголын анхны ногоон тодотголтой эко банк. ХасБанк ногоон санхүүгийн ойлголт, механизмыг салбартаа анхлан нэвтрүүлж,

**ХасБанкны гурван тулгуур үг “Эх дэлхий, эрдэнэт хүмүүн, эрүүл ашиг”**

түүчээлэн хөгжүүлсээр байгаа билээ. Олон улсын санхүүгийн зах зээлд ч Монголын ногоон банк гэдгээрээ хэдийнэ танигдсан. 2007 онд НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдэж, байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрүүл ухаалаг хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэхээ заралж, харин байгаль орчинд хор хөнөөлтэй бизнесийг санхүүжүүлэхгүй байх бодлогыг баримталж буйгаа олон нийтэд эко банкны үйл ажиллагаагаар харуулж ирсэн юм. Мөн ХасБанк НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC)-ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг сааруулахад зориулж хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад олгох санхүүжилтийн гол механизм болох Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар 2016 онд магадлан итгэмжлэгдсэн Монгол Улсын анхны арилжааны банк төдийгүй хөгжиж буй орнууд дунд УАНС-аас магадлан итгэмжлэл авсан анхны хувийн хэвшлийн байгууллага болж байв. УАНС-аас магадлан итгэмжлэлийг таван жилийн хугацаатай олгодог ба 2022 онд Уур Амьсгалын Ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар хоёр дахь удаагаа дахин магадлан итгэмжлэгдэв.

Цаашлаад эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг сурталчлан таниулж, хэрэглэгч нийлүүлэгчдийг холбон, аль алийг нь санхүүжүүлж ирсэн тэдний хүчин чармайлт өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийт 2.5 сая тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж чаджээ. Зүйрлэвэл энэ нь 183 сая ширхэг мод тарьж, 10 жилийн түрш үргүүлсантай дүйцэх үр дүн буюу нэг га-д 300 ширхэг мод тарьсан гэвэл 183 сая ширхэг мод нь Улаанбаатар хотоос 1.6 дахин том газрыг бүрхэх бөгөөд үүний цаана байгаль орчинд ээлтэй хэрэглээ, ногоон бизнесийн эерэг хандлага, зөв сэтгэлгээг маш олон хүмүүсийн зүрх сэтгэлд суулгаж чадсан нь түүнээс ч илүү амжилт юм.

ХасБанк цаашид ч харилцагч төвтэй үйлчилгээгээ эрхэмлэн, харилцагчаа хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж, банкны үйлчилгээг нийгэм, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр үзүүлж, бодит эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх замаар иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт хувь нэмэр оруулах бодлого, зарчмаа баримтлан батжуулж ажиллах нь тодорхой юм. ■



## Төрийн банк

# Ө.ГАНТӨР: Төрийн банкийг Дундаж давхаргыг дэмжигч үндэсний тэргүүлэгч банк гэж тодорхойлсон

*Монгол Улсад орчин цагийн банк үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Төрийн банкны Гүйцэтгэх захирал Ө.Гантөртэй ярилцлаа.*

-Монгол Улсад банк үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохиож байна. 100 жил гэдэг багагүй хугацаа. Таны хувьд банкны ялангуяа Монголбанканд олон жил ажилласан туршлагатай. Та сэтгэгдлээ хуваалцана уу?

-Юун түрүүнд танай сэтгүүлийг уншигчид болон Монголын банкны салбарт ажиллаж байсан үе үеийн төлөөлөл, одоо ажиллаж буй мянга мянган банкирууддаа Монгол Улсад банкны тогтолцоо үүсэж бэхжсэний түүхт 100 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

Миний хувьд анх 1996 онд арилжааны банканд мэргэжилтэн, 1999 онд Монголбанкны Хяналт шалгалтын газарт хянан шалгагчаар орсноор Монголбанк хэмээх том айлын хаалгыг татан орж банкны салбарт хөл тавьж байлаа. Монгол Улсын банкны системийн тогтвортой байдлыг хангахын төлөө Монголбанкны нэгээхэн хэсэг нь болж 17 жилийн турш ажилласандаа туйлын баяртай байдаг. Энэ хугацаанд Банкны тухай хууль тогтоомж, Төрийн мөнгөний бодлого, Монголбанкны гаргасан дүрэм, журам, шийдвэр, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тогтоох болон арилжааны банкуудын үйл ажиллагааг тогтвортой явуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд ажилласан.

Цаашлаад Төрийн банкны удирдлагаар ажиллах хугацаандаа харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн



**Төрийн банк  
Ковид цар  
тахлын үед 25  
мянга орчим  
ажлын байр  
хадгалахад  
бодит хувь  
нэмрээ  
оруулсан**

санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэж ажиллахыг зорьж байна. Банкны дунд болон урт хугацааны стратеги, бизнес зорилгыг оновчтой тодорхойлох, банкны санхүүгийн үзүүлэлт, Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах, банкны зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх, зээлийн багцыг оновчтой удирдах, чанаргүй активыг бууруулах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ►



► ажиллуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлд анхаарал хандуулан ажилласаар байна.

**-Төрийн банкны хувьд Төрийн төлөөллийн ганц банк. Энэ жил 15 жилийн ойгоо тэмдэглэж байгаа. Энэхүү түүхийн он жилүүдэд Төрийн банкны улс орны хөгжил, эдийн засагт гүйцэтгэсэн үүрэг, хувь нэмрийг Та хэрхэн дүгнэж ярих вэ?**

-Төрийн банк анх харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, банкны системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 2009 онд үүсгэн байгуулагдаж байсан. Банк үүсгэн байгуулагдахдаа 174 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй, 28 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа эхэлж байв. Улмаар 2013 оны долоодугаар сараас 21 аймаг, сум, дүүргүүдэд салбар нэгжтэй болж, үндэсний хэмжээний банк болсон.

Төрийн банкны алсын харааг 2022 онд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Дундаж давхаргыг дэмжигч үндэсний тэргүүлэгч банк гэж тодорхойлсон. Энэ ажлын хүрээнд цогц төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ нь Төрийн банкны бизнесийн зорилгод нийцэж байгаа юм. Тухайлбал, нийт харилцагчдын 90 гаруй хувь, нийт зээлдэгчдийн 80 хувь нь иргэд байдаг. Энэ утгаараа Төрийн банк бол иргэдийн банк юм.

Төрийн банк нь 2024 оны I улирлын байдлаар 4.9 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, 599.5 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Банкны салбар нь улс эх орны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулан хуулийн өмнө хүлээсэн үүргээ чандлан биелүүлж, татвараа цаг тухайд нь төлөх, ажлын байрыг бий болгох, Тогтвортой хөгжилд манлайлах, нийгмийн хариуцлагын ажлыг хэрэгжүүлж түүхээлэн ажилладаг. Тэр дундаа манай банк өөрийн нийт харилцагч, ажилтан албан хаагчдын хамтаар үйл ажиллагааныхаа чиглэлд суурилан олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, Тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, дундаж давхаргыг дэмжих зорилгоор хадгаламж, зээл, картын бүтээгдэхүүнийхээ нөхцөлийг тогтмол сайжруулан ажиллаж, “Гялс цэвэрлэгээ”, “Модыг Мода болгоё” зэрэг байгальд ээлтэй аяныг орон

**Нийт харилцагчдын 90 гаруй хувь, нийт зээлдэгчдийн 80 хувь нь иргэд байдаг. Энэ утгаараа Төрийн банк бол иргэдийн банк юм.**

даяар зохион байгуулсаар ирлээ.

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Төрийн банк олон нийтэд нээлттэй банк болсон.

Мөн Төрийн банк үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 15 жилийн туршид нийгэм эдийн засагт томоохон хувь нэмэр оруулан Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж, татвараа цаг тухай бүрд нь төлж, үнэн зөвөөр тайлагнасаар ирсэн байдаг. Өнгөрсөн онд 32.4 тэрбум гаруй төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн. Банкны салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг том зургаар нь харвал, эдийн засаг, нийгэм, байгаль орчны бүхий л салбарт манлайлал үзүүлэн олон улсын санал, санаачилгад нэгдэн дэлхий дахинаа хөл нийлүүлэн алхах боломжийг цогцоор нь олгодог гэдгээрээ онцлогтой.

**-Төр Төрийн банк байгуулсны нэг гол үр дүнгээ Ковид-19 цар тахлын үед харсан гэж ярьдаг. Энэ хүнд цаг үед Төрийн банк хэрхэн яаж ажилласан түршлагаасаа ярина уу? Засгийн газраас эдийн засгаа сэргээхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Төрийн банкны оролцоо юу байсан бэ?**

-Дэлхий дахинаа 2020-2022 онд “Ковид-19” вирус цар тахлын хэмжээнд хүрч, бид олон сорилттой нүүр тулгаран, эрүүл мэндийн болоод эдийн засгийн хувьд хохирол багатай даван гарах үүрэг хүлээсэн үе бидэнд тохиосон. Цар тахлаас үүдсэн онцгой нөхцөл байдлын үед УИХ, Засгийн Газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж эхэлсэн. Энэ төлөвлөгөөнд тусгагдсан Ажлын байрыг дэмжих зээл, Хөдөө аж ахуйг дэмжих зээл, Орон сууцны ипотекийн зээл, Репо арилжааны санхүүжилттэй зээлүүдийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон бөгөөд Төрийн банк манлайлан оролцсон.

Үүний үр дүнд нийт 18 мянган иргэн, аж ахуйн нэгжид 700 гаруй тэрбум төгрөгийн зээл олгож, улсын хэмжээнд 175 мянган ажлын байрыг авч үлдсэнээс Төрийн банк 25 мянга орчим ажлын байрыг хадгалахад бодит хувь нэмрээ оруулсан байдаг. Үүнээс гадна манай ►

► хамт олон цар тахлын үед бусад байгууллага банкуудаа манлайлан ажиллаж банкны үйлчилгээг халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажилласан. Тухайн үед хүмүүс янз бүрээр хүлээн авч байсан ч энэ нь оносон шийдвэр байсан. Тийм ч учраас УИХ-ын дарга индэр дээрээсээ Төрийн банкны хэрэгжүүлсэн туршлагыг сайшаан бусад банк үлгэр жишээ авч ажиллахыг үүрэг болгож байлаа. Ингэж манай хамт олон банкны салбар нэгжийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой үргэлжлүүлж цар тахлыг амжилттай давж гарсныг дурсахад таатай байна.

**-Төрийн банк Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг тогтмол дэмжин ажилладаг. Барилгын салбарыг дэмжих орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийг 2013 оноос хойш олгож эхэлсэн. Энэ ажил ямар явцтай байгаа вэ?**

-Төрийн банк нь Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг тогтмол дэмжин Засгийн газар иргэд хоорондын эдийн засгийн харилцааны гүүр нь болж ажилласаар ирсэн. Энэ ч утгаараа 2013 оноос “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Ипотекийн зээлийг олгож байна. Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газраас эрүүл мэнд, боловсрол, орон сууцны чиглэлээр ашиглагдах Хуримтлалын сангийн дансыг Монголбанканд нээж, тус санд төвлөрүүлсэн эх үүсвэрээс орон сууцны хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах болсноор иргэд, харилцагчдын хүсэлтийг шийдвэрлэх боломж бүрдээд байна.

Төрийн банк 2024 он гарснаас хойш Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 1,550 иргэнд 196.5 тэрбум төгрөгийн Ипотекийн зээл олгосон. Цаашид төвлөрлийг бууруулах, дундаж орлоготой иргэдийг дэмжих зорилтын хүрээнд орон нутагт түлхүү эх үүсвэр олгох зорилт тавьсан ажиллаж байна.

**-“Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна”**

**Төрийн банк  
500 нэгж  
салбартай,  
4,000 гаруй  
ажилтантай,  
2.3 сая  
харилцагчтай  
системийн  
нөлөө бүхий  
банкны нэг  
болжээ**

гэж хуульд заасны дагуу системийн нөлөө бүхий банкууд хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан. Төрийн банк хувьцаа гаргах ажлыг тун амжилттай хэрэгжүүлж байгаа. Үр дүн, ач холбогдол нь ямар байгаа вэ?

-Төрийн банк 2022 онд системийн нөлөө бүхий банкуудаа манлайлан олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгаа гурав дахин давуулан биелүүлж, 25.4 тэрбум төгрөгийг босгож чадсан. Ингэснээр Төрийн банкны нийт хувьцааны 5.71 хувийг 7,421 хувьцаа эзэмшигч эзэмших болсон билээ. Энэ бол Төрийн банкны ажилтан, албан хаагчдын ажилд өгсөн үнэлгээ, итгэлийн хэмжээ болсон гэж бид хүлээн авсан. Банкны салбар бол ил тод байдал, итгэлцлийн огтлол дээр оршдог бизнес бөгөөд 2023 онд “Төрийн банк” ХК нь 94.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, сүүлийн гурван жилд нийт активаа дунджаар 15.9 хувиар нэмэгдүүлж санхүүгийн үзүүлэлтүүд маань жилээс жилд өсөлттэй гарч байгаа нь хамгийн том бодитой үр дүн юм.

**-Дижитал цахим банк болох тал дээр хэрхэн ажиллаж байгаа вэ? Дэлхий нийт цаасгүй технологи, иргэд, олон нийтэд хялбар бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах болсон байна.**

-Орчин үед бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж иргэд харилцагчдын цаг завьг хэмнэхийн зэрэгцээ цаас, шатахууны зарцуулалтыг багасгах олон давуу талыг бий болгодог болсон. Төрийн банк ч мөн цахим үйлчилгээний цогц шийдэл бүхий орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан Гялсбанк үйлчилгээний шинэчлэгдсэн 3.0 хувилбарыг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна. Энэхүү үйлчилгээ нь вэб хуудас, смарт аппликейшн, мобайл суваг, мессеж суваг гэсэн дөрвөн төрлийн цахим үйлчилгээг нэгтгэснээрээ онцлогтой. Гялсбанк 3.0 үйлчилгээгээр банкны бүх төрлийн санхүүгийн үйлчилгээг зайнаас авах, төлбөр тооцоогоо түргэн шуурхай гүйцэтгэх цахимаар зээл авах боломжийг бүрдүүлж өгсөн. Бид банкны бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах, хурдан шуурхай бөгөөд хүртээмжтэй хүргэх чиглэлд анхаарал хандуулан тасралтгүй ►

► хөгжүүлэлт, шинэчлэлтүүдийг хийсээр байна.

**-Төрийн банк тогтвортой, ногоон хөгжилд хөл нийлүүлэн алхах үүднээс энэ чиглэлд тодорхой бодлого, стратеги баримталж ажиллахаар тусгай газар, хэлтэс байгуулан ажиллаж байгаа. Тогтвортой хөгжилд баримтлах стратеги төлөвлөгөө юу байна вэ?**

-2015 оноос ТоС хөтөлбөр болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд элсэж байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэхээс эхлэн Тогтвортой хөгжлийн 17 зорилтод үйл ажиллагаагаа нийцүүлэн, хувь нэмрээ оруулан ажиллаж байна. 2015 онд “Байгаль орчин, нийгмийн бодлого, журам”-аа батлуулан хэрэгжүүлсэн бөгөөд тасралтгүй сайжруулж, 2022 онд “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-ын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх холбогдох журам, зааврыг шинэчлэн баталснаар Тогтвортой хөгжлийн төлөө банкны үйл ажиллагааг чиглүүлэхэд нэг алхам урагшилсан.

Мөн “Тогтвортой хөгжлийн хороо” болон “Тогтвортой хөгжлийн алба”-г шинээр байгуулж үйл ажиллагааг банкны бүхий л түвшинд хэрэгжүүлэх зорилго бүхий Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн, чиглэл тус бүрд анхааран ажиллаж байна. Төрийн банкны Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого нь Олон улсын болон Монгол Улсын Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглалын талаарх бодлогын

**Төрийн банк  
Ажлын байрыг  
дэмжих зээл,  
Хөдөө аж ахуйг  
дэмжих зээл,  
Орон сууцны  
ипотекийн  
зээл, Репо  
арилжааны  
санхүүжилттэй  
зээлүүдийг  
арилжааны  
банкуудаар  
дамжуулан  
олгоход  
манлайлан  
оролцсон**

бичиг баримтуудтай уялдаж гарсан. Банк урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дэмжих, зохистой засаглалын тогтолцоог хангах Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүний хувьд 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлээд байна.

**-Хүний нөөцийн бодлогын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, цаашдын бодлого төлөвлөгөөний талаар уншигчидтай хуваалцана уу?**

-Банкны зүгээс ажилтнууддаа хандсан нийгмийн баталгааны бодлогыг тогтмол хэрэгжүүлэн цалин, хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулах, тогтвор суурьшилтай ажилласны болон гүйцэтгэлийн үр дүнд суурилсан нэмэгдэл цалин, урамшуулал олгож бодит дэмжлэг үзүүлдэг. Мөн ажилтны сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндэд чиглэсэн хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж байна.

Төрийн банкны амжилтын гол хөдөлгөгч хүч болсон ажилтнуудын ард 10 мянга гаруй гэр бүлийн гишүүд байдаг. Банкны зүгээс 2024 онд хүний нөөцийн удирдлага болон хөгжлийн шинэ чиг хандлагыг эрэлхийлж, банкны урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжилд хувь нэмэр оруулах хүний нөөцийн бодлогын шинэчлэл хийж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлсны нэг нь “Гэр бүлд ээлтэй банк” байх бодлогыг дэвшүүлсэн явдал юм. Дэлхий даяар хөдөлмөр эрхлэлтийн чиг хандлага хурдацтай өөрчлөгдөж байна. Энэ өөрчлөлттэй уялдуулан ажилтандаа ээлтэй уян хатан ажлын байрны бодлогыг хэрэгжүүлж, зайнаас, гэрээсээ бүтэн, бүтэн бус цагаар ажиллах, хүүхэд асрах чөлөө авсан ажилтныг богиносгосон цагаар ажиллах зэрэг боломжоор хангасан.

Дэлхий дахинаа цахим шилжилт эрчимтэй өрнөж буйтай холбоотой банкны газар, нэгжийн ажилтнууд шинэ технологийн дэвшлийг ашиглан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран ажиллах, банкны ажилтнуудын хөдөлмөрийн хүчин зүйлсийг хөнгөвчлөх, боломжит ажил үүргийг цахимжуулах, хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх ажил судалгааны түвшинд явж байна. ■





## Капитрон банк

# Шинэ эриний үнэ цэнийг бүтээгч Капитрон банк

**М**онголын банкны салбарт шинэлэг салхи сэвэлзүүлсэн банк бол Капитрон. Капитрончууд дэвшилтэд технологид суурилсан интернэт банк, телефон банк болон мессеж банкны үйлчилгээг анхлан нэвтрүүлж, эрч хүчтэй, шинэлэг дүр төрхийг бүтээж ирсэн түүхтэй. Тэдний эхлэл 2001 онтой холбогдоно. Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, гурван тэрбум төгрөгийн дүрмийн сан, 17 ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байв. Үүсэн байгуулагдсан цагаасаа Монгол Улсын банк, санхүүгийн системд тогтвортой өсөлтийг бий болгож, “Шинэ эриний үнэ цэнийг бүтээнэ” гэсэн алсын хараагаа эрхэмлэн ажиллаж иржээ.

Өдгөө Капитрон банк Улаанбаатар хот болон орон нутгийн томоохон зургаан аймгийн 40 гаруй салбар, нийт 600 гаруй мэргэшсэн, чадварлаг ажилтнаараа дамжуулан харилцагчдадаа банк, санхүүгийн цогц үйлчилгээг найдвартай, шуурхай хүргэж байна.

Тус банкны санхүүгийн үзүүлэлт жил бүр тогтмол өсч, банкны системд эзлэх байр сууриа тэлсээр. Өнөөдрийн байдлаар нийт активаа 2.3 их наяд төгрөгт, дүрмийн сангаа 100 тэрбум төгрөгт хүргэж, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байна. Иргэд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан бизнесийн болон хэрэглээний зээл, орон сууцны зээл, бүх төрлийн гадаад, дотоод төлбөр тооцоо, харилцах, хадгаламж, төлбөрийн карт, цахим банк, даатгалын зүүчлал зэрэг санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг харилцагчдадаа найдвартай, шуурхай хүргэсээр байгаа юм.

Монгол Улсын банк санхүүгийн салбар дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхсаар ирсэн. Тэр тусмаа тус салбар шинэ дэвшилтэд технологийг хамгийн түрүүнд нэвтрүүлдэг учраас санхүүгийн хүртээмж, дижиталчлал, төлбөр тооцооны үр ашигтай байдал гэх мэт олон талаар бусад улсаас



**Moody's  
агентлагийн  
зээлжих  
зэрэглэлийн  
“ВЗ” үнэлгээг  
таван жил  
дараалан  
хангасан**

дутахгүй гэдгийг бардам хэлэх байна. Улс орон даяар цахимд эрчимтэй шилжиж байсан үе буюу 2005 онд Капитрон банкны төв удирдлага, орон нутгийн бүх салбар, нэгжүүд онлайн сүлжээнд бүрэн шилжсэн байдаг. Мөн 2006 онд Интер банкныг худалдан авсан нь Монгол Улсын банкны салбарын түүхэнд хоёр банк сайн дураараа нэгдсэн анхны нэгдэл болж, тэмдэглэгдсэн билээ.

Капитрон банк 2012 онд үндэсний ₮ брэнд төгрөгийн карт гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас авч, өөрийн нэрийн төгрөгийн ▶

► картыг зах зээлд анхлан нэвтрүүлж байв. Түүнчлэн 2013 онд бэлэн бус төлбөрийн VISA International картын системд гишүүнээр элссэнээр Капитрон банкны харилцагчид VISA карт ашиглаж эхлэв. 2019 онд нэвтрүүлсэн дансны мэдээллээ олон нийтэд болон зорилтод бүлгийн этгээдэд ил тод харуулах боломжтой “Шилэн данс” үйлчилгээ нь нийгмийн болон бусдын төлөө өрнүүлж буй сайн үйлсийн аян, хандив зэрэгт ихээхэн ашиглагдаж, харилцагчдын талархлыг хүлээгээд буй.

Капитрон банк улс орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэр төртэйгээр биелүүлж, татвараа цаг хугацаанд нь төлж, улсын төсвийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна. Түүнчлэн банкныхаа 600 гаруй ажилтныг тогтвортой ажлын байраар хангаж, ажилтнуудынхаа нийгмийн асуудалд тогтмол анхаарч иржээ. Тухайлбал, ажилтнууддаа орон сууцны, цалингийн хөнгөлөлттэй зээл санал болгохоос гадна амьдралд тохиолдох баяр гүнигтай гэнэтийн асуудалд зориулсан бүх төрлийн тэтгэмж, урамшууллын тогтолцоо, уян хатан ажлын цаг, сурч хөгжихөд нь зориулсан дотоод гадаад сургалтууд болон тэтгэлгийн системийг бий болгосон байдаг. Энэ нь ажилтнаар дамжуулан тухайн гэр бүл, цаашлаад улс орны хөгжилд хувь нэмэр оруулж буйн сайн жишээ юм.

Капитрон банкны тогтмол өсөж буй санхүүгийн үзүүлэлтүүд, 23 жилийн тогтвортой үйл ажиллагаа, дэвшилтэд технологид суурилсан дижитал үйлчилгээнүүд, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн манлайлал, улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр зэргийг үнэлэн Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас хамтран тодруулдаг ТОП-100 аж ахуйн нэгжээр сүүлийн долоон жилийн турш дараалан шалгаруулав. Түүнчлэн Капитрон банк олон улсын үнэлгээний Moody’s агентлагаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийлгэж, “B3” үнэлгээг таван жил дараалан хангасан байна.

### **Капитрон банкны ноу-хау “Хурд”, “Хариуцлага”, “Зогсолтгүй хөгжил”, “Зориулсан үйлчилгээ”**

Капитрон банк 2015-2016 онд хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд томоохон

**“Шилэн данс”  
үйлчилгээ нь  
харилцагчдын  
талархлыг  
хүлээгээд  
байна**

өөрчлөлт хийж, компанийн засаглалын тогтолцоог улам сайжруулах, банкны бүтэц, зохион байгуулалт, удирдлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, улмаар банкны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлд шат дараалсан өөрчлөлт, шинэчлэлийг амжилттай хийсэн нь өнөөдрийн амжилттай банкныг бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Капитрон Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТОС)-ны гишүүн банк бөгөөд 2019 онд "Тогтвортой санхүүжилтийн бодлого"-оо баталж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг банкны гадаад, дотоод үйл ажиллагаандаа шингээн, ногоон хөгжлийг дэмжих чиглэлд идэвхийлэн ажиллаж ирсэн.

Тогтвортой хөгжлийг дэмжих гадаад зорилтын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулж буй хувь хүмүүс, бизнесүүдээ дэмжин ногоон бизнес болон хэрэглээний зээл олгох;

Ус их хэрэглэдэг үйл ажиллагаатай бизнесүүдэд чиглэсэн цэвэр усны хэрэглээг хэмнэх, дахин ашиглах тоног төхөөрөмж худалдан авах боломжтой саарал усны тоног төхөөрөмжийн зээлийг тус тус олгож байна.

Дотоод үйл ажиллагааны хүрээнд байгууллагын зохистой засаглалыг бэхжүүлэх, жендэр болон тэгш эрхийг эрхэмлэхийн сацуу цаас, ус, эрчим хүчний хэрэглээг хэмнэж байгальд ээлтэй ажлын таатай орчин бүрдүүлэн "Тогтвортой Хөгжлийн 17 зорилго"-д нийцүүлэн ажиллаж байгаа юм.

Өөрчлөлт, шинэчлэлийн үр дүнд Капитрон банк өнөөдөр тогтвортой хөгжлийг дэмжих, байгаль орчноо хамгаалах, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр тэргүүлэгчдийн нэг болоод байна.

Капитрон банк харилцагчдадаа бүх төрлийн санхүүгийн үйлчилгээг найдвартай, түргэн, шуурхай хүргэхийг зорьж, түүнийгээ ч банкныхаа үнэт зүйл болгон түнхагласан байдаг. Тодруулбал, “Хурд”, “Хариуцлага”, “Зогсолтгүй хөгжил”, “Зориулсан үйлчилгээ” гэсэн дөрвөн үнэт зүйлст Капитрон банкны баримтлан ажилладаг ноу-хау агуулагддаг. Капитрон банк харилцагчаа дээдэлсэн, найдвартай, шуурхай, найрсаг үйлчилгээтэй банк байхыг зорин ирээдүй рүү тэмүүлж байна. ■



## Банкны тогтолцооны хөгжил гэрэл зурагт



1924 он: Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банкны байгуулах комиссын гишүүн А.Амар, Э.Ринчино болон удирдах албаны хүмүүс, орос зөвлөхүүдийн хамт.



1934 он: Яармаг дахь баяр наадмын талбайд Монголбанкны байгуулсан үзэсгэлэнгийн павильон.



1940-өөд он: Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банкны ажилтнууд.



1982 он: Улсын банкны Ерөнхий хорооны дарга Г.Хүдэрчулуун банкны ажилтнуудын хамт.



1991 он: БНМАУ-ын Төв банкны Ерөнхийлөгч Н.Жаргалсайхан ажилтнуудын хамт.



1991 он: БНМАУ нь ОУВС, Дэлхийн банкны гишүүн орноор элсэв.





1990 он: Улсын банкны Ерөнхий хорооны гадаад тооцооны газрын үйлчилгээний танхим.



2017 он: Мөнгө тоологч. Уг машин нь мөнгөн дэвсгэртүүдийг сайн, муу, хүчингүйгээр нь ялган тоолж, хуурамч дэвсгэртийг таньж илрүүлдэг.



2024.06.02 Монгол Улсад Монголбанк үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан "Банк-100" үзэсгэлэн нээгдэв.



2017.06.13: Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ аяны хүрээнд хүүхдүүдэд үндэсний мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын элементийг танилцуулав.



2024.06.02 Монгол Улсад орчин цагийн банк үүсэн бэхэжсэний 100 жилийн ойд зориулсан "Банк-100" үзэсгэлэнгийн үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн арилжааны банкуудын удирдлагуудын хамт.



2004 он: Монгол Улсын Эрдэнэсийн сангийн хосгүй үнэт үзмэрүүдийг нийтэд нээлттэйгээр үзүүлж эхлэв.